

# ХАМТАРСАН БАГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЛОЛТ, АМЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

“МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ  
БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ЭЦСИЙН СУДАЛГАА

# 2018



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Save the Children

# ХАМТАРСАН БАГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЛОЛТ, АМЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

“МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ  
БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ЭЦСИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот  
2018 оны 3 дугаар сар

ЖАЙКА Олон улсын байгууллагын санхүүжилтээр Хүүхдийг Ивээх Сангаас  
2015- 2018 онд хэрэгжүүлсэн “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог  
бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулав.

Багийн ахлагч

Г.Түмэннаст, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, доктор

Багийн гишүүд

Т.Бүрэнжаргал, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, доктор, дэд профессор

Н.Болдмаа, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш, доктор, дэд профессор

М.Батбаатар, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, доктор

Ц.Одгэрэл, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн докторант

Д.Оюунцэцэг, МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш

С.Түмэндэлгэр, МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, доктор, дэд профессор

*“Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төв”-ийн судлаачид талбарын мэдээлэл цуглуулах ажлыг хамтран  
гүйцэтгэв.*

Удиртгал	5
Судалгааны аргазүй	7
Бүлэг 1. Хамтарсан багийн бодлого ба удирдлага, зохион байгуулалт	10
1.1 Хамтарсан багийн бодлогын орчин	10
1.2 Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт	17
Бүлэг 2. Хамтарсан багийн гишүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдлэг, ур чадвар	23
2.1. Хамтарсан багийн гишүүдэд зориулсан сургалтын үр нөлөө	24
2.2. Хамтарсан багийн гишүүдэд зориулсан арга зүйн дэмжлэг, туслалцаа	25
2.3. Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын өөрчлөлт	27
Бүлэг 3. Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээ	30
3.1 Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл хүлээж авах	30
3.2 Хамтарсан багийн кейс бүртгэл	34
3.3 Хамтарсан багийн үйлчилгээ	40
Бүлэг 4. Хамтарсан багийн олон нийтэд хандсан үйл ажиллагаа	52
4.1 Зорилтот орон нутгийн эцэг эхчүүдэд зориулсан хүмүүжлийн эерэг аргын сургалтын үр дүн	55
4.2 Хүүхэд хамгааллын талаарх хүүхдүүдийн ойлголт, мэдлэг, хандлага	62
4.3 Хамтарсан багаас олон нийтэд зориулсан өдөрлөг, аян	68
4.4 Хүүхэд хамгааллын асуудлаар хамтарсан багт хандах, хамтран ажиллах туршлага	71
Бүлэг 5. Хамтарсан багийн үйлчилгээг сайжруулах нь:	
Судалгааны дүгнэлт, зөвлөмж	77
5.1. Бодлогын төвшинд	77
5.2. Орон нутгийн төвшинд	80
5.3. Хамтарсан багийн төвшинд	82
5.3.1. Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын хүрээнд	82
5.3.2. Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд	83
5.3.3. Хамтарсан багаас олон нийтэд хандсан үйл ажиллагааны хүрээнд	84

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

---

БГД - Баянгол дүүрэг

БЗД - Баянзүрх дүүрэг

ГБХЗХГ - Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар

ГБХЗХХ - Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Хэлтэс

ОУБ - Олон улсын байгууллага

СХД - Сонгинохайрхан дүүрэг

ТББ - Төрийн бус байгууллага

ХИС - Хүүхдийг Ивээх Сан

ХНХЯ - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХУД - Хан-Уул дүүрэг

ЧД - Чингэлтэй дүүрэг

## УДИРТГАЛ

---

Хүүхдийг Ивээх Сан (ХИС)-гаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ)-тай хамтран 2015 оны 5 сараас эхлэн 3 жилийн хугацаатай “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлсэн билээ. Аливаа төслийг хэрэгжүүлэх үйл явцад зорилтот бүлэг, олон нийт (орон нутаг), нийгэмд үзүүлж буй үр нөлөөг анхааран судлах шаардлагатай бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ нь төслийн удирдлагын салшгүй бүрдэл хэсэг юм. Дээрх төслийг хэрэгжүүлж эхлэх үе шатанд хамтарсан багийн нөхцөл байдлыг тодорхойлж байсан бол төсөл хэрэгжиж дуусах энэ мөчид хамтарсан багийн үйл ажиллагаа хийгээд үйлчилгээнд төслийн зүгээс үзүүлсэн үр дүн, үр нөлөөг үнэлэх зайлшгүй шаардлага бий болсон юм.

ХИС-гаас төслийн суурь судалгаа буюу хэрэгцээний үнэлгээг 2015 онд явуулсан бөгөөд төслийн зорилтот (Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 6 хороо болон Архангай аймгийн 3 сум/баг) болон хяналтын зорилгоор сонгон авсан орон нутгууд дахь хамтарсан багийн талаар оролцогч талуудын дунд тоон болон чанарын судалгааны аргаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн юм. Харин эцсийн үнэлгээг өмнө нь хийгдсэн суурь судалгааны арга зүйд тулгуурлан хийсэн бөгөөд төслийн гарааны үеийн суурь үзүүлэлтүүдийг төсөл дуусах үед хүрсэн төвшний үзүүлэлтүүдтэй харьцуулан хийснээрээ онцлог юм.

Энэхүү төслийн эцсийн судалгааг 2018 оны 1-3 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд нэг талаас төсөл хэрэгжсэнээр хүүхэд хамгааллын тогтолцоонд, тэр дундаа хамтарсан багийн үйлчилгээнд бий болсон үр нөлөөг тодорхойлсны дээр нөгөө талаас үндэсний болон орон нутгийн төвшинд цаашид хийгдэх шаардлагатай үйл ажиллагааны чиглэл, алхмуудыг тодорхойлж, хамтарсан багийг бэхжүүлэх, өнөөгийн үйлчилгээг чанаржуулахад шаардлагатай шинэ хэрэгцээг танин мэдсэн билээ. Төсөл хэрэгжүүлж дуусах энэ шатанд төслийн хэрэгжилт болон хамтарсан багийн үйлчилгээ, үйлчлүүлэгч, оролцогч талууд, олон нийтэд (орон нутагт) үзүүлсэн үр нөлөө, үр дүн, тэдгээрт холбогдох сургамжуудыг тодорхойлсон бөгөөд ингэснээрээ цаашид төслийн үйл ажиллагаа, үр дүнг түгээн дэлгэрүүлэх боломж бүрдэх юм.



## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Төсөлд хамрагдсан нийслэлийн болон аймгийн засаг захиргааны анхан шатны нэгжүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж болон үйлчлүүлэгч, оролцогч талууд, олон нийтэд гарсан үр нөлөө, үр дүн, хамтарсан багийн ололт, амжилт, сургамжийг тодорхойлж, цаашид хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн улс орон, орон нутаг, хамтарсан багийн түвшинд хамаарах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулахад төслийн эцсийн судалгааны зорилго оршино.



### СУДАЛГААНЫ ЗОРИЛГОД ХҮРЭХИЙН ТУЛД ДАРААХ ЗОРИЛТЫГ ТАВИВ. ҮҮНД:


- Хүүхэд хамгааллын бодлогын орчны өөрчлөлт болон түүнд төслийн үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох;
- Хамтарсан багийн гишүүдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, ур чадварын өөрчлөлтийг тодорхойлох;
- Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээнд гарсан өөрчлөлт, төслийн зүгээс үзүүлсэн үр нөлөөг тодорхойлох;
- Хамтарсан багийн үйл ажиллагааны талаарх оролцогч талууд (хүүхдүүд, иргэд, хүүхэд хамгааллын ажилтнууд гэх мэт)-ын ойлголт, мэдлэг, хандлагын өөрчлөлтийг судлах;
- Хамтарсан багийн үйлчилгээг цаашид хөгжүүлэх бусад асуудал, санал зөвлөмжийг боловсруулах;



## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Төслийн эцсийн үнэлгээ нь 2015 онд хийсэн төслийн суурь судалгааны үзүүлэлтүүдийг өнөөгийн хүрсэн түвшинтэй харьцуулж, өөрчлөлт, үр нөлөөг хэмжихэд чиглэж байгаа тул 2015 онд хэрэглэсэн судалгааны аргазүй, түүвэрлэлт, дүн шинжилгээний аргуудад тулгуурлан явагдсан юм. Үнэлгээг хийхдээ тоон болон чанарын судалгааны аргазүй ашигласан бөгөөд төслийг хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс төслийн зорилго, зорилт, гарцад суурилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдээр тэдгээрийн хүрээнд бий болсон өөрчлөлтийг тодорхойлсон билээ.

### СУДАЛГААНЫ АРГАЗҮЙН ЗУРАГЛАЛ







## МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГУУД

Эцсийн үнэлгээний мэдээллийг цуглуулахдаа хоёрдогч баримт бичгийн шинжилгээ болон анхдагч мэдээлэл цуглуулах тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн. Үүнд:



### БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

2015-2017 онуудад төсөл хэрэгжих хугацаанд боловсруулсан баримт бичиг, материал, төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны болон үнэлгээ, мониторингийн тайлан, дүрэм журам, холбогдох бусад баримт бичигт дүн шинжилгээ хийв.



### ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

Хамтарсан багийн гишүүд, хүүхэд хамгааллын ажилтнууд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хөтөлбөрийн ажилтнуудыг хамруулсан болно. Хамтарсан багийн өнөөгийн үйлчилгээ, түүнд гарсан өөрчлөлтүүд, тулгарч буй бэрхшээл болон цаашдын сургамжийн талаар мэдээлэл цуглуулсан.



### АСУУЛГА

Хамтарсан багийн талаарх эцэг эх болон хүүхдийн мэдлэг, ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулах зорилгоор ашигласан болно.



## СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### ХАМРАХ ХҮРЭЭ

Дээр дурдсанчлан эцсийн судалгааг 2015 онд хийгдсэн суурь судалгаатай харьцуулах зорилгоор хийж байгаа учраас түүврийн хамрах хүрээ, төлөөллийг баримжаалан түүнтэй ижил төстэй байдлаар төлөвлөсөн юм. Судалгааг гүйцэтгэх ажлын даалгаварт зааснаар төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багуудын хүрээнд буюу Улаанбаатар хотын 3 дүүргийн 12 хороо, Архангай аймгийн төвийн 2 баг болон 4 суманд судалгааны мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийв.

## ТҮҮВЭР

2015 онд явуулсан гарааны үнэлгээгээр зорилтот бүлгийг түүврийн, хяналтын бүлгийг энгийн санамсаргүй түүврийн аргад тулгуурлан түүврийн зүй тогтол, арга техникийг сонгосон. Энэ удаагийн судалгаанд мөн адил түүвэрлэлтийн загварыг санал болгож байна.

## СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ТАЛБАР БОЛОН БҮЛГЭЭР

Талбарын нэр	Хороо/ баг/сум	Хамтарсан багийн гишүүд		Эцэг, эх	Хүүхэд
		Хороо, сум, багийн түвшинд	Хэлтсийн түвшинд		
<b>Улаанбаатар:</b> Төсөлд хамрагдсан хороод: БЗД 23, 27-р хороод, ЧД 9,10-р хороод, СХД 2, 10-р хороод	6 хороо	12	4	36	30
<b>Улаанбаатар:</b> Хяналтын бүлгээр сонгогдсон хороод: БЗД 7, 16-р хороод, ЧД-ийн 7, 12, СХД-ийн 13, 20-р хороод	6 хороо	12		36	30
<b>Архангай аймаг:</b> Төсөлд хамрагдсан сум/баг: Эрдэнэбулган сум (аймгийн төв) 4-р баг, Батцэнгэл сум, Хайрхан сум	1 баг 2 сум	9	3	18	15
<b>Архангай аймаг:</b> Хяналтын бүлгээр сонгогдсон сум /баг: Эрдэнэбулган сум (аймгийн төв) 1-р баг, Ихтамир сум, Өндөр-Улаан сум	1 баг 2 сум	9		18	15
<b>Нийт</b>	<b>18</b>	<b>42</b>	<b>7</b>	<b>108</b>	<b>90</b>



### МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Асуулгын аргаар цуглуулсан мэдээллийг боловсруулахад SPSS-22.0 программыг ашигласан ба ганцаарчилсан ярилцлага болон баримт бичгийн шинжилгээний хүрээнд цуглуулсан мэдээллийг бүлэглэлт, харьцуулсан жишилт, хэв маягчлал, ангилал, матриц зэрэг чанарын шинжилгээний аргачлалыг ашиглав. Нотолгоо болох баримтуудыг тоон давтамж, хувийн жин, харьцаа, оноор харьцуулсан хүснэгт, график, матриц, категори, ишлэл зэргээр тайланд тусгалаа.

# ХАМТАРСАН БАГИЙН БОДЛОГО БА УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 1.1 ХАМТАРСАН БАГИЙН БОДЛОГЫН ОРЧИН

ХИС-гийн “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл хэрэгжиж эхлэх үед хийгдсэн “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” хэмээх суурь судалгааны хүрээнд хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалтын асуудлыг, тухайлбал хамтарсан багийн бүтэц тогтолцоо, салбар дундын зохицуулалт, хамтарсан багийн бүрэлдэхүүн, удирдлагын үйл ажиллагаа зэргийг авч үзсэн билээ. Харин энэ удаагийн судалгаагаар тухайн үеэс хойш бүтэц тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтын дээрх асуудлууд хэрхэн өөрчлөгдсөн талаар тодорхойлох юм. Юуны өмнө бодлогын өөрчлөлтийг судалсан ба ингэхдээ дараах хоёр асуудалд анхаарлаа хандууллаа. Үүнд:

**1**

Хамтарсан багийн бодлогын орчинд бий болсон чухал өөрчлөлтүүд болон тэдгээрт төслийн үзүүлсэн нөлөө





**2**

Дээрх бодлогын орчны хэрэгжилт болон түүнд төслийн үзүүлсэн нөлөө

Юуны өмнө төсөл хэрэгжиж эхлэхийн өмнөх үеийн хүүхэд хамгааллын тогтолцооны нөхцөл байдлыг өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулан авч үзэх хэрэгтэй юм. Өмнөх суурь судалгааны тайлангаас харвал Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх чухал дэд бүтэц болсон хамтарсан багийн талаар ямар ч зохицуулалт байхгүй байжээ.<sup>1</sup> Тухайн үеэс хойш хүүхэд хамгааллын эрхзүйн орчинд ихээхэн өөрчлөлт гарсан юм.

<sup>1</sup> ХАХНХЯ, ЖАЙКА, Японы Хүүхдийг Ивээх Сан. “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” судалгааны тайлан УБ., (2015) 11 дүгээр тал

**Хүснэгт 1.1.1 Хамтарсан багийн бодлогын орчинд гарсан өөрчлөлт**

	Төсөл хэрэгжиж эхлэх үеийн бодлогын орчин (2015)	Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үеийн бодлогын орчин (2015-2018)
 <b>ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ</b>	2016 оноос өмнө Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль үйлчилж байсан бөгөөд хамтарсан багийн талаар зохицуулалт байгаагүй.	Хүүхдийн эрхийн үндсэн зарчим, төрөл, хүүхдийн эрхийг хангахад эцэг эх, асран хамгаалагчийн болон бусад талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон.
 <b>ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ</b>	2016 оноос өмнө Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль үйлчилж байсан бөгөөд хамтарсан багийн талаар зохицуулалт байгаагүй.	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний хүрээнд мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад хамтарсан багийн оролцоо болон хамтарсан багийн ажил үйлчилгээг тодорхойлж, хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа, хамтарсан багийн санхүүжилт зэргийг шийдвэрлэсэн байна.
 <b>ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ</b>	2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсан бөгөөд үүнээс өмнө хамтарсан багийн талаар хуульзүйн ямар нэг зохицуулалт байгаагүй.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “хамтарсан баг”-ийг болон түүний чиг үүргийг тодорхойлсон байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцооны хүрээнд оролцогч талуудын хамтарсан багийн талаарх чиг үүргийг тодорхойлжээ. Үүнд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо болон захиргаа багтжээ. Мөн дээрх үзэгдлийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээнд хамтарсан багийн хүрээн дэх нийгмийн ажилтны үүргийг тодорхойлсон байна.
 <b>ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР</b>	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр 2002-2010 онд хэрэгжиж дууссан байв.	Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршихыг тодорхойлсон байна.

Төсөл хэрэгжиж эхлэх үетэй харьцуулахад хүүхэд хамгааллын бодлогод хэд хэдэн чухал дэвшил гарсан байна. Нэгдүгээрт, хүүхдийн эрх болон хүүхэд хамгааллын асуудлаар хуулиуд батлагдан гарснаар нийгмийн суурь харилцаа болон хүүхэд хамгаалах үйл явцыг тусгаарлан зохицуулсан эрхзүйн орчин бүрджээ. Хоёрдугаарт, “хамтарсан баг”-ийг хуулийн хүрээнд тодорхойлсноор эрхзүйн статустай болсон байна. Гуравдугаарт, хүүхэд хамгааллын тогтолцоонд хамтарсан багийн чиг үүрэг тодорхойлогджээ. Түүнчлэн, 2017 оны 9 дүгээр сарын 20-нд Монгол Улсын Засгийн газрын 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг баталсан нь бодлогын төвшинд чухал өөрчлөлт юм.

Ийнхүү хамтарсан багаар ажиллах эрх зүйн орчин бүрдсэнээр цаашид түүний хэрэгжилтийг хангахын тулд хамтарсан багийн үйл ажиллагааг удирдамжаар хангах асуудал чухал болж ирсэн байна. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсанаас хойш хамтарсан багийн үйл ажиллагаанд шууд холбогдох дүрэм журмуудыг боловсруулах үйл явц эрчимжсэн байна. Дээрх хугацаанд хүүхэд хамгаалал, тэр дундаа хамтарсан багийн үйл ажиллагаанд (үйлчилгээнд) хамаарах 17 журам, 1 дүрэм, 1 стандарт батлагдан гарчээ.



**Хүснэгт 1.1.2** Хүүхэд хамгааллын тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах журмууд

Журмууд	Батлагдсан огноо
➤ Хамтарсан багийн ажиллах журам	2016.12.26
➤ Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам	2016.12.26
➤ Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм	2016.12.26
➤ Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах журам	2016.12.26
➤ Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам	2017.01.31
➤ Хүүхдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх журам	2017.02.06
➤ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам	2017.02.09
➤ Аюулын зэргийн үнэлгээний журам	2017.02.14
➤ Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам	2017.02.14
➤ Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам	2017.02.14
➤ Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам	2017.02.23
➤ Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам	2017.03.13
➤ Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын журам	2017.03.22
➤ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам	2017.03.27
➤ Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам	2017.04.04
➤ Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам	2017.04.06
➤ Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам	2017.04.06
➤ Нөхцөл байдлын үнэлгээний журам	2017.07.04
➤ Хүүхдийн асрамжийн хувилбарт үйлчилгээний стандарт	2017.12.

Дээр дурдсан эрхзүйн орчныг бүрдүүлэхэд ХИС-гийн “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн болон төслийн ажилтнуудын оролцоо үлэмж их байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ оролцоо нь нэг талаас үйл явцын буюу төслийн багийн зүгээс зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ, нөгөө талаас агуулгын буюу хууль эрхзүйн баримт

бичгүүдийг боловсруулах гэсэн хоёр чиглэлээр биеллээ олсон нь харагдаж байна. Төслийн хугацаанд төслийн багаас бодлого боловсруулах, шийдвэр гаргах төвшинд нөлөөллийн олон удаагийн арга хэмжээг хэрэгжүүлж иржээ. Төслийн зүгээс хэрэгжүүлсэн нөлөөллийн арга хэмжээг а) бодлого боловсруулах үйл явцад буюу түүний бүтэц, зохион байгуулалтын хүрээнд, б) олон нийтэд хандсан гэсэн хоёр чиглэлээр авч үзэж болно.

### Хүснэгт 1.1.3 ХИС-гийн хөтөлбөрийн зүгээс бодлогын хөгжилд оруулсан хувь нэмэр

 <p><b>БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хүүхэд хамгааллын хуулийг боловсруулах ажлын хэсэгт ажилласан</li> <li>➤ Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ажилласан</li> <li>➤ Журмуудын төсөл боловсруулахад хувь нэмэр оруулсан (маягтууд болон аргачлалууд)</li> </ul>
 <p><b>БҮТЭЦ, ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай салбар дундын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төлөөлөл багтсан</li> <li>➤ Хүүхдийн хөгжил хамгааллын байнгын ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцсон</li> </ul>

Ярилцлага судалгаанд хамрагдсан хөтөлбөрийн болон төрийн албан хаагчдын ярианаас үзэхэд ХИС-гийн хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зүгээс хүүхэд хамгааллын холбогдох хуулиудыг боловсруулах үйл явцад идэвхтэй оролцсон бөгөөд хүүхэд хамгааллын үзэл баримтлал болон түүнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлоход, түүнчлэн хүүхдийн эсрэг бүхий л төрлийн хүчирхийллийг нийгмийн бүх орчинд таслан зогсоох ёстой гэсэн үзэл санааг бүх оролцогч талуудад ойлгуулахад анхаарч ирсэн байна. Түүнчлэн хүүхдийн эсрэг хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? хэрэв хүүхэд түүнд өртсөн бол ямар үйлчилгээ үзүүлэх вэ? үүнд хамтарсан багийн гүйцэтгэх үүрэг юу байх вэ? гэх зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээний аргагүй болон механизмын талаар хууль боловсруулагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд дээрх байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй хөтөлбөр үлэмж нөлөөлсөн гэжээ. Эндээс үзэхэд ХИС нь “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийг боловсруулах үе шатанд хуулийн үзэл баримтлалыг боловсруулах, хуулийн төслийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тэр дундаа хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулах удирдамж болсон дүрэм журмуудыг боловсруулах ажилд ХИС-гийн төслийн оруулсан хувь нэмрийг онцгойлон тэмдэглэх хэрэгтэй. Дээрх журмуудаар батлагдсан хүүхэд хамгааллын болон хамтарсан багийн үйл ажиллагааны гол маягтууд болон тэдгээрийг хэрэглэх аргачлалуудыг төслийн хүрээнд боловсруулжээ. Тухайлбал, хүүхэд хамгаалалд

холбогдох 5 журмын хүрээнд батлагдсан маягтууд болон аргачлалууд нь үндсэндээ “Монгол улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулсан маягт, аргачлалд суурилсан байна. Хүүхэд хамгаалалд холбогдох журмын төслийг боловсруулах хэд хэдэн ажлын хэсгүүдэд хөтөлбөрийн ажилтнууд орж ажилласан ба зарим журмын хувьд хөтөлбөрийн ажилтнууд санал өгсөн байна.

Бодлого боловсруулах үйл явцаас гадна үндэсний хэмжээний бүтэц тогтолцооны төвшинд ХИС-гийн хөтөлбөрийн ажилтнуудын болон төслийн оролцоо их байсан юм. ГБХЗХГ-ын даргын тушаалаар тус агентлагийн дэд даргаар ахлуулсан “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн удирдах зөвлөл байгуулагдсан бөгөөд энэ нь бодлогын оролцогч талуудад төслийн талаарх мэдээллийг жигд хүртээх, төслийн үйл ажиллагааг бодлогын төвшинд уялдуулахад чухал үүрэгтэй байв. Энэхүү зөвлөлд ХИС-гийн хөтөлбөрийн ажилтнууд, нийслэл болон дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (ГБХЗХХ)-ийн дарга нар, төрийн бус байгууллагын төлөөлөл багтсан байдаг. Мөн ХНХЯ-ны сайдын 2017 оны 12 сарын 19-ний өдрийн А 218 тоот тушаалаар “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай салбар дундын ажлын хэсэг” байгуулагдсан бөгөөд түүнд ХИС-гийн ажилтнууд олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөр ажилласан юм. ХНХЯ-наас уг ажлын хэсгийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулах, мөн онд батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах уулзалтыг 2017 оны 12 сарын 21-нд зохион байгуулжээ. Уулзалтаар хүүхдийн асуудлаар голлон үүрэг гүйцэтгэх яамд, тухайлбал Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам, Хуульзүй, дотоод хэргийн яамны төлөөлөл болон хүүхдийн асуудалд шууд хамааралгүй боловч иргэдийн амьдралын чанарт шууд нөлөө үзүүлдэг бусад яам, агентлагууд болон Нийслэлийн засаг даргын тамгын газрын төлөөлөл болж буй ажлын хэсгийн гишүүдэд хандсан зөвлөмжийг боловсруулж хүргүүлсэн байна. Уг ажлын хэсгээс 2018 оны төлөвлөгөөг нийтлэг ажил, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, хүүхдийн хамгаалал зэрэг дэд хэсгүүдээр дэвшүүлсэн байна. Мөн төслийн зүгээс “Хүүхдийн хөгжил, хамгааллын байнгын ажлын хэсэг”-ийн 2018 оны төлөвлөгөөг боловсруулахад оролцсон билээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд бодлого боловсруулах төвшинд нөлөөлөхөөс гадна олон нийтэд нөлөөлөх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал, ХИС-гаас хууль болон журмуудыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулснаас жишээ дурдвал 2016 оны 5 дугаар сард хүүхэд хамгааллын маягтуудыг 9 дүүргийн 180 орчим нийгмийн ажилтанд тайлбарлан таниулах уулзалт арга хэмжээг тухайн үеийн нэршлээр Нийслэлийн гэр бүл, хүүхэд хөгжлийн газартай хамтран зохион байгуулжээ. Мөн ХИС-гийн “Хүүхэд хамгааллын аргазүйн төв” нь сүүлийн хоёр жилд нийтдээ 14 удаагийн нөлөөллийн ажлыг хийсэн ба эдгээр арга хэмжээ нь нэвтрүүлэг, мэдээлэл сурталчилгаа, сургалт болон тэмцээн зэрэг хэлбэрүүдээр явагдаж, нийт 30,000 орчим иргэн хамрагдсан байна.<sup>2</sup>

2 ХИС-гийн Хүүхэд хамгааллын арга зүйн төв 2016, 2017 оны үйл ажиллагааны тайлан

Хууль, журмуудын хэрэгжилтийг хангахын тулд хамтарсан багийн гишүүдэд мэргэжил, аргазүйн дэмжлэгийг тогтмол үзүүлэх нь чухал юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12.2.4.-т хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, чиглэл өгөх нь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн чиг үүрэг байхаар тодорхойлсон<sup>3</sup> бол Хүүхэд хамгааллын тухай хуульд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллага нь хамтарсан багийг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах үүрэгтэй болохыг заасан<sup>4</sup> байна. “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ХИС-гаас хүүхэд хамгааллын мэргэжил, аргазүйн үйлчилгээг 2016 онд 382 хүнд, 2017 онд 517 хүнд тус тус үзүүлсэн байна. Тухайлбал, 2016 онд 183 хүнд сургалт, 139 хүнд нээлттэй семинар, 60 хүнд ажлын байран дахь зөвлөгөө, 2017 онд 339 хүнд сургалт, 91 хүнд нээлттэй семинар, 87 хүнд ажлын байран дахь зөвлөгөө өгөх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулжээ.<sup>5</sup> Ярилцлагын үр дүнгээс үзэхэд хүүхэд хамгааллын хууль, журмын хэрэгжилтийг хангах ажилд хөтөлбөрийн үзүүлж буй зэрэг нөлөө маш их бөгөөд төсөл хэрэгжээгүй дүүргүүд, хороодын хамтарсан багийн гишүүд, мэргэжилтнүүдийн ярилцлагаар хууль, бодлого, журмын хэрэгжилтийг хангахад мэргэжил, аргазүйн зөвлөгөө маш чухал байна.

Хэдийгээр Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлогын орчин сүүлийн хоёр жил сайжирч байгаа ч бодлого болон тогтолцооны хүрээнд бодит асуудлууд оршсоор байна. Энэ нь хөтөлбөрийн зүгээс бодлогын орчныг хөгжүүлэхээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулахад нөлөөлсөн байж болох юм.

Хүүхэд хамгааллын асуудлаар бие даасан хуультай болсон нь хамгийн чухал дэвшил байсан ч хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх хамгийн чухал бүтэц болсон хамтарсан багийн талаарх зохицуулалт хангалтгүй хэвээр байна. Тухайлбал, энэ хуульд хамтарсан баг гэж юу болох, түүний чиг үүрэг ямар байх тухай зохицуулалтууд байхгүй байна. Өнөөгийн нөхцөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон хүүхэд хамгааллын үйл ажиллагаа нь хариуцах бүтэц, тогтолцооны хувьд хоёрдмол байдалтай гэж болно. Гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хууль хяналтын салбар, харин хүүхэд хамгааллын асуудлыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хариуцаж буй энэ бүтэц нь хүүхэд хамгааллын төрийн бүтцийг хоёрдмол байдалд хөтөлж болох юм. Түүнчлэн хүүхэд хамгаалалд хамаарах журмын төслүүдийг боловсруулах ажлын хэсгүүд нь өөр хоорондоо уялдаа холбоо муутай байдаг нь ажиглагдсан. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хүрээнд 30 орчим журмыг боловсруулах шаардлагатай ба одоогийн байдлаар 10 орчим журам боловсруулаад байгаа ажлын хэсгүүд нь тус тусдаа ажиллаж байгаа талаар төрийн албан хаагчид ярилцлагын хүрээнд өгүүлж байв. Одоогийн хуулиар хамтарсан баг нь хүүхэд хамгааллын гэхээсээ илүүтэй гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд илүү зориулагдсан бүтэц шиг ойлгогдож байна. Нөгөө талаар, бодлого боловсруулах үйл явцад хууль эрх зүйчид болон хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд, нийгмийн ажилтнуудын хамтын ажиллагаа чухал байж болох юм.

3 [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол Улсын хууль. 2017 он.

4 [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хууль. 2016 он.

5 ХИС-гийн Хүүхэд хамгааллын аргазүйн төв, 2016, 2017 оны үйл ажиллагааны тайлан



Монгол Улсад тогтолцооны бас нэг асуудал тулгарч байгаа нь төрийн эрх мэдлийн бүтцэд гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд хамгааллын асуудлыг хариуцсан зэрэгцсэн хоёр бүтэц оршиж байгаа бөгөөд энэ нь **“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”, “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”** болж байна. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-ийн дэргэд “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл” байдаг. Ярилцлага судалгаанд оролцогчдын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь удаах зөвлөлийг бодвол бодлого, үйл ажиллагаа нь илүү тогтворжсон, эрх мэдлийн бүтцэд илүү байр суурьтай, түүнчлэн төсөв санхүү нь харьцангуй шийдэгдсэн гэж үзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон хүүхэд хамгаалах үйл ажиллагааг тусгаарлан хөгжүүлэх тухай энд өгүүлээгүй билээ. Гагцхүү бүтцийн хоёрдмол байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үзэл баримтлалын доор хүүхэд хамгаалал хэмээх бие даасан үзэл баримтлал бүдгэрэх, алдагдах, түүний эрхзүйн орчин хагас дутуу бүрдэх, хүүхэд хамгааллын төсөв санхүүгийн асуудал орхигдох зэрэг байдал бий болгохыг үгүйсгэхгүй. ХИС-гийн хөтөлбөрийн ажилтнуудын зүгээс Монголд хөгжүүлж ирсэн хүүхэд хамгааллын үзэл баримтлал нь хууль, журмын төслийг хөгжүүлэх үйл явцад зарим талаар алдагдаж ирснийг, хүүхэд гэр бүлийн орчинд хамгаалагдахаас гадна нийгмийн бүхий л орчинд хамгаалагдах ёстойг, хамтарсан багийн үйлчилгээг авах ёстойг ярилцлагын явцад илэрхийлж байв.

Төсөл хэрэгжиж эхлэх үеийн нэг анхаарал татсан нөхцөл байдал бол салбар дундын зохицуулалт байхгүй байсан явдал юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхдийн эрх, хамгааллын асуудалд оролцогч талуудын чиг үүргийг тодорхойлсон байна. Түүнчлэн хамтарсан багийн үйлчилгээнд чухал ач холбогдолтой бүтэц болох салбар дундын ажлын хэсэг байгуулагдсан юм. Гэсэн хэдий ч салбар дундын зохицуулалт нь хамтарсан багийн төвшинд биеллээ олоход асуудал тулгарсаар байна. Бодлого хийгээд бүтцийн төвшинд чухал алхмууд тавигдсан ч орон нутгийн төвшинд хангалтгүй бөгөөд хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгах явдал жигд биш байна.

Дээр дурдсанчлан, бодлогын төвшинд гарсан чухал ололт бол хамтарсан багийн үйлчилгээнд хамаарах зардлыг төсөвт суулгасан явдал боловч орон нутгийн төвшинд түүнийг зориулалтын бусаар зарцуулсан мэдээлэл байна. Энэ нь цаашид хамтарсан багийн төсвийг зориулалтын дагуу зарцуулах асуудлаар журам боловсруулах шаардлага байгааг харуулж байна.

## 1.2 ХАМТАРСАН БАГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төсөл хэрэгжихээс өмнөх суурь судалгаагаар хөдөө орон нутгийн хамтарсан багууд үйл ажиллагаагаа төлөвлөх тал дээр тун тааруухан байжээ (Архангай аймгаас үнэлгээнд оролцсон хамтарсан багуудын 17% нь төлөвлөгөөтэй)<sup>6</sup>. 2015 онд бүх шатны засаг даргын үр дүнгийн гэрээнд “хүүхэд хамгааллын үйлчилгээ”-ний талаар үүрэг хүлээхээр тусгагдсан тул хамтарсан багууд улирал тутам үйл ажиллагаагаа тайлагнахдаа хүүхэдтэй илүү холбоотой үйл ажиллагааг оруулдаг байв<sup>7</sup>. Төслийн үр дүнд нийслэл болон Архангай аймгийн төслийн зорилтот хамтарсан багууд жил, сар, улирлаар үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнадаг болсон бөгөөд төлөвлөлт, тайлагналт байдал сайжирсан болох нь ийнхүү харагдаж байна. Тодруулбал, төсөлд хамрагдсан хамтарсан багуудаас судалгаанд оролцсон гишүүдийн “төлөвлөгөө, тайланг тогтмол гаргаж хэвшсэн” гэх хариултын дундаж үнэлгээ 4.8 байхад хяналтын хамтарсан багийн гишүүдийн дундаж үнэлгээ 3.6 буюу 1.2 оноогоор доогуур байна. Т тестээр<sup>8</sup> дунджийн ялгааг шалгахад энэ нь ( $t=3.74$ ) статистикийн ач холбогдлын төвшинд илэрч байна. Төслийн нэгжээс хамтарсан багуудыг үйл ажиллагааны төлөвлөлт, тайлангийн нэгдсэн загвараар хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн нь тэдгээрийн удирдлага, зохион байгуулалтад эерэг нөлөө үзүүлжээ (Хүснэгт 1.2.2). Энэ нь төслийн суурь судалгааны хүрээнд хамтарсан багийг чадавжуулах үүднээс санал болгосон “... ямар ч нөхцөлд ашиглах боломж бүхий цахим болон олон хувилбарт удирдамж, гарын авлагыг боловсруулан хэрэгжүүлэх” гэсэн зөвлөмжийг<sup>9</sup> төслийн хүрээнд сайн хэрэгжүүлсний үр дүн мөн.

### Шигтгээ 1.2.1 Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт

#### Төслийн зорилтот хамтарсан баг

Хамтарсан багаар тогтмол уулзаж, хуралдаж, хуралдааны тэмдэглэл үйлдэн, үйл ажиллагаагаа жил, улирал, сараар төлөвлөж, тайлагнах зэргээр үйл ажиллагаа тогтворжсон. Үйл ажиллагаагаа төлөвлөх, тайлан боловсруулах тал дээр төслийн нэгжээс дэмжиж ажилласан тул их юм сурсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан ч сайжирсан.

*Архангай аймгийн Хайрхан сумын хамтарсан багийн гишүүний ярианаас*

#### Төслийн хяналтын хамтарсан баг

Бидэнд төлөвлөгөө, тайлан гэж байхгүй. Би ажлаа аваад 6 сар л болж байна.

*Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1-р багийн хамтарсан багийн гишүүний ярианаас*

Дүүргийн ГБХЗХХ-ээс сар бүр тоогоор тайлан гаргахыг шаарддаг тул сар бүр тайлангаа гаргаж ажилладаг.

*ЧД, 7-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас*

6 ХАХНХЯ, ЖАЙКА, Японы Хүүхдийг Ивээх Сан. “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” судалгааны тайлан УБ., (2015) 93 дугаар тал

7 мөн тэнд: 93 дугаар тал

8 Судлагдсан 2 бүлгийн сонирхсон үзүүлэлтээр дунджийн ялгаа статистикийн хувьд ач холбогдолтой эсэхийг шалгахад Т тестийг ашигладаг.

**Хүснэгт 1.2.1** 2015 онтой харьцуулахад хамтарсан багийн үйл ажиллагаа хэрхэн сайжирсан тухай багийн гишүүдийн үнэлгээний дундаж (санал бүрэн нийлэх - “5”-аас санал огт нийлэхгүй - “1”)

Талбар	Хамтарсан багийн хурал тогтмолжсон	Хамтарсан баг жил, улирал, сарын төлөвлөгөө, тайлангаа тогтмол гаргаж хэвшсэн	Хамтарсан багийн гишүүд үүргээ биелүүлэх байдал сайжирсан	Хамтарсан баг хурлынхаа тэмдэглэлийг баримтжуулж, файлдаа хадгалдаг
Төслийн зорилтот хамтарсан баг	4.333	4.762	4.714	4.682
Хяналтын хамтарсан баг	3.348	3.609	4.696	3.696
T тестийн үр дүн (p≤0.05)	t=2.80 (+;0.008)	t=3.74 (+; 0.001)	t=3.68 (+; 0.001)	t=3.43 (+; 0.001)

Судалгаанд оролцсон төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн зүгээс өгсөн “хамтарсан багийн хурал тогтмолжсон” хэмээх хариултын дундаж үнэлгээ 4.3 байхад хяналтын хамтарсан багийн гишүүдийн үнэлгээ 3.3 байгаа (Хүснэгт 1.2.1) ба энэ ялгаа нь статистик ач холбогдол бүхий үр дүн юм. Энэ нь төсөл хэрэгжсэн хамтарсан багийн зохион байгуулалт жигдэрч, харьцангуй тогтвортой үйл ажиллагаа явуулж эхэлсэн болохыг илтгэж байна (Хүснэгт 1.2.2). Хууль, эрхзүйн орчин, төрийн үйлчилгээний бүтцэд өөрчлөлт гарсан (хүүхдийн байгууллагын чиг үүргийг хүүхэд төдийгүй гэр бүл, залуучуудад чиглэн ажиллуулахаар өргөтгөсөн, дүүрэгт хэлтэс нээн ажиллуулах болсон г.м) нь ерөнхийдөө хамтарсан багуудын хурлын тогтворжилтод эерэг нөлөө үзүүлжээ. Гэхдээ тухайн аймаг, дүүргийн ГБХЗХХ-ийн удирдлага,

**Шигтгээ 1.2.2. Хамтарсан багийн хурлын тогтворжсон байдал**

**Төслийн зорилтот хамтарсан баг**

2016 оны 10 сараас сар тутам үйл ажиллагааны тайлан бичиж эхэлсэн ба 2017 оны 3 сараас хойш “Хамтарсан багийн сар тутмын хуралд гишүүдийн ирц 100% болж өссөн” гэжээ.

*Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 4-р багийн хамтарсан багийн үйл ажиллагааны тайлангаас*

Мөн бид нар 7 хоног болгон хуралддаг болсон, цуглуулсан мэдээллийн дагуу. Кейсээр орж ирсэн хүн бүрийг хамтарсан багаар оруулдаг.

**БЗД, 27-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас**

**Төслийн хяналтын хамтарсан баг**

Дүүрэг бүр ГБХЗХХ-тэй болсноор тогтмол үйл ажиллагааг биднээс шаарддаг. Мөн бидэнд ирж буй хүүхэд хамгааллын асуудал, дуудлагууд нь хурал хийхийг цаанаасаа шаардаж байгаа гэсэн үг. Хуулийн дагуу ч заагаад өгсөн байгаа. Тухайн хүний асуудлыг олуулаа нийлж шийдвэрлэхээр заасан тул бүх гишүүд оролцоно.

*ЧД, 7-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас*

Миний оролцоо ерөөсөө байдаггүй. Нэг ийм кейс байсан ингээд шийдвэрлэсэн гэж нийгмийн ажилтан, цагдаа хэлдэг.

*БЗД, 7-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас*

хяналтаас хамаарч хурал харилцан адилгүй явагдаж байгаа юм (Шигтгээ 1.2.2). Хамтарсан багийн ажиллах журмын 4.4-д буй “хамтарсан багийн хурлыг 51-ээс дээш хувийн ирцтэй тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ” гэсэн заалт төслийн хяналтын зарим хамтарсан багт бүрэн утгаараа хэрэгжихгүй байна.

### Хүснэгт 1.2.2 Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалтад гарсан өөрчлөлт

Үзүүлэлт	Төсөл хэрэгжихээс өмнө		Төсөл хэрэгжсэний дараа	
	Төслийн зорилтот хамтарсан баг	Төслийн хяналтын хамтарсан баг	Төслийн зорилтот хамтарсан баг	Төслийн хяналтын хамтарсан баг
Төлөвлөлт, тайлагналт	+	+	+++	++
Тогтмолжсон хурал, уулзалт	+	+	+++	+
Гишүүдийн үүрэг биелүүлэлт, хамтын ажиллагаа	+	+	+++	+
Хамтарсан багуудын хамтын ажиллагаа	-	-	+++	-
Төсөв хуваарилуулж шийдвэрлүүлэх	-	-	+	-
Хамтарсан багаараа шилдгээр шалгарах, үйл ажиллагаагаараа бусад хамтарсан багаа манлайлах	-	-	+	-
Ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг тусгасан байдал	-	-	++	+
Гишүүдийн тогтвор суурьшилтай ажиллах байдал	+	+	+	+
Багийн ахлагчийн идэвхтэй оролцоо	-	-	+++	+
Нууцлалын гэрээ байгуулж ажиллах	-	-	+++	-
+++ бүгдэд ++ заримд + цөөн хэсэгт – бүгдэд үгүй				

Төслийн суурь судалгаанд хамрагдсан 18 хамтарсан багийн гишүүдэд ажил үүргээ хэрхэн биелүүлэх тухайд суурь чадамж бүрдээгүй болохыг дүгнэж байсан. Тодруулбал, уг судалгаанд хамрагдсан хамтарсан багуудын дийлэнх олонхын хувьд багаар ажиллах чадамж төлөвшөөгүй, гол төлөв сум, баг, хорооны ажилтны үүрэг оролцоогоор хязгаарлагдсан байдлаар үйл ажиллагаа явуулж байв<sup>9</sup>. Энэ удаагийн судалгаанд хамрагдсан төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн зүгээс “Хамтарсан багийн гишүүд үүргээ биелүүлэх байдал сайжирсан” хэмээн хариулсан хариултын дундаж үнэлгээ 4.71, хяналтын хамтарсан багийн гишүүдийн үнэлгээ 4.69 байгаа юм. (Хүснэгт 1.2.1) Энэ нь төсөл хэрэгжсэн эсэхээс үл хамааран хамтарсан багийн гишүүд үүргээ биелүүлэх байдал нь 2015 онтой харьцуулахад сайжирсныг харуулж байна. Үүнд хүүхэд хамгааллын болон хамтарсан багийн эрхзүйн орчин бүрдэж, улмаар гишүүдийн эрх, үүрэг тодорхой болсон нь нөлөөлсөн гэж үзэж болно.

9 ХАХНХЯ, ЖАЙКА, Японы Хүүхдийг Ивээх Сан. “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” судалгааны тайлан УБ., (2015) 87 дугаар тал

Энэ удаагийн судалгаанд хамтарсан багийн гишүүдийн зүгээс өөрсдийн багийн гишүүдийн үүрэг биелүүлэлт, хамтын ажиллагааны төлөв байдлыг үнэлсэн ба График 1.2.1-д дурдсан асуултад өгсөн хариултын үр дүнг нэгтгэн үзвэл төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн дундаж үнэлгээ 3.34 (дундаас дээгүүр), хяналтын хамтарсан багийн гишүүдийн дундаж үнэлгээ 2.73 буюу дундаас доогуур байна. Энэ ялгааг Т тестээр үнэлэхэд ( $t=4.23$ ) статистик ач холбогдлын төвшинд илэрч байгаа бөгөөд энэ нь төслийн зүгээс хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн биелэлт, хамтын ажиллагааг дээшлүүлэхэд анхаарсны үр дүн юм (Хүснэгт 1.2.2). Ялангуяа хамтарсан багийн гишүүн бүрийн оролцоог хангах, гишүүдийн хоорондын хамтын ажиллагааг дээшлүүлэхэд мэдэгдэхүйц дэвшил гарсан нь ажиглагдаж байна (График 1.2.1).

### Шигтгээ 1.2.3. Хамтарсан багийн гишүүдийн оролцоо

Хамтарсан багийн гишүүд ажлаа хуваарилаад, тус тусын шаардлагатай үнэлгээнүүдээ хийж чадаж байгаа. Өрхийн эмнэлгийн эрүүл мэндийн ажилтан эмнэлгийг, цагдаа өөрийн чиглэлийн гэх мэт. Гишүүдийн оролцоо нэмэгдсэн. 2015 онтой харьцуулахад багийн гишүүдийн идэвх оролцоо сайжирсан. Үүнд гишүүдийн сургалт, туршлага солилцох уулзалтад хамрагдсан нь их нөлөөлсөн.

*ЧД, 9-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас*

**График 1.2.1** Хамтарсан багийн гишүүдийн үүрэг биелүүлэлт, хамтын ажиллагаа (өөрийн үнэлгээний дунджаар)



Дээрх мэдээллээс хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тогтвор суурьшил муу, тэдний ажлын байрны тодорхойлолтод чиг үүрэг нь тусгагдаагүй, түүнчлэн удирдлагаас дэмжихгүй байх зэрэг асуудлууд байгааг харж болно (Шигтгээ 1.2.3). Суурь судалгааны үед хамтарсан багийн гишүүдийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, баталгаа хангагдаагүй байдал илэрч байсан бол өнөөдөр ч байдал хэвээр байна. Энэ нь төслийн хэрэгжилтэд саад болж байсан гол хүчин зүйлсийн нэг байжээ. Нийгмийн ажилтан нь тогтвор суурьшилтай ажилласан хамтарсан багийн хөгжил, төлөвшилт 2015 онтой харьцуулахад дараагийн шатанд гарч, багийн дотоод болон гадаад хамтын ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг

**Шигтгээ 1.2.4. Хамтарсан багийн гишүүдийн үүргийн хэрэгжилт****Төслийн зорилтот хамтарсан баг**

- Багийн гишүүд тогтвортой ажиллаж чаддаггүй (ахлагч, нийгмийн ажилтан, цагдаа)
- Хамтарсан багийн ажлыг ажлын байрны тодорхойлолтод тусгах. Гишүүд хэдий ажиллах хүсэлтэй байвч цаад удирдлагууд нь ойлгодоггүй. Ажлын уялдааг нь зохицуулж өгдөггүй.

*СХД, 10-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас*

**Төслийн хяналтын хамтарсан баг**

- Багийн гишүүд тогтвортойгоор ажиллаж чаддаггүй (ахлагч, нийгмийн ажилтан, цагдаа)
- Нийгмийн ажилтан бүх үйл ажиллагаанд оролцдог. Хогны төсөл, ахмадын судалгаа, тамирчдын өдөрлөг гэх мэт олон төрлийн ажил хийдэг. Удирдлагууд биеэр оролцдоггүй тул асуудлыг ойлгодоггүй. Ажил үүргийн хуваарь тодорхой бус байгаа.

*ЧД, 12-р хорооны хамтарсан багийн гишүүний ярианаас*

өсгөж чадсан байв. Тухайлбал, нийгмийн ажилтан нь тогтвортой ажилласан (төслийн зорилтот) хамтарсан багуудаас нийслэл, дүүргийн “Шилдэг” хамтарсан багаар шалгарчээ.

Улаанбаатар хотын БЗД-ийн 23, 27-р хороо болон ЧД-ийн 7, 9-р хороодын хамтарсан багийн гишүүдийн чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тодорхой тусгаж өгчээ. Холбогдох хууль, журмууд батлагдсан нь гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгож, хамтарсан баг дахь гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудлаар хамтарсан багаар ажиллаж, шийдвэр гаргадаг болоход нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Судалгаанд хамрагдсан хамтарсан багуудын дийлэнхэд нь гишүүний эрх, үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгах гэхээсээ холбогдох хууль, журмаар зохицуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Гэвч ажлын байрны тодорхойлолтод гишүүдийн эрх үүргийг тусгаагүй байдал нь удирдлага болон ажилтан улс төрийн сонгуулиас хамаарч солигдох нөхцөлд хамтарсан баг хуулиар заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад

учруулах үндсэн нөхцөл болж байна. Өөрөөр хэлбэл хамтарсан багийн зарим гишүүдийн ажлын байрны тогтворгүй байдал нь тухайн гишүүдийн зүгээс хамтарсан багийн гишүүний үүргээ хэрэгжүүлэхэд саад болсоор байна. Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)-ийн 20 дугаар зүйлийн 5-д “Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна” хэмээн заасан ч хэрэгжилт орон нутгийн төвшинд хангагдахгүй байна.

Төсөлд хамрагдсан сум, баг, хорооны хамтарсан багуудын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд нийтлэг ажиглагдсан давуу тал бол хүүхэд хамгааллын чиг үүрэг бүхий ажилтнуудтай “Нууцлалын гэрээ” (нууц хадгалах гэрээ) байгуулж ажилладаг болсон явдал юм. Тухайлбал, ЧД-ийн 9-р хорооны хувьд гишүүд, хэсгийн ахлагч нартай, Архангай аймгийн Батцэнгэл сумын хувьд багийн засаг дарга, багийн эмч гэх мэт төрийн байгууллагын ажилтнуудтай нууц хадгалах үүрэг хүлээлгэсэн гэрээ байгуулан ажиллаж байна.

Төслийн зорилтот хамтарсан багуудаас хоёр нь сум, дүүргийн төсвөөс тодорхой хөрөнгийг хамтарсан багийн үйл ажиллагаанд хуваарилуулж чадсан байна. Энэ санаачилгын анхдагч

нь Архангай аймгийн Хайрхан сумын хамтарсан баг бөгөөд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хамтарсан багийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, төлөөлөгчид болон засаг даргад нөлөөлсний үр дүнд 2017 онд 750,000 төгрөг, 2018 онд 1,000,000-1,500,000 төгрөгийн төсөв хуваарилуулан хамтарсан багаар хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээг хүргэхэд зарцуулсан байна. Нийслэлийн хамтарсан багуудаас ЧД-ийн 9-р хорооны хамтарсан багийн ахлагч нь дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн хувьд 2018 оны төсвийг хэлэлцэх явцад хороо тус бүрийн хамтарсан багийн үйл ажиллагаанд зориулан сардаа 80,000-100,000 төгрөг хуваарилуулахаар болжээ. Төслийн суурь судалгааны үр дүнд хамтарсан багийн ахлагч нь хэн болох, хамтарсан багийн удирдах, зохион байгуулах үүргийг хэн хариуцах тухай асуудал чухал болохыг тэмдэглэж байсан бол төсөл хэрэгжсэн хамтарсан багуудад багийн ахлагчийн оролцоо, үүрэг, санаачилга, шийдвэр гаргагчдад нөлөөлөх чадамж нь өссөн болохыг орон нутгаас төсөв, санхүүгийн дэмжлэгийг олж авснаас харж болно (Хүснэгт 1.2.2). Өмнө дурдсанчлан хамтарсан багт тулгамдаж буй санхүүгийн хүндрэлийг зохих хэмжээнд шийдэх үүднээс 2018 оны улсын төсвөөс хамтарсан багийн үйл ажиллагаанд зориулан төсөв хуваарилахаар болсон нь орон нутгаас төсвийн дэмжлэг үзүүлдэггүй хамтарсан багуудын үйл ажиллагаанд ихээхэн дэм болох юм.

Төслийн зорилтот хамтарсан багуудын хооронд туршлага судлах боломж олгосон нь харилцан суралцах, хамтарсан багийн гишүүдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр хамтран ажиллах, мэдээлэл, туршлага солилцох таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна. Туршлага судлах боломжийг олгосноор хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс гаргуулах, иргэд, иргэдийн зөвлөл, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар дэвшил гарчээ. ЧД-ийн 9-р хорооны хамтарсан баг “Эерэг ээжүүд”, “Хамтарсан багийн бүлэг”, Архангай аймгийн Батцэнгэл сумын хамтарсан баг “Эерэг аавуудын клуб”, “Ахмад багш нарын зөвлөл”, “Анги удирдсан багш нар”-ын клуб, төрийн байгууллага бүрт “Гэр бүлийн зөвлөл”, “Сурагчийн зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байгаа нь хүүхэд хамгааллын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх ажилд дэм үзүүлж байна.

### *Шигтгээ 1.2.5. Хамтарсан багийн үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой асуудлууд*

Манайхаас Хөтөлийн буудал хүртэл манай хороо үргэлжилдэг, тэнд айлд очих, дагуулж явахад өөрөө зардлыг нь гаргадаг. 108-аас утасдахад, хамгаалах байрнаас хүн гаргах тэр бүгдэд өөрийнхөө зардлыг тэр хүний зардалтай хамт гаргадаг. Улсаас шийдэж өгдөггүй.

*ЧД-ийн 7 хорооны (хяналтын) хамтарсан багийн гишүүний ярианаас*

Санхүүгийн асуудал хүнд. Үйлчилгээ явуулахтай холбоотой бүх зардал төсөвлөгдөөгүй байдаг.

*БЗД-ийн 23-р хорооны (зорилтот) хамтарсан багийн гишүүний ярианаас*

# ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЛЭГ, УР ЧАДВАР

Хамтарсан багийн гишүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдлэг болон ур чадвар, тулгамдаж буй асуудал бэрхшээл, шийдвэрлэх арга замыг ярилцлага болон баримт бичгийн судалгааны аргаар тус тус тодорхойлсон болно. Ийнхүү авч үзэхдээ төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар ямар түвшинд байгааг харьцуулан судалсан юм.

## *Хүснэгт 2.1.1 Үнэлгээнд оролцсон хамтарсан багийн гишүүдийн тоо*

	Төслийн зорилтот хамтарсан баг	Төслийн хяналтын хамтарсан баг
Төсөл хэрэгжихээс өмнө бүлгийн ярилцлагад оролцсон хамтарсан багийн гишүүдийн тоо	45/50.0%	45/50.0%
Төсөл хэрэгжсэний дараах стандарт асуумжид оролцсон хамтарсан багийн гишүүдийн тоо	23/48.9%	24/51.1%

Төслийн хүрээнд хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлуудыг хэрэгжүүлснээр тэд мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, орон нутгийн хүүхдүүдэд хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болно хэмээн төлөвлөсөн байна.

2015 онд хийсэн суурь судалгааны үр дүнгээс<sup>1</sup> үзэхэд төслийн зорилтот хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээ гэж юу болох талаар анхан шатны ойлголттой, хэрхэн ажиллах талаар мэдлэгтэй, харин хяналтын бүлгийн хувьд хүүхэд хамгааллын үйлчилгээ гэж юу болох, хамтарсан багийн чиг үүрэг, хэрхэн ажиллах талаар мэдлэг, ур чадвар хангалтгүй байсан юм. Харин 2018 онд төслийн эцсийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар, туршлага ихээхэн нэмэгдэж, кейс бүртгэл болон кейсийг шийдвэрлэх ур чадвар сайжирсан ба төслийн хяналтын хамтарсан багийн гишүүд анхан шатны ойлголттой, хэрхэн ажиллах талаар хангалттай мэдлэг, мэдээлэлтэй болсон нь харагдаж байна. Мөн төслийн хяналтын хамтарсан багийн гишүүд бодит байдал дээр хэрхэн баг болж хамтарч ажиллах талаар ойлголт, мэдлэг хомс, хамтарсан баг хэрхэн ажиллах талаар тэдгээрийн ажил үүргийн хуваарьт тусгаагүй, багаар ажиллах мэдлэг, хандлага тааруу, албан тушаал өөрчлөгдөх, солигдох зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан

<sup>1</sup> ХАХНХЯ, ЖАЙКА, Японы Хүүхдийг Ивээх Сан. “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал” судалгааны тайлан УБ., (2015)



олон бэрхшээлтэй тулгардаг ажээ.Төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварыг сургалтын үр нөлөө, арга зүйн дэмжлэг туслалцаа, мэдлэг, ур чадварын өөрчлөлт гэсэн гурван үндсэн хэсэгт тулгуурлан авч үзлээ.

## 2.1 ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Төсөл хэрэгжих хугацаанд хамтарсан багийн гишүүдийн хүүхдийн эрх, хамтарсан багийн тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тэдэнд ур чадвар эзэмшүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх сургалтыг хоёр үе шаттайгаар зохион байгуулжээ. Эхний шатанд сургагч багш бэлтгэх сургалтыг 2016 оны 11 сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулж, хүүхэд хамгаалал болон хамтарсан багийн үйлчилгээний талаар нэгдсэн ойлголттой болгоход анхаарсан байна. Сургагч багш бэлтгэх сургалтыг төслийн хүрээнд боловсруулсан сургалтын материалыг ашиглан хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төв болон орон нутгийн байгууллагын 30 ажилтны дунд зохион байгуулжээ. Сургалтын бүхий л үйл ажиллагаа сэдэв, агуулгын хувьд төлөвлөсний дагуу зохион байгуулагдсан байна.


Сургалтаар бэлтгэгдсэн 30 сургагч багшийн 15 нь Улаанбаатарт, 7 сургагч багш нь Архангай аймагт зохион байгуулсан сургалтуудыг тус тус удирдан явуулсан буюу сургалтад хамрагдсан 30 сургагч багшаас 22 нь хоёр дахь шатны сургалтыг зохион байгуулахад оролцсон юм. Өөрөөр хэлбэл сургагч багш нарын 73% нь дараагийн шатны сургалтыг зохион байгуулахад оролцсоноор төслийн хүрээнд дэвшүүлсэн 1.3-р зорилтыг биелүүлсэн байна.

Сургагч багшаар бэлтгэгдсэн багш нар салбартаа олон жил ажилласан, дадлага туршлагатай, төрийн байгууллагын хүүхэд хамгааллын ажилтнууд байсан нь сургалтыг амжилттай явуулахад нөлөөлжээ. Сургагч багш нарын хувьд өөрийн ажил мэргэжил, үүргийн хувьд асуудлаа сайн судалсан, агуулгыг эзэмшсэн, практик ач холбогдлыг суралцагчдаа ойлгуулах талаар чин эрмэлзэлтэй, насанд хүрэгчдэд сургалт явуулах аргаар бэлтгэл сайтай оролцсон байна.

Хоёр дахь шатны сургалтыг 2017 оны 11 сард төслийн зорилтот хамтарсан багийн гишүүд, хэсгийн ахлагч нарын дунд хоёр төвшинд явуулжээ. **Анхан шатны сургалтыг** ЧД, СХД, БЗД-ийн төсөлд хамрагдсан 6 хорооны хэсгийн 73 ахлагч нарт, **гүнзгийрүүлсэн сургалтыг** ЧД, СХД, БЗД-ийн төсөлд хамрагдсан 6 хорооны хамтарсан багийн гишүүд, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 4-р баг, Хайрхан, Батцэнгэл сумын хамтарсан багийн 92 гишүүдэд, нийт 165 хүнийг хамруулан зохион байгуулжээ.

Сургалтыг зохион байгуулахад төсөлд хамрагдсан 3 дүүргийн ГБХЗХХ удирдага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн нь сургалт үр дүнтэй, амжилттай болоход нөлөөлсөн байна. ХИС-ийн сургалтын үнэлгээний тайланд дурдсанаар<sup>2</sup> сургалтад хамрагдсан нийт 165 оролцогчдод гэрчилгээ олгосон байна.

<sup>2</sup> Хамтарсан багийн талаарх сургалтад оролцогчдоос авах үнэлгээний хуудас - Сургалтын ерөнхий үнэлгээ. ХИС



Тус сургалтад оролцсон хамтарсан багийн гишүүдээс нийт 10 асуулгаар сургалтын өмнөх болон дараах мэдлэг, ур чадварын сорил авч, зөв буруу хариултын хувь хэмжээг харьцуулахад дараах үр дүн гарсан байна.

### Хүснэгт 2.1.2 Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын үнэлгээ

	Хамтарсан багийн гишүүний сургалтын өмнөх мэдлэг, чадвар		Хамтарсан багийн гишүүний сургалтын дараах мэдлэг, чадвар	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Зөв хариулт	60	67.4	81	91
Буруу хариулт	29	32.6	8	9

Тайлбар: Нийт 89 хамтарсан багийн гишүүн үнэлгээнд хамрагдсан.

Тухайн сургалтын ерөнхий үнэлгээнээс үзэхэд хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын талаарх асуултын зөв хариулт 91% байгаа нь “Сургалтад хамрагдсан хамтарсан багийн гишүүдийн багадаа 85% нь хүүхэд хамгааллын талаарх мэргэжлийн болон аргагүйн мэдлэг, ур чадвараа батлагдахуйцаар нэмэгдүүлсэн байна” гэсэн төслийн 1.3-р зорилтыг бүрэн хангасан байна.

## 2.2 ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН АРГАЗҮЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА

Хамтарсан багийн гишүүдэд зориулсан сургалтаас гадна тухайн хамтарсан багт орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас мэргэжил, аргагүйн зөвлөгөө өгч ажиллаж байгаа нь ихээхэн үр нөлөөтэй байдаг талаар судалгаанд оролцсон хамтарсан багийн гишүүд дурдсан байна. Төслийн үндсэн зорилгын нэг бол хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг хангах механизм бий болгож, бэхжүүлэх явдал юм. Үүний үр дүнд хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломжийг бүрдүүлэх ёстой.

Судалгаанд оролцсон орон нутгийн хамтарсан багийн гишүүд ажлын байран дээрээ мэргэжил, аргазүйн зөвлөгөө, дэмжлэг авсан талаар дараах хариултыг өгсөн байна.

Судалгаанд оролцсон төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 95.7% нь төслөөс боловсруулсан журам, протокол болон байгууллагын дэмжлэг, аргазүйг авч ажилладаг тухайгаа илэрхийлсэн байна. Харин төслийн хяналтын хамтарсан багийн гишүүдийн 70% гаруй нь мэргэжил, аргазүйн зөвлөгөө, дэмжлэг авдаг болохоо илэрхийлсэн нь төслийн зорилтот хамтарсан багаас 25% бага байна. Эндээс үзэхэд төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн багадаа 80% нь төслөөс боловсруулсан журам, протокол, холбогдох аргазүй болон байгууллагын дэмжлэгийг авч хэрэгжүүлдэг болсон байх тухай төслийн **2.1 зорилт** 15.7%-иар давж биелсэн байна. Цаашид хяналтын хамтарсан багийн гишүүдэд зориулж ажлын байран дээр нь мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага бий. Учир нь төсөл хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй орон нутгийн хамтарсан багийн гишүүдийн хүүхэд хамгааллын тухай ойлголт, мэдлэг хандлага, ажилласан туршлагын хувьд ялгаатайн дээр мэдээлэл сургалт, арга зүйн дэмжлэг ч харилцан адилгүй байна.

Төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдэд өгч буй мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэгийн үр дүн чухамхүү ямар байгаа талаар хамтарсан багийн гишүүдийн өгсөн үнэлгээг сонирхож үзэхэд төслийн зорилтот хамтарсан багийн гишүүд сайн, маш сайн гэсэн хариултыг нийтлэг өгсөн байна. Харин хяналтын хамтарсан багийн 8.4% нь тааруу буюу дунд байсан гэсэн үнэлгээг өгчээ.

Мэргэжил, аргазүйн дэмжлэг, зөвлөгөөг дараах төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд нийтлэг өгсөн байна.

**Хүснэгт 2.2.1** *Хамтарсан багуудад мэргэжил, аргазүйн дэмжлэг, зөвлөгөө өгсөн байгууллагууд*

Төрийн бус, Олон улсын байгууллагууд	Төрийн байгууллагууд
Хүүхдийг Ивээх Сан - 17	ГБХЗХГ - 14
Дэлхийн зөн ОУБ - 4	Дүүрэг, орон нутгийн нийгмийн хөгжлийн хэлтэс - 4
ЖАЙКА ОУБ - 3	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс - 2
Гүүд Нейборс ОУТББ - 1	Сумын ЕБС-ийн нийгмийн ажилтан - 1
Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг - 1	Цагдаагийн газар - 1

Судалгаанд оролцсон хамтарсан багийн гишүүд олон улсын байгууллагаас ХИС, төрийн байгууллагуудаас ГБХЗХХ-ээс ихэвчлэн мэргэжил, аргазүйн дэмжлэг авсан тухайгаа дурджээ. Тухайн мэргэжил, аргазүйн дэмжлэгийн хүрээнд хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд, хамтарсан багаар ажиллах аргазүй, стресс менежмент, кейсийг хэрхэн бүртгэх болон кейс дээр хэрхэн ажиллах талаар зөвлөгөө, сургалт тус тус авсан байна. Цаашид төслийн зорилтот хамтарсан багийн сайн туршлага, өгсөн зөвлөгөө дэмжлэгийг бусад хяналтын хамтарсан багт түгээн дэлгэрүүлэх шаардлагатай.

## 2.3 ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫН ӨӨРЧЛӨЛТ

Төсөл хэрэгжих хугацаанд хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар хэрхэн өөрчлөгдсөн тухай асуудал ихээхэн чухал болно. 2015 оноос хойш хамтарсан багийн гишүүдийн хувьд “таны мэдлэг, ур чадвар хэрхэн нэмэгдсэн бэ?” гэсэн асуултад өөрсдийн мэдлэг, ур чадварын талаар дараах байдлаар хариулсан байна.

### Хүснэгт 2.3.1 Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын өөрчлөлтийн үнэлгээ

(5-санал бүрэн нийлнэ, 4-ерөнхийдөө санал нийлнэ, 3-дунд, 2-санал нийлэхгүй, 1-огт санал нийлэхгүй)	5	4	3	2	1
Үйлчилгээний маягтаа хэрэглэх ур чадвар нэмэгдсэн	43.5	37.0	15.2	0	4.3
Хүүхэд хамгаалын асуудалтай холбоотой мэдээлэл авсан тохиолдолд нийгмийн ажилтан эсвэл хамтарсан багийн гишүүн мэдээллийн маягт бөглөдөг	41.3	21.7	23.9	0	4.3
Тухайн кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргадаг	52.2	19.6	21.7	0	6.5
Кейс бүрийг эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажилладаг	50.0	28.3	10.9	6.5	4.3
Эрсдэлийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээг багийн 2-оос доошгүй хүн хийдэг	45.7	34.8	8.7	4.3	6.5
Хамтарсан баг хурлынхаа тэмдэглэлийг баримтжуулж, файлдаа хадгалдаг	47.8	34.8	10.9	2.2	4.3
Кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг	47.8	21.7	26.1	0	4.3
Кейс төлөвлөгөөний дагуу, хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг	52.2	32.6	10.9	0	4.3
Үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг	43.5	37.0	15.2	0	4.3
Кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаадаг	40.9	31.8	13.6	9.1	4.5

Хүснэгтээс үзэхэд төсөл хэрэгжих хугацаанд хамтарсан багийн үйлчилгээний маягтыг хэрэглэх, эрсдэлийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хурлын тэмдэглэлээ баримтжуулах, хамтарсан багаар кейс төлөвлөгөө боловсруулах болон кейс төлөвлөгөөний дагуу хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадвар харьцангуй нэмэгдэж 80%-иас дээш болсон байна. Харин кейс нээх (10.9%), кейс хаах (13.6%) зэрэг ур чадвар төдийлөн сайжраагүй гэж хяналтын хамтарсан багийн гишүүд илүүтэй хариулсан байна. Төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдийн өгсөн тухайн үнэлгээний дунджийг харьцуулан илүү нарийвчилсан байдлаар харж болно.

Үнэлгээг санал нийлж буй эсэхээр 1-5 хүртэлх оноогоор харьцуулж, дундаж үзүүлэлтийг тооцоход төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн хувьд мэдлэг, ур чадварын үнэлгээний өөрчлөлтийн дундаж ихээхэн өндөр байна.

**Хүснэгт 2.3.2** Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын өөрчлөлтийн дундаж, бүлгийн ялгааг T тест ашиглан хэмжсэн үр дүн

	Төслийн хяналтын хамтарсан баг	Төслийн зорилтот хамтарсан баг	Статистик ач холбогдол	Түвшин
Тухайн кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргадаг	3.542	4.739	0.0004	++
Кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг	3.458	4.783	0.0007	++
Кейс төлөвлөгөөний дагуу, хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг	3.875	4.739	0.0083	++
Мэдээллийн маягт бөглөдөг	3.455	4.714	0.0122	+
Эрсдэлийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээг багийн 2-оос доошгүй хүн хийдэг	3.625	4.609	0.0182	+
Хамтарсан баг хурлынхаа тэмдэглэлээ баримтжуулж, файлдаа хадгалдаг	3.750	4.696	0.0302	+
Үйлчилгээний маягтаа хэрэглэх ур чадвар нэмэгдсэн	3.708	4.652	0.0478	+
Үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг	3.708	4.609	0.0779	0
Кейс бүрийг эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажилладаг	3.750	4.565	0.1709	0
Кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаадаг	3.619	4.524	0.7855	0

*Тайлбар:  $p < 0.05$  бага тохиолдолд ач холбогдолтой буюу тухайн бүлгүүд ялгаатай гэж үзнэ. Хамаарлын түвшин ++ бол эрс ялгаатай, + бол ялгаатай, - бол ялгаагүй гэж тус тус үнэлсэн.*

2015 оны суурь судалгаагаар төслийн зорилтот хамтарсан багийн гишүүд урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэгтэй ч цаашид мэргэжлийн үйлчилгээ хэрхэн үзүүлэх тухай нарийвчилсан сургалтад хамрагдах шаардлагатай байсан ба тэдний 63,8% нь хүүхдийн эрсдэлийн үнэлгээнд оролцож байсан туршлагатай байжээ. Харин энэ удаа 2018 онд хийсэн төслийн эцсийн судалгааны үр дүнгээс үзэхэд кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргах, кейс нээсний дараагаар хамтарсан багаар кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, кейс төлөвлөгөөний дагуу хүүхэд гэр бүлд үйлчилгээ үзүүлэх чиглэлд төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар хяналтын хамтарсан багийн гишүүдээс мэдэгдэхүйц ялгаатай байна.

2015 оны суурь судалгаагаар төслийн хяналтын хамтарсан багийн гишүүд урьдчилан сэргийлэх талаар ойлголт, төсөөлөл тааруу, мэргэжлийн болон аргазүйн сургалтад хамрагдах зайлшгүй шаардлагатай байсан юм. Тэдний 71,8% нь хүүхдийн эрсдэлийн үнэлгээнд оролцож байсан туршлагатай ч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх талаар ойлголт төсөөлөл тааруу байжээ. Энэ судалгааны үр дүнгээс харахад төслийн хяналтын хамтарсан багийн гишүүд мэргэжлийн үйлчилгээний талаар хангалттай ойлголт, төсөөлөлтэй болсон байна. Нөгөө талаар үйлчилгээний явцад болон дараа хяналт үнэлгээ хийдэг, кейс бүрийг эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлаж ажиллах, кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаах зэрэг мэдлэг, ур чадварын үнэлгээний дунджийг харьцуулан үзэхэд төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдийн дунд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй болно.

## **ХАМТАРСАН БАГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

Хамтарсан багийн үйлчилгээний чанар 2015 оноос хойш хэрхэн өөрчлөгдсөнийг хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлт нэмэгдсэн эсэх, нийгмийн ажилтны кейс менежерийн ур чадвар сайжирсан эсэх, хамтарсан багийн гишүүдээс үйлчилгээний маягтаа хэрэглэх ур чадвар нэмэгдсэн эсэх, кейсийг хамтарсан багаар ярилцаж, багаар шийдвэр гаргадаг эсэх, аюулын зэрэг болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан кейс нээдэг эсэх зэрэг үзүүлэлтээр тодорхойлох болно. Түүний дээр, аюулын зэргийн үнэлгээг багийн 2-оос доошгүй гишүүн хийдэг эсэх, кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг эсэх, кейс төлөвлөгөөний дагуу хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг эсэх, үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг эсэх, кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейс хаагддаг эсэх зэрэг үзүүлэлтүүдийн дагуу судаллаа.

### **3.1 ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ИЛРҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭЖ АВАХ**

Сүүлийн жилд хүүхэд хамгаалалд холбогдох хууль, дүрэм журмуудыг олон нийтэд сурталчлахад чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулсны үр дүнд хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлт сайжирч байгаа билээ. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээг Засгийн газрын тогтоолоор төв болгон өргөжүүлсэн. Өмнө нь дуудлага авч, зөвлөгөө мэдээлэл өгдөг байсан бол одоо эрсдэлт нөхцөл байдалд очиж яаралтай тусламж дэмжлэгийг үзүүлдэг болсон юм. Дэргэдээ түр хамгаалуулах байрыг байгуулж, хүүхдийг 72 цагаас долоо хоногийн хугацаанд байрлуулж, үйлчилгээ үзүүлдэг

#### ***Шигтгээ 3.1.1 Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл хүлээж авах байдал***

Сүүлийн үед гарч байгаа хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь гэмт хэргийн шинжтэй, хэрцгий болж байгаа учир олон нийтийн хараа хяналтад өртөн, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр их цацаж байгаатай холбоотой мэдээлэл өгөх байдал нэмэгдэх хандлагатай байна.

Өмнө мэдээлэл дуудлага бага ирдэг байсан бол одоо харьцангуй нэмэгдэж байна. Сая өнгөрдөг 12 сард даллага авахуулсан мэт маш их байлаа. Хамтарсан багийн талаарх иргэдийн ойлголт нэмэгдэн илүү мэдээлэлтэй болсны илрэл байх. Мөн эмч нар хүчирхийллийн талаар сургалтад хамрагдсанаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлтэд маш их нэмэр болж байна. Жингийн дутагдалтай, энд тэндээ гэмтсэн гэх мэтчилэн бүх мэдээллийг мэдэгдсэнээр манай илрүүлэлт улам сайжирч байна. 108 утас, хэсгийн ахлагчид бас мэдээлж байна.

*(Хамтарсан багийн гишүүний ярилцлагаас)*

болсон, түүнчлэн нийгэмд гарч буй кейсүүдээс үүдэн иргэд, олон нийтээс мэдээлэл өгөх байдал нэмэгдэж байгаа зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамаарах ололт амжилтуудыг дурдах хэрэгтэй.

2015 онд хийгдсэн суурь судалгааны дүнгээс үзэхэд, хүүхэдтэй зүй бусаар харилцах явдал буюу хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт мөлжлөг, үл хайхрах нөхцөл байдалд өртсөн, өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүдийг нэг талаас хэсгийн ахлагч, хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнд, нөгөө талаас олон нийтийн мэдээлэл, хүүхдийн тусламжийн 108 утас болон цагдаагийн дуудлага, судалгаанд тулгуурлан илрүүлдэг байв.

Төслийн эцсийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүд өөрсдийн үйл ажиллагаагаар дамжуулан илрүүлэх явдал нэмэгдэн, мэдээллийг ихэвчлэн хэсгийн ахлагч нар, хүүхдийн тусламжийн 108 утас, цагдаагийн дуудлага, оршин суугчид зэрэг эх сурвалжаас зонхилон авах хандлагатай байна.

**Хүснэгт 3.1.1** Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх, илрүүлэх байдал

Хороо	Баг, хорооны түвшинд															
	Төслийн эхлэл үе (2015 он)							Төслийн төгсгөл үе (2018 он)								
	Хамтарсан багийн гишүүд	Хэсгийн ахлагч нар, хорооны судалгаа	Хүүхдийн мэдээлэл	Иргэдийн мэдээлэл	Цагдаагийн дуудлага	Сургуулийн нийгмийн ажилтан	Эмчийн мэдээлэл	Төрийн байгууллагууд	Хамтарсан багийн гишүүд	Хэсгийн ахлагч нар	Хүүхдийн тусламжийн 108 утас	Иргэдийн мэдээлэл	Цагдаагийн дуудлага	Сургуулийн нийгмийн ажилтан	Эмчийн мэдээлэл	Төрийн байгууллагууд
Зорилтот хамтарсан баг	ЧД, 9 хороо	+	+		+			+		+	+	+	+	+	+	+
	ЧД, 10 хороо	+	+	+	+	+	+	+		+	+	+	+	+	+	+
	БЗД, 23 хороо		+							+	+	+	+	+		+
	БЗД, 27 хороо	+	+		+					+	+	+	+	+		
	СХД, 2 хороо		+	+	+	+		+		+	+	+	+	+	+	+
	СХД, 10 хороо	+	+			+				+	+	+	+	+	+	
	Архангай, Хайрхан сум		+							+		+	+			+
	Архангай, Батцэнгэл сум	+	+				+	+		+		+	+	+		+
	Архангай, Эрдэнэбулган сум, 4 баг							+		+		+	+	+		
	ЧД, 7 хороо		+							+	+	+		+		
	ЧД, 12 хороо	+	+		+	+				+	+	+	+			+
	БЗД, 7 хороо	+	+		+	+				+	+	+		+		+
	БЗД, 16 хороо		+			+				+	+	+		+	+	



Хяналтын хамтарсан баг	СХД, 13 хороо	+	+			+				+	+	+					
	СХД, 20 хороо	+	+	+	+	+				+	+	+	+				
	Архангай, Эрдэнэбулган сум, 1 баг	+	+							+		+	+	+			
	Архангай, Ихтамир сум, Төвийн баг	+	+							+		+		+			
	Архангай, Өндөр-Улаан сум, Төвийн баг	+								+		+		+			

Хүснэгт 3.1.1-ээс харахад сургуулийн нийгмийн ажилтны үүрэг, оролцоо хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлтэд доогуур, тэдний зүгээс хамтарсан багийн гишүүдтэй хамтран ажиллах байдал учир дутагдалтай байгаа нь суурь судалгааны үр дүнтэй адилхан байна. Гэвч иргэдийн зүгээс мэдээлэл өгөх хандлага нэмэгдсэн, нийгмийн ажилтан, цагдаа болон эмч нар багийн зохион байгуулалтаар ажиллах туршлагатай болсон нь энэ удаагийн судалгааны үр дүнгээс харагдаж байв. Хорооны төвшинд хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл өгөх тал дээр төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах болсон нь хүүхэд хамгааллын үйлчилгээнд гарч буй ахиц дэвшил юм.

**Шигтгээ 3.1.2 Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл хүлээж авах байдал**

Иргэдэд хорооны хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг өгдөг, ингэснээр иргэд өөрсдөө мэдээллээ хамтарсан багийн гишүүдэд өгдөг болж байна. Хамтарсан багийн гишүүн бүр өөрийн үүргээ ойлгон, ажил үүргээ хангалттай биелүүлж байна. Жишээлбэл, өрхийн эмч бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлсэн тохиолдолд хамтарсан багтаа мэдээлэн, асуудлыг хамтарч шийддэг болсон нь төсөл хэрэгжсэний үр дүн гэж ойлгож байна.

(Хамтарсан багийн гишүүний ярилцлагаас)

**График 3.1.1 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлт нэмэгдсэн (n=47)**



Судалгааны үр дүнгээр төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 65.2% нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлт нэмэгдсэнтэй бүрэн санал нийлж байгаа бол төслийн хяналтын хамтарсан багийн хувьд энэ нь 2 дахин бага үзүүлэлттэй байна.

Төслийн эхлэл үед хамтарсан багийн үйл ажиллагаа жигдрээгүй, гишүүдийн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх ойлголт мэдлэг хангалтгүй байснаас хамааран хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл хүлээж авах чиглэлээр санаачлан зохион байгуулсан үйл ажиллагаа хомс байсан юм. Төсөл хэрэгжсэний үр дүнд орон нутаг болон нийслэл дэх зорилтот болон хяналтын хамтарсан багууд тодорхой ажлуудыг санаачлан хийж байна.

### **Хүснэгт 3.1.2** Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл хүлээж авахад чиглэсэн үйл ажиллагаа

Аймаг, нийслэл/ баг, хороо	Үйл ажиллагаа
<b>Зорилтот хамтарсан баг</b>	
УБ, Чингэлтэй дүүрэг, 9 хороо	Нийтийн эргүүл зохион байгуулсан.
УБ, Сонгинохайрхан дүүрэг, 2 хороо	Хэсгийн ахлагчаар дамжуулан өрхийн судалгааг сайжруулах ажлыг хийж байна.
Архангай, Хайрхан сум	Мэдээлэл хүлээн авах нээлттэй утас ажиллуулж байна.
Архангай, Батцэнгэл сум	Хүүхэд хамгааллын сарын аянг зохион байгуулсан.
Архангай, Эрдэнэбулган 4 баг	Хүүхэд хамгааллын талаар бодлого барьж ажиллаж байна.
<b>Хяналтын хамтарсан баг</b>	
УБ, Чингэлтэй дүүрэг, 7 хороо	Урамшуулалт эргүүлийн ажлыг санаачлан зохион байгуулж байна.
УБ, Баянзүрх дүүрэг, 7 хороо	ЕБС-ийн нийгмийн ажилтан болон багш нартай хамтран төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
УБ, Баянзүрх дүүрэг, 16 хороо	Өнөр бүл улсын асрамжийн дотуур байрын багш нартай холбогдож мэдээлэл авдаг.
Архангай, Эрдэнэбулган 1 баг	Айл өрхийн зураглал гаргаад ажиллаж байна.

Зорилтот хамтарсан багийн хувьд 2015 онд 54, 2016 онд 450, 2017 онд 525, харин төслийн хяналтын хамтарсан багуудын хувьд 2015 онд 10, 2016 онд 214, 2017 онд 485 эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг тус тус илрүүлжээ. Үүнээс үзэхэд төслийн үр дүнд гэр бүлийн хүчирхийлэл дарамтад өртсөн, айлд зарцлагддаг, хурдан морь унадаг, өрх толгойлон хараа хяналтгүй амьдарч буй, ялгаварлан гадуурхалтад

өртөн хүнд нөхцөлд амьдарч буй зэрэг эрсдэлт нөхцөлд байгаа, хамгаалуулах эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн илрүүлэлт жилээс жилд нэмэгдэж байна.

### **Шигтгээ 3.1.3** Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэл хүлээж авах байдал

Хамтарсан багийн дэргэд иргэд, хүүхдэд зориулсан мэдээлэл хүлээж авах нээлттэй утас ажиллуулж байна.

*(Хамтарсан багийн гишүүний ярилцлагаас)*

### 3.2 ХАМТАРСАН БАГИЙН КЕЙС БҮРТГЭЛ

Судалгааны үр дүнд үндэслэн зорилтот болон хяналтын хамтарсан багуудын кейсийн бүртгэл, үйлчилгээ, гишүүдийн чадамжийг үл хамаарах түүврийн Т тестээр тооцоолон дараах үр дүнг гаргав.

#### Хамтарсан багийн кейс бүртгэл:

Үндэсний түвшинд гарсан стандарт журмын дагуу хамтарсан багийн доорх үзүүлэлтүүдийг кейс бүртгэлд хамруулан 1-5 оноогоор үнэлэв. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын асуудалтай холбоотой мэдээлэл авсан тохиолдолд нийгмийн ажилтан эсвэл хамтарсан багийн гишүүн мэдээллийг маягтын дагуу бөглөдөг.
2. Тухайн кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргадаг.
3. Кейс бүрийг эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажилладаг.
4. Кейс бүр дээр эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээг багийн 2-оос доошгүй хүн хийдэг.
5. Хамтарсан баг хурлын тэмдэглэлээ баримтжуулж, файлдаа хадгалдаг.

#### Хүснэгт 3.2.1 Зорилтот болон хяналтын хамтарсан багийн кейс бүртгэлд өгсөн үнэлгээ

Кейс бүртгэлд хамаарагдах үзүүлэлт	Талбар	Түүвэр	Дундаж	Стандарт хазайлт	Статистик ач холбогдол	Түвшин
Кейс бүртгэл хийх чадамж	Зорилтот	23	4.5826	.46676	.00009	++
	Хяналт	24	3.5667	.99506		
Хүүхэд хамгааллын асуудалтай холбоотой мэдээлэл авсан тохиолдолд, нийгмийн ажилтан эсвэл хамтарсан багийн гишүүн мэдээллийг маягтын дагуу бөглөдөг.	Зорилтот	23	4.304	1.4596	.01215	+
	Хяналт	24	3.167	1.4346		
Тухайн кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргадаг.	Зорилтот	23	4.739	.5408	.00040	++
	Хяналт	24	3.542	1.2847		
Кейс бүрийг аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажилладаг.	Зорилтот	23	4.565	.8958	.17092	-
	Хяналт	24	3.750	1.1887		
Аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээг багийн 2-оос доошгүй хүн хийдэг.	Зорилтот	23	4.609	.7223	.01827	+
	Хяналт	24	3.625	1.2790		
Хамтарсан баг хурлынхаа тэмдэглэлээ баримтжуулж, файлдаа хадгалдаг.	Зорилтот	23	4.696	.4705	.00302	++
	Хяналт	24	3.750	1.1887		

Тайлбар: (++) – эрс ялгаатай, (+) – ялгаатай, (-) – ялгаагүй гэж үзэн ач холбогдлын түвшинг үнэлэв.

Кейс бүртгэлийн хүрээнд судалж үзэхэд төслийн зорилтот хамтарсан багийн дундаж үнэлгээ нь 4.304~4.739 хооронд, харин хяналтын хамтарсан багийн хувьд 3.167~3.750 хооронд хэлбэлзэж байна. Тухайлбал, тухайн кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргах байдал нь төслийн зорилтот хамтарсан баг 4.739 байхад хяналтын хамтарсан баг 3.542 буюу (4.739-3.542) 1.197 нэгжээр өсжээ. Үүнээс зорилтот хамтарсан багийн кейс бүртгэл тогтворжин, сайжирсан байдлыг илтгэнэ.

Кейс бүртгэлд хамрагдсан үзүүлэлтүүдийг үл хамаарлын тестээр итгэх магадлал 95%-иар тооцон шалгаж үзэхэд “t” утга нь эрс ялгаатай үр дүн гараагүй болно. Статистик ач холбогдлын түвшинг  $p \leq 0.05$  тооцож үзэхэд тухайн кейс бүрээр хамтарсан багаар ярилцаж, шийдвэр гаргадаг байдал нь .00040, харин хамтарсан баг хурлынхаа тэмдэглэлээ баримтжуулж, файлдаа хадгалдаг байдал нь .00302 үзүүлэлт гарсан нь зорилтот болон хяналтын хороодын хооронд эрс ялгаа байгааг харууллаа. Мөн мэдээллийн маягтын дагуу бөглөдөг байдал болон аюулын зэрэг, нөхцөл байдлын үнэлгээг багийн 2-оос доошгүй хүн хийдэг зэрэг үзүүлэлтэд мэдэгдэхүйц ялгаатай байдал ажиглагдав.

### **Хүснэгт 3.2.2** Кейс бүртгэлийн үнэлгээг зорилтот болон хамтарсан багаар харьцуулсан байдал

Талбар	Талбарын тоо	Дундаж	Стандарт хазайлт	t утга	Статистик ач холбогдол
Зорилтот хамтарсан баг	23	4.5826	.46676	4.448	.000
Хяналтын хамтарсан баг	24	3.5667	.99506	4.511	.000

Зорилтот хамтарсан багийн дундаж үзүүлэлт нь 4.5826, хяналтын хамтарсан багийн дундаж үзүүлэлт нь 3.5667 байгаа бөгөөд 1.0159 нэгжээр зөрүүтэй байна. Ач холбогдлын түвшинг тооцон үзэхэд кейс бүртгэл зорилтот болон хяналтын хамтарсан багт ялгаатай болох нь нотлогдов.

### **Үйлчилгээний маягтын хэрэглээ**

2015 оны суурь судалгааны үр дүнгээс үзэхэд хамтарсан багийн гишүүдийн 21.4% нь хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт байгаа эсэхийг мэдэхгүй, 16.7% нь ямар нэгэн маягтыг ашигладаггүй, шууд бичиж тэмдэглэдэг бөгөөд нөхцөл байдлын үнэлгээний маягт, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн маягт, хүүхдийн эрсдэлийн маягт, яамдаас баталсан маягт, Нийслэлийн ГБХЗХГ-ын маягт гэх мэтээр харилцан адилгүй ашигладаг байв. Суурь судалгааны хүрээнд хамтарсан багийн зүгээс хэрэглэж байгаа үйлчилгээний олон маягтыг нэгтгэх, ижил нөхцөл, шалгуураар үнэлдэг болгох чиглэлээр зөвлөмж өгч байсан юм.

Төслийн хүрээнд хамтарсан багийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягтуудыг боловсруулж, тухайн үеийн нэршлээр Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын 2016 оны 4 сарын 13 өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан билээ. Эхний бүлэгт дурдсанчлан, эдгээр 13 маягтад ХХ01-Хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягт, ХХ02-Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхэд хүлээн авах бүртгэлийн маягт, ХХ03-Хүүхдийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ, ХХ04-Гэр бүлийн нөхцөл байдал, хэрэгцээний үнэлгээ, ХХ05-Кейс төлөвлөгөөний маягт, ХХ06-Аюулгүй байдлын төлөвлөгөө, ХХ07-Ярилцлагын тэмдэглэл,

ХХ08- Үйл явцын тэмдэглэл, ХХ09-Холбон зуучлах маягт, ХХ10-Кейс шилжүүлэх маягт, ХХ11-Буцаах маягт, ХХ12-Кейсийг хаах, ХХ13-Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын тооцоо зэргийг оруулжээ (ХАХНХЯ, ХИС, 2016).

Хорооны хэсгийн байцаагч нарын хувьд Хуульзүй, дотоод хэргийн Сайдын 2017 оны 02 сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан Аюулын зэргийн үнэлгээ хийх журмын хавсралт маягтыг ашигладаг. Эдгээр маягтуудыг хэвлэмэл байдлаар төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүд ашиглах болсныг судалгааны үр дүнгээс харж болно.

**График 3.2.1** Үйлчилгээний маягтаа хэрэглэх үр чадвар нэмэгдсэн байдал (n=47)




График 3.2.1-ээс харахад судалгаанд зорилтот хамтарсан багийн 23 гишүүний 69.2% нь тэдний маягтуудыг ашиглах үр чадвар нэмэгдсэнтэй бүрэн санал нийлнэ гэжээ. Харин хяналтын хамтарсан багийн хувьд дөнгөж 16.7%-ийг эзэлж байна. Төслийн зүгээс хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, маягтуудыг практикт хэрхэн хэрэглэх талаар зөвлөн тусалж, тэдэнд холбогдох үр чадварыг олгосноос энэ үр дүн гарчээ.

### Шигтгээ 3.2.1 Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягтуудыг ашиглах байдал

Нөхцөл байдлын үнэлгээний маягт, кейс менежмент хийхэд 13 маягт байдаг, тэдгээрийгээ бариад явдаг. Шинээр санаачлаад мэдүүлгийн хуудас, аюулгүй ажиллагааны дүрэм, хуулийн танилцуулах хуудас, итгэлцлийн гэрээ гэж нэмж хийсэн байгаа.

Хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээлэл хүлээн авах маягт, бүртгэлийн маягт, эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний маягт, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээний маягт, төлөвлөгөөний маягт зэрэг нийт 13 маягт байна. Бүх маягтуудыг ашигладаг.

Үйлчилгээний маягт хэрэглэх үр чадвар нэмэгдсэн. Нэлээн туршлагажиж байна.

(Хамтарсан багийн гишүүний ярилцлагаас)

### Хүснэгт 3.2.3 Зорилтот болон хяналтын хамтарсан багийн маягт ашигладаг байдал (n=18)

Маягтууд	Баг, хорооны түвшинд																	
	Төслийн зорилтот хамтарсан баг									Төслийн хяналтын хамтарсан баг								
	ЧД, 9 хороо	ЧД, 10 хороо	БЗД, 27 хороо	БЗД, 23 хороо	СХД, 2 хороо	СХД, 10 хороо	Архангай, Хайрхан сум	Архангай, Батцэнгэл сум	Архангай, Эрдэнэбулган сум	ЧД, 7 хороо	ЧД, 12 хороо	БЗД, 7 хороо	БЗД, 16 хороо	СХД, 13 хороо	СХД, 20 хороо	Архангай, Эрдэнэбулган сум, 1-р баг	Архангай, Ихтамир сум, төвийн баг	Архангай, Өндөр-Улаан сум, төвийн баг
Маягт ХХ01	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
Маягт ХХ02	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
Маягт ХХ03	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
Маягт ХХ04	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	+	+	+	-	-	-
Маягт ХХ05	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ06	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ07	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ08	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ09	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ10	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ11	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ12	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-
Маягт ХХ13	+	+	+	+	+	+	+	+	+	-	-	-	-	-	-	-	-	-
Аюулын зэргийн үнэлгээний маягт					+						+	+		+	+			+
Эрүүл мэндийн маягт		+	+	+			+	+								+	+	+

Тайлбар: Зөвхөн судалгаанд оролцсон хэсгийн ахлагч, эмч нарын мэдээлэлд үндэслэн аюулын зэргийн үнэлгээ, эрүүл мэндийн маягтуудыг ашигладаг байдлыг үнэлэв.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.4 заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан нь тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлдэг байна (УИХ, 2016). Мөн аймаг, дүүргийн ГБХЗХХ дээр хамтарсан багийн үйл ажиллагааг хариуцдаг мэргэжилтэнтэй болсон бөгөөд сар бүр сум/баг/хорооны хамтарсан баг өөрийн үйл ажиллагааны тайландаа үйлчилгээний маягтуудыг бөглөж оруулах шаардлагатай байдаг.

### Шигтгээ 3.2.2 Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягтуудыг ашиглах байдал

Халамжийн мэргэжилтэн гэхэд хуульд хамтарсан багийн гишүүн гээд оруулаад ирсэн атлаа хамтарсан багийн гишүүдийн үүрэг, оролцоог нь задлахдаа хамтарсан багт орсон халамжийн мэргэжилтний үүрэг, оролцооны талаар ганц ч өгүүлбэр байхгүй байна. Тэгээд ядаж л нийгмийн ажилтны эзэнгүйд халамжийн мэргэжилтэн эрсдэлийн үнэлгээг хийх, тэр маягттай ажиллах чадвар хэрэгтэй байна. Хамтарсан багийн бүх гишүүд хүүхэд хамгааллын үйлчилгээний маягтуудыг бөглөчихдөг байвал зүгээр.

(Хамтарсан багийн гишүүний ярилцлагаас)



**Зураг 3.2.1** Зөрчлийн мэдээллийг бүртгэсэн байдал




**Зураг 3.2.2** Хамтарсан багийн үйл ажиллагааны тайлан, баримтжуулалт


Судалгааны явцад СХД-ийн ГБХЗХХ-ийн хамтарсан багийг хариуцсан мэргэжилтэн нийт 32 хорооны 48 хамтарсан багийн гишүүдийг хамруулсан Фэйсбүүк хаяг нээн, мэдээллийн маягтуудыг байршуулан, хэрхэн бөглөх талаар зөвлөгөө мэдээллээр ханган ажилладаг сайн туршлага бий болжээ.

Хамтарсан багийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягтуудыг гол төлөв нийгмийн ажилтан бөглөдөг бөгөөд зарим гишүүн маягтуудын талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байв. Энэ нь хяналтын хамтарсан багийн гишүүдийн хувьд илүү ажиглагдсан болно.

Төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 69.6% нь дээрх маягтуудыг бөглөх мэдлэг чадвартай болсон төдийгүй ажилдаа ашигладаг гэдэгтэй бүрэн санал нийлж байгаа нь хяналтын хамтарсан багтай харьцуулахад 4 дахин их үзүүлэлт юм. Энэ нь зорилтот хамтарсан багийн үйл ажиллагаа жигдэрч, нэг стандартыг баримталдаг болсноор асуудалд бодитой хандах, хүүхдэд чанартай үйлчилгээ үзүүлэх болсныг харуулж байна.



**Зураг 3.2.3** Аюулын зэргийн үнэлгээний маягт




**Зураг 3.2.4** Ярилцлагын тэмдэглэл

### Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ

2015 онд хийгдсэн суурь судалгааны үр дүнгээр хамтарсан багийн гишүүдэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртсөн хүүхдэд эрсдэлийн болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх туршлага, ур чадвар дутагдаж байсан юм. Харин энэ удаагийн судалгаагаар төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 52,3% нь хүүхдийн аюулын зэргийн болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ сайжирсан гэдэгтэй бүрэн санал нийлж байгаа бол хяналтын хамтарсан багийн гишүүдийн дөнгөж 25% нь ийм хариулт өгсөн байна. Ийнхүү хүүхдийн аюулын зэрэг болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ сайжирсан нь хамтарсан багийн гишүүд чадавхжуулах сургалтуудад хамрагдсан, тэдэнд төслийн мэргэжилтнүүдийн зүгээс мэргэжил, аргазүйн зөвлөгөөг сард нэг удаа, шаардлагатай тохиолдолд өдөр бүр нийгмийн сүлжээгээр холбогдож яаралтай өгч байсантай шууд холбоотой.

Төсөл хэрэгжихээс өмнө кейс бүрийг аюулын зэрэг болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажиллах нь хангалтгүй, мөн ямар тохиолдолд кейс нээж ажиллах талаар мэдлэг тун доогуур байсан юм. Харин төсөл хэрэгжсэнээс хойш хамтарсан баг хүүхэд хамгааллын кейс бүрийг эрсдэлийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажилладаг болсон гэдэгтэй судалгаанд оролцсон төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 73,9% нь бүрэн санал нийлж байна. Харин энэ талын асуултад хяналтын хамтарсан багийн гишүүдийн 35% орчим нь санал нийлж байгаагаа хэлжээ.

**График 3.2.2** Хүүхдийн аюулын зэргийн болон эрсдэлийн үнэлгээ сайжирсан (n=47)



**График 3.2.3** Кейс бүрийг эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан нээж ажилладаг болсон (n=47)



2015 оны суурь судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээг ихэнхдээ нийгмийн ажилтан ганцаараа хийдэг байсан бол энэ удаагийн судалгаанд хамрагдсан төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 69,6% нь дээрх үнэлгээг 2-оос доошгүй хүн хамтарч хийдэг болсон гэж хариулсан юм. Харин төслийн хяналтын хамтарсан багийн хувьд хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг нийгмийн ажилтан урьдын адил ганцаараа хийж байгаа нь харагдаж байна. Энэ нь цагдаа, эмч, сургуулийн нийгмийн ажилтан зэрэг хамтарсан багийн гишүүдийн ажил үүрэгт байгууллагуудын удирдлагын зүгээс ач холбогдол төдийлөн өгдөггүй, тэдгээр мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээнд хамтарсан багийн үйл ажиллагаа тусагдаагүй зэрэг шалтгаантай холбоотой гэжээ.



### Шигтгээ 3.2.3 Аюулын зэргийн үнэлгээ

Бид хүүхдийн талаарх мэдээлэл ирэнгүүт асуудлыг нь харгалзаад хамтарсан багийн гишүүдээс хэн, хэн эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээнд явахаа нийгмийн ажилтантайгаа ярилцаж байгаад шийддэг.

Би нийгмийн ажилтан хийгээд 4 жил болж байгаа, хүүхдийн 108 утаснаас мэдээлэл ирэхэд би өөрөө очиж авдаг. Манай цагдаа уг нь сэтгэл сайтай хамтарч нөхцөл байдлын үнэлгээнд явдаг, идэвхтэй ажиллах гэдэг боловч цагдаагийн хэлтсийн дарга нь хамтарсан багийн ажлыг ойлгодоггүй, тэр хороон дээрээ очиж ажилла, би өөр цагдаа ажилд авна гэж дарамталдаг.

(Хяналтын хорооны нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагаас)

## 3.3 ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### Үйлчилгээ:

Үндэсний түвшинд гарсан стандарт журмын дагуу хамтарсан багийн доорх үзүүлэлтүүдийг үйлчилгээнд хамруулан 1-5 оноогоор үнэлэв. Үүнд:

1. Кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг.
2. Кейс төлөвлөгөөний дагуу, хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг.
3. Үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг.
4. Кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаадаг.

### Хүснэгт 3.3.1 Зорилтот болон хяналтын хамтарсан багийн үйлчилгээнд өгсөн үнэлгээ

Үйлчилгээнд хамаарагдах үзүүлэлт	Талбар	Түүвэр	Дундаж	Стандарт хазайлт	Статистикийн ач холбогдол	Түвшин
Үйлчилгээ үзүүлэх чадамж	Зорилтот	23	4.5761	.55614	.0001	++
	Хяналтын	24	3.5521	1.00266		
Кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг.	Зорилтот	23	4.783	.4217	.00070	++
	Хяналтын	24	3.458	1.1025		
Кейс төлөвлөгөөний дагуу хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг	Зорилтот	23	4.739	.4490	.00832	++
	Хяналтын	24	3.875	1.1539		
Үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг	Зорилтот	23	4.652	.4870	.00780	++
	Хяналтын	24	3.708	1.1221		
Кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаадаг.	Зорилтот	23	4.130	1.7137	.78556	-
	Хяналтын	24	3.167	1.5788		

Тайлбар: (++) – эрс ялгаатай, (+) – ялгаатай, (-) – ялгаагүй гэж үзэн ач холбогдлын түвшинг үнэлэв.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд зорилтот хамтарсан багийн дундаж үнэлгээ нь 4.130-4.738 хооронд, харин хяналтын хамтарсан багийн хувьд 3.167-3.875 хооронд хэлбэлзэж байна. Тухайлбал, кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах хүрээнд зорилтот хамтарсан баг 4.738 байхад хяналтын хамтарсан баг 3.458 буюу дунджаар (4.738-3.458) 1.28 нэгжээр өсжээ. Үүнээс зорилтот хамтарсан багийн хувьд кейс дээр төлөвлөгөөний дагуу ажиллах чадвар нэмэгдсэн нь харагдаж байна.


Үйлчилгээнд хамрагдсан үзүүлэлтүүдийг үл хамаарлын тестээр итгэх магадлал 95%-иар тооцон шалгаж үзэхэд “Т” утга нь эрс ялгаатай үр дүн гараагүй болно. Статистик ач холбогдлын түвшинг  $p \leq 0.05$  тооцож үзэхэд кейс нээсний дараа хамтарсан багаараа кейс төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг байдал нь .00070, кейс төлөвлөгөөний дагуу хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг нь .00832, үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг нь .00780 гэсэн үзүүлэлттэй гарсан бөгөөд энэ нь зорилтот болон хяналтын хороодын хооронд эрс ялгаа байгааг харуулав. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд хамтарсан багийн үйлчилгээ нь зорилтот болон хяналтын хороодод ялгаатай байна.

### Хүснэгт 3.3.2 Үйлчилгээний үнэлгээг зорилтот болон хяналтын хамтарсан багаар харьцуулсан байдал

Талбар	N	Дундаж	Стандарт хазайлт	t утга	Статистик ач холбогдол
Зорилтот хамтарсан баг	23	4.5761	.55614	4.303	.000
Хяналтын хамтарсан баг	24	3.5521	1.00266	4.353	.000

Зорилтот хамтарсан багийн дундаж үзүүлэлт нь 4.5761, хяналтын хамтарсан багийн дундаж үзүүлэлт нь 3.5521 байгаа бөгөөд 1.024 нэгжээр зөрүүтэй байна. Ач холбогдлын түвшинг тооцон үзэхэд үйлчилгээ нь зорилтот болон хяналтын хамтарсан багт ялгаатай харагдлаа.

### График 3.3.1 Хүүхдэд үзүүлэх хамтарсан багийн үйлчилгээний чанар сайжирсан



Хамтарсан багийн үйлчилгээний чанар сайжирсан эсэх талаар асуухад төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн 60,9% нь эерэг хариулт өгснийг хяналтын хамтарсан багийн гишүүдийн хариулттай харьцуулахад 2 дахин их байна. Энэ нь төслийн үр дүнд нэг талаас хамтарсан багийн үйлчилгээг хүргэх багийн гишүүдийн ур чадвар нэмэгдсэн, нөгөө талаас удирдлагын зүгээс хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг ойлгох, дэмжих явдал сайжирсныг харуулж байна.

### Шигтгээ 3.3.1 Хамтарсан багийг дэмжин ажиллаж буй сайн туршилага

Төсөл хэрэгжихээс өмнө би яг нийгмийн ажилтныхаа гол үүргийг 30%-д нь хийдэг байсан, үлдсэн 70%-д нь хорооны захиргааны, бүртгэл судалгаа болон бусад ажлыг хийдэг байсан. Харин төсөл хэрэгжиж эхэлснээс хойш манай хорооны засаг дарга хамтарсан багийн үйл ажиллагааг маш сайн ойлгож, би 70%-д нь нийгмийн ажил, хамтарсан багийн ажлаа хийдэг, үлдсэн 30%-д нь хорооны бусад ажлаа хийдэг болсон. Энэ нь хамтарсан багийн үйл ажиллагаа, ялангуяа нийгмийн ажилтныг дэмжсэн том дэм, төслийн том үр нөлөө гэж үзэж байна.

(Хамтарсан багийн гишүүнтэй хийсэн ярилцлагаас)

Хүүхэд хамгааллын үйлчилгээний үе шатын дагуу шаардлагатай кейс бүрээр хавтас нээх, хүүхдийн бүртгэл анкет хөтөлж, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, тухайн хүүхдийн талаар хамтарсан багийн хуралдааны тэмдэглэл, эмнэлэг, цагдаагийн байгууллагын магадлагаа баримт бичгийг авах, үйлчилгээний маягтуудыг хөтөлж, үйл явцын тэмдэглэл үйлдэх, кейс төлөвлөгөө боловсруулан кейс бүрээр хамтарсан багаар ярилцах, шийдвэр гарган хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа гэдэгтэй төслийн зорилтот хамтарсан багийн бараг бүх гишүүд санал нэгтэй байна.

**Хүснэгт 3.3.3** Хамтарсан багийн кейс бүртгэл болон үйлчилгээний үр дүн, 2015, 2018 оноор (n=9)

Зорилтот хороо	Үйлчилгээ 2015 он	Кейс бүртгэл (а) 2018 он	Үйлчилгээ (б) 2018 он
СХД 2 хороо	тийм	4.33	4.58
СХД 10 хороо	үгүй	4.50	3.87
ЧД 9 хороо	тийм	4.66	4.33
ЧД 10 хороо	үгүй	4.70	4.50
БЗД 23 хороо	тийм	4.40	4.87
БЗД 27 хороо	үгүй	4.30	4.75
Архангай, Эрдэнэбулган ,4-р баг	үгүй	4.60	4.50
Архангай, Хайрхан, Өгөөмөр баг	үгүй	4.66	4.83
Архангай, Батцэнгэл, 6-р баг	үгүй	4.93	4.83


*Тайлбар: Хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэхдээ бүртгэлийн маягт хөтлөх, аюулын зэрэг болон нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан кейс нээх, кейс төлөвлөгөөг боловсруулах, кейс төлөвлөгөөний дагуу үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний явцад хяналт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн кейс хаах зэрэг үе шатуудын дагуу хийдэг байдал дээр үндэслэн 2015 оны нөхцөл байдлыг “тийм” ба “үгүй” гэсэн үзүүлэлтээр үнэллээ.*

2015 онд хийгдсэн суурь судалгааны үр дүнг шинжлэн үзэхэд хамтарсан багийн үйлчилгээ үзүүлсэн болон үзүүлээгүй гэсэн үзүүлэлтээр хэмжсэн байна. Иймд 2018 онд хийгдсэн төслийн эцсийн үнэлгээний үр дүнтэй харьцуулах боломжгүй юм. Гэвч өөрчлөлт гарсан эсэхийг дараах байдлаар авч үзэв.


Төслийн эхлэл үед зорилтот хамтарсан багийн гишүүдийн 30.4% нь ямар нэгэн маягтыг ашигладаггүй, кейс бүртгэлийн талаарх ойлголт мэдлэг дутмаг байв. Мөн хуралд ирсэн 2-3 гишүүн хуралдах, гэр бүлийн гишүүдийн оролцоогүйгээр кейс менежментийн төлөвлөгөөг гаргах, хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээнүүдийг ангилан цаг хугацааны дэс дараалалтай төлөвлөж чадахгүй байдал ажиглагдаж байсан нь хүүхдэд үзүүлэх үйлчилгээг сааруулж, үйлчилгээний чанарт нөлөөлж болзошгүй сул тал байлаа.

Төслийн төгсгөл шатанд зорилтот хамтарсан багийн гишүүдийн кейс бүртгэлийн дундаж үзүүлэлт нь 4.76, үйлчилгээ үзүүлэх ур чадварын дундаж үзүүлэлт нь 4.6 байгаа нь хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, маш сайжирсныг гэрчилж байна.

**График 3.3.2** Кейс төлөвлөгөөний дагуу, хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг



**График 3.3.3** Үйлчилгээний явцад болон дараа хяналт, үнэлгээ хийдэг



Төслийн зорилтот хамтарсан гишүүдийн 90% гаруй нь нийгмийн ажилтны кейс менежерийн үүрэг, ур чадвар сайжирсан гэж хариулсан нь хамтарсан багийн хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй, хүртээмжтэй, шуурхай хүргэхэд нэг талаас кейс төлөвлөгөөг удирдан зохицуулах нийгмийн ажилтны мэдлэг, ур чадвар туршлага нэмэгдсэн. Нөгөө талаас тухайн хүүхдэд тохиолдсон асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай үйлчилгээний багцыг тодорхойлон, төлөвлөж, тэдгээрийг уялдуулан зохицуулж холбогдох байгууллага, мэргэжилтний тусламж

### Шигтгээ 3.3.2 Кейсийн асуудлыг шийдвэрлэсэн тухай

Би 4 хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй, надад эцэг эх, ах дүү байхгүй. Манай хорооны хамтарсан баг 6 сар манайд тусалсан. Кейс төлөвлөгөө гэж нээгээд надад танилцуулсан. Үүний дагуу би ажилтай болсон. 2 хүүхэд маань цэцэрлэгт орсон. Би айлын хашаанд гэрээ бариад амьдарч байтал хашаагаа зарна гээд хөөгдсөн. Тэгээд хорооны засаг дарга хогийн цэг байсан газрыг цэвэрлээд буучих гэсэн. Хороо маань хог ачих машин, хашаа барих материалаар тусалсан. Хамтарсан баг маань хөөцөлдөж газрыг миний нэр дээр болгосон. Хамтарсан баг надад туслаагүй бол хэцүүдэх байсан шүү.

(Кейс ярилцлагаас)

дэмжлэгийг авч чадаж байгаатай холбоотой. Тиймээс кейс менежментийн үйлчилгээг нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтийн дагуу хүүхэд, гэр бүлийн давуу талд тулгуурлан хүргэж, хамтарсан багийн гишүүд кейстэй ажиллах, хүүхэдтэй харилцах арга барилд суралцаж, кейсийг нээх, интервенци хийх, үнэлэх, хаах зэргээр үйлчилгээг амжилттай хэрэгжүүлж байгаа нь төслийн эцсийн үнэлгээний үр дүнгээс харагдаж байв. Мөн төслийн зүгээс хот, хөдөөгийн баг, хорооны хамтарсан багуудын дунд харилцан мэдээлэл туршлага солилцох аялал хийсэн нь маш үр дүнтэй үйл ажиллагаа болсныг хамтарсан багийн гишүүд үнэлж байна.

Хамтарсан багийн гишүүд өөрсдийн зүгээс үзүүлэх боломжгүй нарийн мэргэжлийн үйлчилгээнд хүүхэд, гэр бүлийг зуучилдаг билээ. Төсөл эхлэх үед хамтарсан багийн гишүүд гол төлөв баримт бичиг олгох, эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйлчилгээнд хамруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах үйлчилгээг үзүүлж байв. Тухайлбал, 2015 оны суурь судалгааны тайланд хамтарсан багууд амьжиргааны төвшин доогуур өрхийг хүнсний талон хөтөлбөрт хамруулах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах байранд байрлуулах, төрийн бус байгууллагад хандан хүнд, эрсдэлт нөхцөлд байгаа өрхөд гэр авч өгөх, хүүхдүүдийг хувцас, хичээлийн хэрэглэлээр хангах, түлээ түлш өгөх, завсардсан хүүхдийг сургуульд хамруулах гэх мэт үйлчилгээг түлхүү үзүүлж байсныг дурджээ. Харин төсөл хэрэгжсэнээр хамтарсан багаар холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх байдал жилээс жилд нэмэгдэх хандлагатай болжээ. Ялангуяа төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн хувьд энэ үйлчилгээг үзүүлэх тал дээр харилцан адилгүй байна.

### Хамтарсан багийн кейс менежментийн үйлчилгээ

Төслийн эцсийн үнэлгээгээр 2016 оноос хойш зорилтот хамтарсан багийн хувьд кейс бүртгэх, кейс дээр ажиллах байдал нэмэгдэн, гишүүдийн кейсийн талаарх ойлголт, мэдлэг дээшлэн, кейс дээр ажиллах туршлагатай болсон байна. Харин хяналтын хамтарсан багийн хувьд кейстэй ажиллах байдал харьцангуй бага, хамтарсан багийн үйл ажиллагаа тогтворжоогүй, багаар ажиллах зохион байгуулалт сул байгаа нь анзаарагдаж байна.

#### Хүснэгт 3.3.4 Зорилтот хамтарсан багийн бүртгээгдсэн кейсийн тоо (n=9)

Зорилтот орон нутаг	2015 он	2017 он
СХД 2 хороо	9	10
СХД 10 хороо	тодорхойгүй	15
ЧД 9 хороо	19	16
ЧД 10 хороо	тодорхойгүй	21
БЗД 23 хороо	50	17
БЗД 27 хороо	тодорхойгүй	16
Архангай, Эрдэнэбулган, 4-р баг	3	1
Архангай, Хайрхан, Өгөөмөр баг	тодорхойгүй	3
Архангай, Батцэнгэл, 6-р баг	3	3
<b>Нийт</b>	<b>84</b>	<b>102</b>

Тайлбар: тодорхойгүй – бүртгээгдсэн кейсийн талаарх нотлох баримт байгаагүй.

Хүснэгт 3.3.4-өөс харахад 2015 онд хамтарсан багт ирсэн мэдээлэл бүрийг кейс гэж бүртгэж байсан нь зарим хороодын 2017 онд бүртгэсэн кейсийн тоо харьцангуй бага харагдахад нөлөөлсөн байх талтай. Зорилтот орон нутгийн хамтарсан багийн бүртгэгдсэн кейсийг 2015 болон 2017 онтой харьцуулан үзэхэд 28.1%-иар нэмэгдсэн байна. Иймд төслийн хүрээнд зорилтот орон нутгийн хамтарсан багийн бүртгэгдсэн кейсийг багадаа 25%-иар нэмэгдүүлнэ гэсэн зорилгыг хангасан гэж үзлээ.

**Хүснэгт 3.3.5 Хамтарсан багийн кейстэй ажилласан байдал (n=18)**

Кейсийн үзүүлэлт	Он	Сум, баг, хорооны түвшинд																	
		Төслийн зорилтот хамтарсан баг									Төслийн хяналтын хамтарсан баг								
		ЧД, 9 хороо	ЧД, 10 хороо	БЗД, 27 хороо	БЗД, 23 хороо	СХД, 2 хороо	СХД, 10 хороо	Архангай, Хайрхан сум	Архангай, Батцэнгэл сум	Архангай, Эрдэнэбулган сум	ЧД, 7 хороо	ЧД, 12 хороо	БЗД, 7 хороо	БЗД, 16 хороо	СХД, 13 хороо	СХД, 20 хороо	Архангай, Эрдэнэбулган сум, 1-р баг	Архангай, Ихтамир сум, Төвийн баг	Архангай, Өндөр-Улаан сум, Төвийн баг
Ажилласан кейсийн тоо	2015	15			34	24			1	3	2	8	2	21	36	4		1	
	2016	20	12		34	18	76	2	7	9	22	17	22	23	2	7		1	3
	2017	25	18	28	17	20	18	5	5	12	10	25	10	4	2	14	1	1	3
Холбон зуучилсан кейсийн тоо	2015	2			32	3								3					
	2016	2			32	2		2			1		12	4			1		
	2017	2	2	28	2	4	11	5		2	14	7		5	1		3		
Шилжүүлсэн кейсийн тоо	2015	2				4													
	2016	2				2					2								
	2017	3	1	1		2				2	2				1		1	1	
Хаагдсан кейсийн тоо	2015	1			15	10			1		2	8			1	1			
	2016	2			10	8	6	2	5	1	12	17			2	3			3
	2017	1			4	6	12	6	4	1	8	16		2	2	14	1	1	3
Зөвлөгөө өгсөн	2015	52		17	170	146	30		5	20		3		11	13	10		1	
	2016				4		30	7	3	10	25	5		13	21			2	
	2017			60	3		45	8	1	45	6	8		9	16		12	2	1

Тайлбар: Зөвхөн хорооны нийгмийн ажилтны мэдээлэлд тулгуурлав.

Хамтарсан багууд амьжиргаа доогуур, эцэг эх нь ажилгүй, орлогогүй, архины хамааралтайгаас болж хүүхдүүд үл хайхрагдсан, гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд байгаа, эцэг эх, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэйгээс хүүхдээ асран хамгаалах боломжгүй, хүүхдээр


хөдөлмөр эрхлүүлдэг, гуйлга гуйлгадаг, бичиг баримтгүй гэх шалтгаанаар нийгмийн халамжийн үйлчилгээ авч чадахгүй зэрэг асуудлаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, кейс төлөвлөгөөний дагуу хүүхэд болон гэр бүлд үйлчилгээ үзүүлж, амжилттай шийдвэрлэж байгааг хамтарсан багийн гишүүнтэй хийсэн болон кейсийн ярилцлагын үр дүнгээс харж болох юм.

**График 3.3.4** Ажилласан кейсийн тоо



Хамтарсан багийн гишүүдийн ажиллаж буй кейсийн шалтгааныг төсөл эхлэх болон дуусах үетэй харьцуулан судалж үзэв. Төслийн эхэн үед зорилтот хамтарсан багийн гишүүд гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй (32.7%) ихэнхдээ ажиллаж байсан бол хяналтын хамтарсан багийн гишүүд хараа хяналтгүй орхисон, үл хайхрагдсан эсвэл хаягдсан хүүхэд (23.1%) болон архины хамааралтай гэр бүлд байгаа хүүхэдтэй (17.9%) түлхүү ажиллаж байв. Төслийн эцсийн үнэлгээгээр кейсийн шалтгааныг жөндөрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд болох гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд тулгуурлан нарийвчлан судалж үзлээ. Сүүлийн 3 жилд төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдийн ажилласан кейсийн шалтгаан нь газар зүйн байршил, төсөлд хамрагдсан эсэхээс үл хамааран адилхан байгааг харж болно. Кейсийн үндсэн шалтгаанд бие махбод, сэтгэл санааны болон үл хайхрах хүчирхийлэл зонхилох хандлагатай байгаа бол бэлгийн хүчирхийлэл, хүүхдийг хөдөлмөр эрхлүүлэх, гуйлга гуйлгах шалтгаанаас үүссэн кейсийн эзлэх хувь 6-11 байна.

**График 3.3.5** Хамтарсан багийн гишүүдийн ажилласан кейсийн шалтгаан



2015 оны суурь судалгааны үр дүнгээс харахад хамтарсан багийн гишүүдийн зүгээс кейстэй ажиллах арга барил дутмаг, кейсийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй, кейсийг нээх, ажиллах, үнэлэх, хаах зэрэг үйлчилгээний үе шат, дарааллын талаар мэдлэг байхгүй байсан. Хамтарсан багт ирсэн мэдээлэл, дуудлага бүрийг нөхцөл байдлын болон эрсдэлийн үнэлгээ хийхгүйгээр шууд кейс гэж үзэх хандлага түгээмэл байв.

**График 3.3.6** Холбон зуучилсан кейсийн тоо



Хамтарсан багийн гишүүдийн хийсэн нөхцөл байдлын үнэлгээнээс үзэхэд хүүхдэд тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд иргэнийг баримт бичигтэй болгох, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, боловсрол олгох, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, хүүхдийг хамгаалах, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамруулах зэргээр холбогдох эрх бүхий байгууллагуудад холбон зуучлах үйлчилгээг түгээмэл үзүүлдэг байна. Мөн бусад шаардлагатай үйлчилгээг төр, дотоодын болон олон улсын байгууллагаас үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээтэй холбон зуучилж байна. Тухайлбал, нийслэлийн ГБХЗХГ, дүүргийн ГБХЗХХ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хамгаалах байрууд, иргэний бүртгэлийн байгууллага, 2-р шатлалын эмнэлгүүд, асрамж халамжийн төвүүд зэрэг байгууллагууд байна.

**График 3.3.7** Шилжүүлсэн кейсийн тоо



Төслийн эцсийн үнэлгээнд хамрагдсан хамтарсан багийн гишүүдийн кейс шилжүүлэх үйлчилгээг судлан үзэв. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй ажиллах хугацаа дуусаж, үйлчлүүлэгч амьдран буй газраа өөрчлөн өөр нийгмийн ажилтантай ажиллах эсвэл нийгмийн ажилтан өөрөө өөрчлөгдөх үед кейсийг шилжүүлдэг. Төслийн эхлэл шатанд ажиллаж байсан нийгмийн ажилтнуудын тодорхой хэсэг нь солигдсонтой холбоотойгоор, үйлчлүүлэгчийн асран хамгаалагч хуулийн дагуу өөрчлөгдсөнтэй холбоотойгоор кейс шилжүүлэх явдал гарч




байсан нь харагдаж байна. Кейс шилжүүлэлтийн тал дээр төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн хувьд ижил нөхцөл байдал ажиглагдсан болно. Хяналтын хамтарсан багуудаас 2015 онд нэг ч кейс шилжүүлэх үйлчилгээ хийгээгүй бол 2016-2017 онд хамтарсан багийн гишүүдийн ойлголт мэдлэг тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаатай холбоотой энэ талын үйлчилгээг үзүүлэх болсон нь сайшаалтай.

### Шигтгээ 3.3.3 Шилжүүлсэн кейсийн мэдээлэл

Эцэг эх нь зуурдаар нас барснаас болж бүтэн өнчин болсон 4 хүүхдэд асран хамгаалагч тогтоох ажлыг хэд хэдэн удаагийн хуралдаанаар ярилцан, өөр дүүргийн нутаг дэвсгэрт орших нагац эмээг нь асран халамжлагчаар тодорхойлсон бөгөөд энэхүү кейсийг үйлчлүүлэгчийн шилжин явахтай холбоотой өөр нийгмийн ажилтанд шилжүүлсэн.

(Хамтарсан багийн гишүүний ярилцлагаас)


График 3.3.8 Ажилласан болон хаагдсан кейсийн тоо



Үйлчлүүлэгч, түүний гэр бүл үйлчилгээг үргэлжлүүлэн авах шаардлагагүй болсон эсвэл амьдралын хэвийн нөхцөлд эргэн орсон тохиолдолд кейсийг хаадаг. Суурь судалгааны тайланд кейсийн хэрэгжилтэд гол төлөв хамтарсан багийн гишүүд хяналт тавьж, сард нэг удаа айл өрхөөр хэд хэдэн удаа очиж хүүхдийн нөхцөл байдалтай танилцах, хүүхэд болон асран хамгаалагчтай ярилцах, айл хөршөөс асууж лавлах зэрэг арга замаар үйлчилгээний үр дүнг үнэлсний дараа кейсийг хаадаг байв. 2015 онд төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн хувьд энэхүү туршлага нийтлэг ажиглагдаж байв. Төслийн үр дүнд зорилтот хамтарсан багийн гишүүдийн кейстэй ажиллах ур чадвар нэмэгдсэнтэй холбоотой хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан зарим тохиолдолд Засаг даргын тамгын газраас нөхцөл байдалтай танилцах, ярилцах, тэмдэглэл хөтлөх байдлаар хэд хэдэн удаа зочилж, үйлчилгээний үр дүнг дүгнэдэг болсон байна. Зорилтот хамтарсан багийн хувьд өрхөд 7 хоногт нэг удаа зочилдог мэдээ байна. Хяналтын хамтарсан багийн хувьд кейс хаасан тоо зорилтот хамтарсан багаас их байгаа нь кейсийг гол төлөв холбон зуучлах үйлчилгээгээр дуусгавар болгодогтой холбоотой гэж үзэж болно.

**График 3.3.9** Кейс үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаадаг

Энэ удаагийн судалгаанд оролцсон зорилтот хамтарсан багийн гишүүдийн 72,7% нь үнэлгээний үр дүнд үндэслэн кейсийг хаадаг гэсэн бөгөөд энэ хариултын хувь хяналтын хамтарсан багийн гишүүдтэй харьцуулахад 2 дахин их байна. Кейсийн үйлчилгээний хэрэгжилтэд хамтарсан багийн гишүүд хяналт тавьж ажиллахдаа хүүхдийн гэрээр очиж, хүүхэд, эцэг эхтэй ярилцах, айл хөршөөс асууж лавлах, үйлчилгээний үр дүн баттай гарсан эсэхэд үнэлгээ өгч, үйлчилгээний явцад болон дараах нөхцөл байдалд хяналт тавьж, үйл явцын тэмдэглэл хөтлөн, үр дүн хангалттай гэж үзвэл кейсийг хаадаг байна. Гэхдээ зорилтот хамтарсан багийн гишүүдийн зүгээс кейсийг хурдан хаахыг эрмэлздэггүй, харин кейсийн үйлчилгээний үр дүн баттай гарсан тохиолдолд кейсийг хаадаг болохоо судалгааны үед илэрхийлж байлаа.

**График 3.3.10** Зөвлөгөө өгсөн хүний тоо

Төслийн эхэн үед зорилтот хамтарсан багийн гишүүд зөвлөгөө гэдэгт кейсийн хүрээнд өгсөн зөвлөгөөнөөс гадна эцэг эх, гэр бүлд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд, стресс тайлах, тайвшруулах, бэрхшээлтэй асуудлыг сонсох, шийдвэрлэх зэрэг бүхий л асуудлаар өгсөн зөвлөгөөг хамруулан хэлж байжээ. Тиймээс 2015 оны хамтарсан багийн гишүүдээс өгсөн зөвлөгөө нь хэт өндөр үзүүлэлттэй гарсан юм. Ялангуяа, СХД-ийн 2-р хороо, БЗД-ийн 23-р хороо бусад хамтарсан багаас нэлээн өндөр тоон үзүүлэлттэй байгааг хүснэгт 3.3.6-аас харж болно. Төслийн дунд болон төгсгөлийн шатны үед зорилтот хамтарсан багуудын хүүхдэд зөвлөгөө өгсөн тоо жигд тархалттай байгаа бөгөөд 2017 оноос нэмэгдэж ирсэн нь харагдаж

байна. Тухайлбал, СХД-ийн 10-р хороо, БЗД-ийн 27-р хороо, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хамтарсан баг зөвлөгөө өгөх тал дээр идэвх санаачилгатай ажиллаж байна.

### Хамтарсан багийн чадамж

Судалгааны ажлын хүрээнд зорилтот болон хяналтын хамтарсан багийн гишүүдийн чадамжийг судлав.

#### Хүснэгт 3.3.6 Улаанбаатар хотын зорилтот болон хяналтын хамтарсан багийн чадамж (n=27)

	(а) Кейс бүртгэл	(б) Үйлчилгээ үзүүлэх	(а)+(б) Хамтарсан багийн чадамж
<b>Төслийн зорилтот хамтарсан баг</b>			
Дундаж	<b>4.48</b>	<b>4.48</b>	<b>8.96</b>
СХД 2 хороо	4.33	4.58	8.91
СХД 10 хороо	4.50	3.87	8.37
ЧД 9 хороо	4.66	4.33	8.99
ЧД 10 хороо	4.70	4.50	9.20
БЗД 23 хороо	4.40	4.87	9.27
БЗД 27 хороо	4.30	4.75	9.05
<b>Төслийн хяналтын хамтарсан баг</b>			
Дундаж	<b>3.82</b>	<b>3.67</b>	<b>7.49</b>
СХД 13 хороо	3.90	3.37	7.27
СХД 20 хороо	3.80	4.16	7.96
ЧД 7 хороо	4.40	4.25	8.65
ЧД 12 хороо	3.00	3.25	6.25
БЗД 7 хороо	3.60	3.25	6.85
БЗД 16 хороо	4.20	3.75	7.95

Кейс бүртгэлийн хувьд Улаанбаатар хотын төслийн зорилтот хамтарсан багаас хяналтын хамтарсан баг нь (4.48-3.82) 0.66 нэгжээр бага байгаа нь зорилтот хамтарсан багийн гишүүд илүү ур чадвартай байгааг гэрчилж байна. Үйлчилгээ үзүүлэх тал дээр хяналтын хамтарсан багийн чадамж зорилтот хамтарсан багийн чадамжаас доогуур үзүүлэлттэй болох нь дээрх үр дүнгээс харагдаж байна.

Хамтарсан багийн чадамжийг кейс бүртгэл болон үйлчилгээ үзүүлж байгаа чадвар, мэдлэг дээр үндэслэн тооцоход зорилтот хорооны хамтарсан багийн гишүүдийн чадамж хяналтын хорооны хамтарсан багийн гишүүдээс (8.96-7.49) 1.47 нэгжээр илүү байгаа нь төсөл үр дүнтэй хэрэгжсэний баталгаа юм.

**Хүснэгт 3.3.7** Архангай аймгийн зорилтот болон хяналтын хамтарсан багийн чадамж (n=20)

	(a) Кейс бүртгэл	(b) Үйлчилгээ үзүүлэх	(a)+(b) Хамтарсан багийн чадамж
<b>Төслийн зорилтот хамтарсан баг</b>			
Дундаж	<b>4.73</b>	<b>4.72</b>	<b>9.45</b>
Архангай, Эрдэнэбулган, 4-р баг	4.60	4.50	9.10
Архангай, Хайрхан, Өгөөмөр баг	4.66	4.83	9.49
Архангай, Батцэнгэл, 6-р баг	4.93	4.83	9.76
<b>Төслийн хяналтын хамтарсан баг</b>			
Дундаж	<b>3.14</b>	<b>3.24</b>	<b>6.39</b>
Архангай, Эрдэнэбулган, 1-р баг	1.73	2.00	3.73
Архангай, Өндөр-Улаан	4.10	4.18	8.28
Архангай, Ихтамир	3.60	3.56	7.16

Архангай аймгийн хяналтын орон нутагтай харьцуулахад зорилтот орон нутгийн хамтарсан багийн кейс мэдээлсний дараах бүртгэл, үйлчилгээ үзүүлэх чадвар Т-тестийн дагуу дундаж онооны зөрүү (9.45-6.39) 3.06 байгаа нь маш их сайжирсныг харуулж байна.

## **ХАМТАРСАН БАГИЙН ОЛОН НИЙТЭД ХАНДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2015 онд хийгдсэн төслийн суурь судалгааны дүнгээр хамтарсан багийн тухай мэдээллийг эцэг эхчүүдийн 22% нь авдаг байсан бол 2018 оны эцсийн үнэлгээний үр дүнд 63.8% нь авдаг болсон байна. Төслийн зорилтот орон нутаг болох Архангай аймгийн 4-р баг, Батцэнгэл, Хайрхан сумд, Улаанбаатар хотын БЗД-ийн 23, 27, ЧД-ийн 9, 10, СХД-ийн 2, 10-р хороодоос эцсийн үнэлгээнд оролцсон эцэг эхчүүдийн хамтарсан багийн талаарх мэдээлэл авсан байдал төсөл эхлэх үетэй харьцуулахад 54.5%-иар, төслийн хяналтын орон нутгууд болох Архангай аймгийн 1-р баг, Ихтамир, Өндөр-Улаан сумд, БЗД-ийн 7,16, ЧД-ийн 7,12, СХД-ийн 13, 20 хороодын судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд 27.3%-иар тус тус нэмэгдсэн байна. Төслийн хяналтын орон нутагтай харьцуулахад төслийн зорилтот орон нутгийн эцэг эхчүүдийн хамтарсан багийн талаар мэдээлэл авсан байдал даруй 2 дахин өссөнийг эцсийн үнэлгээний дүнгээс харж болно. (Хүснэгт 4.1)

**Хүснэгт 4.1** Хамтарсан багийн талаар эцэг эхчүүдийн мэдээлэл авсан байдал (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)

Сонгосон үзүүлэлт	2015 он		2018 он		Нийт
	Мэдээлэл авсан	Мэдээлэл аваагүй	Мэдээлэл авсан	Мэдээлэл аваагүй	
<b>Байршил</b>					
Архангай	20.4	79.6	69.4	30.6	100.0
Улаанбаатар	22.6	77.4	61.5	38.5	100.0
<b>Төслийн зорилтот болон хяналтын орон нутгийн эцэг эхийн бүлэг</b>					
Зорилтот	29.1	70.9	83.6	16.4	100.0
Хяналтын	14.4	85.6	41.7	58.3	100.0
<b>Нийт</b>	<b>22.0</b>	<b>82.0</b>	<b>63.8</b>	<b>36.2</b>	<b>100.0</b>

Эцэг эхчүүдийн хамтарсан багийн талаар мэдээлэл авсан эх сурвалжуудыг сонирхвол 2015 онд хорооны нийгмийн ажилтнаас (41.1%), сургуулийн нийгмийн ажилтнаас (19.6%), баг, хорооны засаг даргаас (16.1%), харин 2018 онд хорооны нийгмийн ажилтнаас (29.3%), баг, хорооны засаг даргаас (14.6%), хамтарсан багаас (14%) мэдээлэл авсан байна. 2015 онд эцэг эхчүүдийн 3.6% нь хамтарсан багийн тухай мэдээллийг хамтарсан багийн гишүүдээс авч байсан бол 2018 онд энэ үзүүлэлт 14% болж өссөн байна.

**Хүснэгт 4.2** Хамтарсан багийн тухай мэдээлэл авсан эх сурвалж (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)

Сонгосон үзүүлэлт	2015 он		2018* он	
	Зорилтот	Хяналтын	Зорилтот	Хяналтын
Баг, хорооны засаг дарга	23.5	11.1	29.9	6.7
Сургуулийн нийгмийн ажилтан	32.4	0.0	13.4	10.0
Хорооны нийгмийн ажилтан	55.9	44.4	56.7	16.7
Хамтарсан баг	5.9	0.0	19.4	16.7
ХГБЗХХ-ийн төв	2.9	11.1	3.0	5.0
Багш			1.5	6.7
Цэцэрлэгийн багш			3.0	3.3
Хүүхдийн төлөө ажилладаг ТББ	0.0	11.1	4.5	5.0
Найз нөхөд			3.0	1.7
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	11.8	33.3	11.9	15.0
108 утас			3.0	0.0
Самбар, брошур, нугалбар			3.0	8.3
Бусад	2.9	0.0	7.5	0.0

Тайлбар: \*Олон сонголттой хариултын хувилбар

2015 онд суурь судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 44% нь хүүхдийн эрх, хамгаалал зөрчигдсөн тохиолдолд хаана хандаж тусламж дэмжлэг авахаа мэдэж байсан бол 2018 оны эцсийн үнэлгээнд хамрагдсан эцэг эхчүүдийн 69.3% нь ийнхүү хариулсан байна. Энэ нь эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн болохыг илтгэнэ.

Энэ удаагийн судалгаанд оролцсон төслийн зорилтот орон нутгийн эцэг эхчүүдийн 80.6%, хяналтын орон нутгийн эцэг эхчүүдийн 56.7% нь хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хаана хандах, хэрхэн тусламж дэмжлэг авахаа мэднэ гэжээ. Эндээс үзэхэд төслийн хяналтын орон нутгийн эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, ойлголт мөн адил нэмэгдсэн болохыг харж болно.

**Хүснэгт 4.3** Хүүхдийн хамгаалуулах эрх зөрчигдсөн тохиолдолд хэнд хандах вэ? (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)


Сонгосон үзүүлэлт	2015 он		2018 он		Нийт
	Хэнд хандахаа мэднэ	Хэнд хандахаа мэдэхгүй	Хэнд хандахаа мэднэ	Хэнд хандахаа мэдэхгүй	
<b>Байршил</b>					
Архангай	29.6	90.4	80.6	19.4	100.0
Улаанбаатар	49.3	50.7	64.8	35.2	100.0
<b>Төслийн зорилтот болон хяналтын орон нутгийн эцэг эхийн бүлэг</b>					
Зорилтот	46.6	53.4	80.6	19.4	100.0
Хяналтын	41.2	58.8	56.7	43.3	100.0
<b>Нийт</b>	<b>44.0</b>	<b>56.0</b>	<b>69.3</b>	<b>30.7</b>	<b>100.0</b>

Төслийн зорилтот орон нутгийн бүхий л хороо, сум, багийн хувьд судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 80%-аас дээш нь хүүхэд хамгааллын ойлголт мэдлэгтэй хэмээн хариулснаас үзэхэд төслийн холбогдох зорилт хангалттай биелсэн болохыг харуулж байна.

Харин төслийн хяналтын зарим орон нутагт, тухайлбал Архангай аймгийн 1-р багийн эцэг эхчүүдийн 33.3%, ЧД-ийн 12-р хорооны эцэг эхчүүдийн 16.7% нь хүүхдийн эрх зөрчигдөхөд хаана хандаж тусламж дэмжлэг, зөвлөгөө авахаа мэднэ гэж хариулсан нь бусад зорилтот болон хяналтын орон нутагтай харьцуулахад хамгийн бага хувьтай үзүүлэлт болж байна.

Төсөл хэрэгжиж эхлэх болон хэрэгжсэний дараа эцэг эхчүүдийн хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар ямар байгууллага, албан тушаалтанд хандах талаарх үр дүнг График 4.1-т харуулав.

**График 4.1** Хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар ханддаг байгууллага, албан тушаалтан (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)



Эцэг эхчүүд хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу хүүхэд хамгааллын асуудал эрхэлдэг албан тушаалтан, байгууллагад ханддаг болохыг судалгааны дээрх үр дүн харуулахын зэрэгцээ олон нийтээс хамтарсан багт хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар хандсан тохиолдол суурь судалгааны дүнтэй харьцуулахад хэд дахин өссөнийг харж болно. Зорилтот орон нутгийн эцэг эхчүүдээс хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар хамтарсан баг, нийгмийн ажилтан, цагдаад хандсан тохиолдол хяналтын бүлэгтэй харьцуулахад илүү байна. Төсөл хэрэгжсэн энэ хугацаанд зорилтот хамтарсан багийн үйл ажиллагаа идэвхжиж, олон нийттэй ажилласнаар эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж ирсэн нь тодорхой боловч ерөнхийдөө зорилтот орон нутгийн төдийгүй хяналтын орон нутгийн эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж, улмаар тэдний зүгээс хүүхдийн эрхийн зөрчилд анхаарал хандуулдаг, хүүхдийн эрхийг хамгаалахад оролцдог болсон гэж энэ судалгааны үр дүнгээс дүгнэж болно.

## 4.1 ЗОРИЛТОТ ОРОН НУТГИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ХҮМҮҮЖЛИЙН ЭЕРЭГ АРГЫН СУРГАЛТЫН ҮР ДҮН

Төслийн хугацаанд 2017 онд 109, 2018 онд 112, нийт 221 эцэг эхэд хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулсныг баримтын шинжилгээний дүн харуулж байна. Хүмүүжлийн эерэг аргын сургалтын гарын авлага, материалыг шинэчлэн төслийн зорилтот орон нутагт ашигласан байна.

Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг 7 хоног бүр 1 удаа 3 цагийн хугацаатайгаар, нийт 9 удаагийн, нэг удаагийн хөтөлбөрт 13 эцэг, эхийг хамруулан зохион байгуулж ирсэн бөгөөд энэ хөтөлбөр нь төслийн хамгийн үр дүнтэй үйл ажиллагаануудын нэг байсныг төсөлд оролцогч талууд тодорхойлжээ. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн хэлснээр сургалт нь оролцооны аргад тулгуурласан нь эцэг эхэд зориулсан хүмүүжлийн эерэг аргын сургалт үр нөлөөтэй болоход нөлөөлсөн байна. Тоон болон чанарын судалгааны мэдээлэл цуглуулах явцад төслийн хяналтын орон нутгийн эцэг эх, хамтарсан багийн гишүүдийн зүгээс хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа нь ихээхэн ажиглагдсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

**Хүснэгт 4.1.1** Зорилтот орон нутгийн нийт өрхийн тоо болон хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдсан эцэг эхийн тоо

Зорилтот баг, хороо, сум	Нийт өрхийн тоо	Сургалтад хамрагдсан эцэг эхийн тоо	Дүнд эзлэх хувь
Архангай аймгийн Батцэнгэл сум	1125	26	1.9
Архангай аймгийн Хайрхан сум	1150	26	1.8
Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 4-р баг	1137	26	1.8
БЗД-ийн 27-р хороо	3760	26	0.6
БЗД-ийн 23-р хороо	4423	22	0.5
ЧД-ийн 9-р хороо	1740	26	1.2
ЧД-ийн 10-р хороо	1839	24	1.1
СХД-ийн 2-р хороо	3654	25	0.6
СХД-ийн 10-р хороо	2469	20	0.9
Нийт	<b>21297</b>	<b>221</b>	<b>1.1</b>

Төслийн зорилтот орон нутгийн эцэг эхчүүдийн дунд хүмүүжлийн эерэг аргын хэрэглээ нэмэгдэж, хүүхдэд ямар нэг хэлбэрийн шийтгэл ноогдуулах байдал багасжээ. 2018 оны байдлаар зорилтот болон хяналтын орон нутагт хүмүүжлийн эерэг арга хэрэглэдэг эцэг



эхчүүдийн хувь 2015 оныхтой харьцуулахад харьцангуй өндөр хувьтай гарч байна. Тэр дундаа төслийн зорилтот орон нутгийн хувьд энэ үзүүлэлт өндөр байгаа нь төслийн үр шимийг хүртэгчдийн үнэлгээнээс илэрхий байна. Чанарын судалгаанд хамрагдсан хамтарсан багийн гишүүд болон эцэг эхчүүдийн өгсөн мэдээллээр хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдсан эцэг эхчүүд олж авсан мэдээллээ бусад эцэг эхчүүдтэй хуваалцдаг ба хамтарсан багийн зүгээс тэдний ийнхүү сурсан мэдсэн зүйлээ цааш түгээн дэлгэрүүлэхэд анхаарч, дэмжиж ажилладаг сайн туршлага бий болжээ.

**Хүснэгт 4.1.2** Эцэг эхчүүдийн хүүхэд хүмүүжүүлэхэд хэрэглэдэг аргууд (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)

Сонгосон үзүүлэлт	2015		Нийт	2018*		Нийт
	Зорилтот	Хяналт		Зорилтот	Хяналт	
Өөрийн үгэндээ оруулдаг, дуулгавартай хүн болгож хүмүүжүүлдэг	15.8	17.1	<b>16.0</b>	4.5	8.3	<b>5.2</b>
Загнаж зандардаг, алганы амт үзүүлж хүмүүжүүлдэг	8.3	11.8	<b>9.0</b>	3.0	3.3	<b>3.1</b>
Ярилцдаг, буруу зөвийг нь ойлгуулдаг	49.2	47.4	<b>46.0</b>	65.7	80.0	<b>60.1</b>
Хүмүүжлийн эерэг арга хэрэглэдэг	8.3	10.5	<b>9.0</b>	53.7	10.0	<b>27.5</b>
Хүүхэд хүмүүжүүлэх аргын талаар сайн мэдэхгүй	11.7	11.8	<b>8.0</b>	1.5	8.3	<b>3.9</b>
Бусад (эрхлүүлдэг)	5.8	1.3	<b>2.5</b>	1.5	0.0	<b>0.7</b>
Хүүхэд том болсон	0.8	0.0	<b>9.5</b>	0.0	0.0	<b>0.0</b>

Тайлбар: \* Олон сонголттой хариултын хувилбар

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн зүгээс хамтарсан багаас зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээнүүдэд оролцсон байдлыг харж болно. 2015 оны суурь судалгааны дүнгээр хамтарсан багаас эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан хүмүүжлийн эерэг аргын сургалтад 0.4% нь хамрагдсан үр дүн үзүүлсэн бол 2018 оны төгсгөлийн үнэлгээний дүнгээр 51%-д хүрч өссөн нь зорилтот орон нутгийн эцэг эх, асран хамгаалагчдад хүмүүжлийн эерэг аргуудын талаарх ойлголт, мэдлэгийг өргөн хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн нь харагдаж байна. Холбогдох төслийн зорилт сайн хэрэгжиж, олон нийтэд үр дүнгээ өгчээ. (График 4.1.1)

**График 4.1.1** Хамтарсан багаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон эцэг эхчүүдийн оролцоо (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)

2018 онд эцэг эхчүүдийн 51% нь хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь төслийн зорилтот орон нутгийн эцэг эхчүүдийн 87.8%, харин хяналтын орон нутгийн эцэг эхчүүдийн 12.2%-ийг бүрдүүлж байна.

**Шигтгээ 4.1.1** Хүмүүжлийн эерэг аргын сургалтын тухай

Би “Хүмүүжлийн эерэг арга” сургалтад хамрагдсан. Яаж хүмүүжүүлэх, яаж сургах арга барилыг мэдсэн. Энэ сургалтаар хүүхэдтэйгээ харьцах ойлголт сайн авсан. Одоо би нэг л зүйлийг охиддоо байнга хэлдэг. “Би чамд хайртай” гээд би нүд рүү нь харж байгаад чинь сэтгэлээсээ хэлдэг болсон. Анхандаа ингэж хэлэхийн үнэ цэнийг ойлгодоггүй байсан ч одоо хүүхдүүд маань их өөр болоод байгааг анзаарах болсон. Хүүхдүүд ч надад их өөрөөр хандах болсныг мэдэрдэг. Одоо манай хүүхдүүд “хүүхэд хамгаалах утас” гэдгийг маш сайн мэддэг болсон. Сургалтад суухаас өмнө их дотогшоогоо байсан бол одоо харьцангуй нээлттэй болсон. Өөрийгөө илэрхийлдэг болсон. Хаа нэг газар хэрэг гарвал шууд л утсаар ярьдаг. Өөрийгөө нээх талдаа сайн болсон. Өөрт тохиолдож байгаа зүйлээ нууж хаахгүй илэн далангүй ярьдаг болсон.

(Кейс ярилцлага, ЧД-ийн 9-р хороо, ээж)

Хамтарсан багаас олон нийтэд зориулан олон үйл ажиллагаа хэрэгжүүлдгээс эцэг эх, хүүхдэд зориулсан хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцах, хүмүүжлийн эерэг аргын сургалтын хүрээнд бий болсон үр нөлөө, ололт амжилт, сургамжийг ХИС, аймаг, дүүрэг, баг, хорооны хамтарсан багийн үйл ажиллагааны тайлан, бусад чанарын судалгааны үр дүнд тулгуурлан шинжилж дараах матрицаар үзүүлэв.

**Хүснэгт 4.1.3** Хамтарсан багаас эцэг эх, асран хамгаалагчдад зориулан явуулсан хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгааллын сэдэвт холбогдох сургалт

Төслийн зорилтот бүлэг	Арга хэмжээ	Зохион байгуулагчид	Үр нөлөө
БЗД-ийн 23-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд”</li> <li>- “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх нь”</li> <li>- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- Сургуулийн нийгмийн ажилтан</li> <li>- Сургуулийн нийгмийн ажилтны холбоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхэд суралцсан</li> </ul>
БЗД-ийн 27-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эхчүүдэд хүмүүжлийн эерэг аргын сургалт</li> <li>- Зан үйл өөрчлөх шаардлагатай хяналтад байгаа эцэг эх болон гэр бүлийн гишүүдэд зориулсан ганцаарчилсан сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зан үйлийн өөрчлөлт</li> <li>- Эцэг эхчүүд маш сайн хүлээж авч эерэг аргыг хэрэглэдэг болсон</li> <li>- Эцэг эхчүүдийн сургалтад хамрагдах хүсэлт</li> </ul>
ЧД-ийн 9-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэгийн эцэг эхчүүд болох 50 хүнд (32 эмэгтэй, 18 эрэгтэй) 40 минутын сургалт</li> <li>- Хүмүүжлийн эерэг арга сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эергээр хүлээж авсан</li> <li>- Эерэг ээжүүдийн бүлэг байгуулагдсан</li> </ul>
ЧД-ийн 10-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- 13 иргэнд “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь” 2 удаагийн сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Иргэдэд тухай бүрт мэдээлэл хүргэдэг</li> <li>- Хуулийн мэдлэг олгодог</li> </ul>
СХД-ийн 2-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалт (эцэг эхэд)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургагч багшаар бэлтгэгдсэн</li> </ul>
СХД-ийн 10-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны иргэдэд хүүхэд хамгааллын хуулийн талаар сургалт</li> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллээр хангасан</li> </ul>
Архангай аймгийн 4-р баг	<ul style="list-style-type: none"> <li>- 13 эцэг эхэд хүмүүжлийн эерэг аргын сургалт</li> <li>- Сургалтаар олж авсан мэдлэг мэдээллээрээ илтгэл тавьсан</li> <li>- Аз жаргалтай ээж сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> <li>- Дэлхийн зөн</li> <li>- Цагдаагийн хэлтэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Маш үр дүнтэй</li> <li>- Эцэг эхчүүд сургалтад хамрагдах хүсэлт гаргадаг</li> </ul>

Архангай аймгийн Батцэнгэл сум	<ul style="list-style-type: none"> <li>- 26 эцэг эхэд хүмүүжлийн эерэг аргын сургалт (гэрчилгээтэй)</li> <li>- Аз жаргалтай ээжүүд сургалт</li> <li>- Зорилтот 18 өрхийн сургалт, нөлөөлөл (хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг аргууд)</li> <li>- Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийн сурталчилгаа, хамтарсан багийн үйл ажиллагааны сургалт</li> <li>- Шийтгэл хэрэглэдэг аав, ээжийг хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамруулсан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сумын хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> <li>- Дэлхийн зөн</li> <li>- Цагдаагийн байгууллага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 1 суралцагч дахин 1 эцэг эхэд сурсан зүйлээ мэдүүлснээр дараагийн сургалтад хамрагдах аав ээжийн тоо нэмэгдсэн</li> <li>- Шийтгэл хэрэглэдэг аав ээжүүдийн хандлагад өөрчлөлт гарч эхэлсэн</li> </ul>
Архангай аймгийн Хайрхан сум	<ul style="list-style-type: none"> <li>- “Хүмүүжлийн эерэг арга” 2 удаагийн сургалт</li> <li>- Стресс бухимдлаас сэргийлье, тайвшруулах дасгалын сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сумын хамтарсан баг</li> <li>- ХИС-гийн сургагч багш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрэлттэй сургалт</li> <li>- Эцэг эхчүүд асуудаг</li> <li>- Сургалтад суух хүсэлт гаргадаг</li> </ul>
<b>Төслийн хяналтын бүлэг</b>			
БЗД-ийн 7-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эхчүүдтэй хийсэн хүүхэд хамгааллын талаарх уулзалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны хамтарсан баг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл түгээдэг</li> </ul>
БЗД-ийн 16-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Улирал тутам хууль эрхзүйн сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хороо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл хүргэдэг</li> </ul>
ЧД-ийн 7-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөж байгаа</li> </ul>		
ЧД-ийн 12-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дүүргийн ГБХЗХХ</li> </ul>	
СХД-ийн 13-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Аз жаргалтай гэр бүл сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төв-Үүрийн од ТББ</li> </ul>	
СХД-ийн 20-р хороо	<ul style="list-style-type: none"> <li>- Хорооны эцэг эхчүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт</li> <li>- Эцэг эхчүүдэд зориулсан хүүхэд хамгааллын сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цагдаагийн байгууллага</li> <li>- Хууль зүйн үндэсний хүрээлэн</li> <li>- Өрхийн эмнэлэг</li> </ul>	
Архангай аймгийн 1-р баг	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалт хийгээгүй</li> </ul>		
Архангай аймгийн Ихтамир сум	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүжлийн эерэг арга сургалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтарсан баг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ойлголт мэдээлэл өгсөн</li> </ul>
Архангай аймгийн Өндөр-Улаан сум	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалт хийгээгүй</li> </ul>		

Чанарын судалгааны үр дүнд тулгуурлан хүүхэд хамгааллын оролцогч талуудад, ялангуяа эцэг эх, хүүхдийн дунд зохион байгуулсан “Хүмүүжлийн эерэг арга” сургалтын үр нөлөө, ач холбогдол өндөр байж, хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон нийт зан үйлээ эерэгээр өөрчлөхөд хүргэсэн арга хэмжээ байжээ хэмээн дүгнэж болно. Тэрчлэн төслийн үзэл санааг хөгжүүлэн, орон нутгийн зарим хамтарсан багаас шинэ санаачилга гарган, тодорхой амжилтад хүрч, сайн туршлага хуримтлуулжээ. Жишээлбэл, төслийн зорилтот орон нутгийн буюу Архангай аймгийн Батцэнгэл сумын хамтарсан баг гэр бүлийн хүчирхийлэл илэрсэн, архины хамааралтай гишүүнтэй, амьжиргааны баталгаажих төвшнээс доогуур орлоготой 18 өрхийг сонгож, хүүхэд хамгааллын сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулахын зэрэгцээ түр ажлын байраар хангах арга хэмжээнд зуучилж ажилласан байна.

#### Шигтгээ 4.1.2. Эцэг эхэд зориулсан хүмүүжлийн эерэг аргын сургалтын үр дүн

Өмнөх сургалтын үеэр эцэг эхчүүд ширээ цохиод босоод ирдэг байснаа больсон, анх удаа хүүхдээсээ уучлалт гуйж үзсэн, надаас их зүйлийг шаарддаг юм байна лээ, их гоё сургалт болсон гэж хэлж байсан. Мөн бренд гэх тодотголтой хараалын хэдэн үгээ хэлэхээ больсон, амралтын өдрүүдээр хөмсөг зангидаж, уурласан уцаарласан л хүн байдаг байсан бол одоо тийм авир гаргаа больсон. Гэрт хүүхдүүд минь хаа сайгүй гүйлддэг, би өөрөө байнгын цухалдуу байхаа больсон, нөхөр хүүхдүүд маань хүртэл та ямар гоё болчихсон юм бэ? сургалтдаа яв яв гэдэг болсон гэх мэтээр ээж, аавуудад олон өөрчлөлтүүд гарсан.

2017 оны хамгийн үр дүнтэй үйл ажиллагаа маань хүмүүжлийн эерэг аргын сургалт болсон. 3 сартай нялх хүүхэдтэй ээж хүмүүжлийн эерэг аргын сургалтад суудаг. Хүүхэд нь ханиадтай байхад хүртэл сургалтыг маань нэг ч таслалгүй суудаг. Үүнийг хараад их урам ордог.

*(Хагас бүтэцжүүлсэн ярилцлага, БЗД, 27-р хороо, хамтарсан багийн гишүүн)*



**Зураг 4.1.1** Архангай аймгийн Батцэнгэл сумын хамтарсан багаас эцэг эхчүүдэд явуулсан “Хүмүүжлийн эерэг арга” сургалт болон бусад нөлөөллийн үйл ажиллагаа

Судалгаанд оролцсон эцэг эхчүүд бүлгийн ярилцлагын явцад хамтарсан багт хандаж дараах саналыг дэвшүүлсэн юм.

#### Хүснэгт 4.1.4 Хамтарсан багт хандаж эцэг эхчүүдийн гаргасан санал (төслийн зорилтот болон хяналтын бүлгээр)

Аймаг, дүүрэг, сум	Төслийн зорилтот бүлэг	Төслийн хяналтын бүлэг
БЗД	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг хороонд тогтмол хийх</li> <li>- ТВ, радиогоор хөтөлбөр хэлбэрээр цацаж, сургалтын цар хүрээг нэмэх</li> <li>- Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын сургалтыг амралтын өдрөөр явуулах</li> <li>- Богино хугацааны сургалтууд байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зарлал мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэх</li> <li>- Сургалтын талаарх мэдээлэл авдаггүй, мэдээлэл хүргэх</li> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдах</li> <li>- Эцэг эхийн чөлөөт цаг, ажил багатай үед сургалтаа явуулах</li> </ul>
СХД	<ul style="list-style-type: none"> <li>- Хэсгийн ахлагчаар өрхөд мэдээлэл өгөх</li> <li>- Хүмүүжлийн эерэг арга, хүчирхийллийн асуудлаарх сургалт, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Интернэт, Фэйсбүүк ашиглаж мэдээлэл түгээх</li> <li>- Иргэдэд мэдээлэл түгээдэг олон аргыг ашиглах (эцэг эх сургалтад хамрагдана)</li> <li>- Эцэг эхийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах</li> <li>- Утсаар сургалтын зар хүргэх</li> <li>- Эцэг эх завгүй тул мэдээлэл бэлтгэн өрхөөр тараах</li> </ul>
ЧД	<ul style="list-style-type: none"> <li>- Гудамж, олон нийтийн газар самбар байршуулж мэдээлэл тараах</li> <li>- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ ашиглах</li> <li>- Өрх, иргэдийн дунд орж мэдээлэл түгээх</li> <li>- Эцэг эхийн чөлөөт цагаар сургалт зохион байгуулах</li> <li>- Эцэг эх, хүүхдэд хамтад нь сургалт явуулах</li> <li>- Сургалтыг ажилд зуучлах, амьжиргааг дэмжих үйл ажиллагаатай хослуулж үр нөлөөг нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд хүмүүжлийн эерэг аргын сургалт явуулах</li> <li>- Зарлал болон эцэг эхэд хэрэгтэй мэдээллийг шуурхай хүргэх</li> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг хүүхдийн нас, насны онцлогтойгоор тайлбарлан ойлгуулах сургалт хэрэгтэй</li> </ul>
Архангай аймаг	<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалт тогтмол явуулах</li> <li>- Хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамрагдамаар байна (бусад эцэг эхээс сонссон)</li> <li>- Сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх</li> <li>- Залуу эцэг эхийг сургалтад хамруулах</li> <li>- Хүүхдэд зориулсан секц дугуйлан түлхүү хичээллүүлэх</li> <li>- Эцэг эхийн өдөрлөг</li> <li>- Олон эцэг эхийг сургалтад хамруулах</li> <li>- Сургалтын зар мэдээллээ хүртээмжтэй хэлбэрээр цацах, түгээх</li> <li>- Сургалтад идэвхтэй оролцуулах зорилгоор уралдаан тэмцээнтэй хослуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтарсан багийн үйл ажиллагаа нээлттэй байх</li> <li>- Хамтарсан багийн талаар ойлголтгүй тул мэдээлэлжүүлэх</li> <li>- Малчдын хүүхдийн хүмүүжил, хөгжилд анхаарсан сургалт явуулах</li> <li>- Мэдээлэл түгээхдээ өрх бүрт хүрч байгаа эсэхэд анхаарах</li> <li>- Эцэг эхийн чөлөөтэй цагаар сургалтыг явуулах</li> </ul>

## 4.2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ХҮҮХДҮҮДИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА

Хамтарсан багийн талаар хүүхдүүдийн мэдээлэл авсан байдлыг суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад энэ удаагийн судалгааны үр дүн даруй 2 дахин нэмэгдсэн байна. 2015 онд судалгаанд хамрагдсан төслийн зорилтот орон нутгийн хүүхдүүдийн 37.1%, 2018 онд эцсийн үнэлгээнд хамрагдсан хүүхдүүдийн 63.8% нь хамтарсан багийн талаар мэдээлэл авсан гэж хариулсан нь төслийн үйл ажиллагаа энэ бүлэгт амжилттай хэрэгжсэн гэдгийг харуулж байна.

**Хүснэгт 4.2.1** Хамтарсан багийн талаар хүүхдүүдийн мэдээлэлтэй байдал (суурь судалгааны үр дүнтэй харьцуулснаар)

Сонгосон үзүүлэлт	2015 он		2018 он		Нийт
	Мэдээлэл авсан	Мэдээлэл аваагүй	Мэдээлэл авсан	Мэдээлэл аваагүй	
<b>Байршил</b>					
Архангай	23.1	76.9	53.1	46.9	100.0
Улаанбаатар	29.0	71.0	52.9	47.1	100.0
<b>Зорилтот болон хяналтын бүлэг</b>					
Төслийн зорилтот бүлэг	37.1	62.9	63.8	36.2	100.0
Төслийн хяналтын бүлэг	13.5	86.5	38.6	61.4	100.0
<b>Нийт</b>	<b>26.3</b>	<b>73.7</b>	<b>52.9</b>	<b>47.1</b>	<b>100.0</b>

2015 оны болон 2018 оны судалгааны үр дүнгээс харахад хүүхдүүд хамтарсан багийн талаарх мэдээллийг баг/хорооны нийгмийн ажилтан, сургууль, эцэг эх, багш, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэрэг эх сурвалжуудаас гол төлөв авдаг байна.

Төслийн зорилтот орон нутгийн хүүхдүүдийн хувьд 2015 онд 74.2% нь хамтарсан багаас зохион байгуулсан аливаа арга хэмжээнд оролцоогүй байсан бол төсөл дуусах үед энэ үзүүлэлт 43.2%-д хүрч буурчээ. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад 2018 онд төслийн зорилтот орон нутгийн хүүхдүүдээс хамтарсан багийн талаар мэдээлэл авсан байдал, хамтарсан багаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон хувь хэмжээ нэмэгдэж ирснийг харж болно.

### Шигтгээ 4.2.1. Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулах шаардлага

2017 онд хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулсан. 9 удаагийн сургалтдаа 109 хүн хамруулсан. Нийгмийн ажилтнуудыг сургалтад хамруулахдаа ажлын төлөвлөгөөнд тусгуулж, албан ёсоор ажлаас нь чөлөөлүүлсэн. Нийгмийн ажилтан ажлынхаа хажуугаар сургагч багшаар ажиллах зэрэг олон ажил давхцдаг. Зарим засаг дарга, удирдах албан тушаалтан ойлгодоггүй. Дүүргээс хороо хүртэл улс төрийн томилгоогоор албан хаагчдыг сольдог тул ажлаа дахин эхлүүлэх болдог. Удирдах албан тушаалтнуудад хүмүүжлийн эерэг аргын талаар ойлголт мэдлэг өгөх чиглүүлэх сургалтыг хийх хэрэгцээ шаардлага гардаг. Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг аргыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулбал илүү үр дүнтэй санагддаг. Энэ нь удирдах албан тушаалтнуудын сонорт хүрэх ач тустай байх болов уу.

(Экспертийн ярилцлага, ХИС-гийн мэргэжилтэн)

**Хүснэгт 4.2.2** Хамтарсан багаас зохион байгуулсан үйл ажиллагаанд хүүхдүүдийн хамрагдсан байдал

Он	Төслийн зорилтот бүлэг	Төслийн хяналтын бүлэг
2015	74.2% нь хамтарсан баг болон багийн гишүүдээс зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдаагүй байна	96.2% нь хамтарсан баг болон багийн гишүүдээс зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдаагүй байна
2018	43.2% нь хамтарсан баг болон багийн гишүүдээс зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдаагүй байна	54.2% нь хамтарсан баг болон багийн гишүүдээс зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдаагүй байна

2015 онд хамтарсан багаас зохион байгуулсан арга хэмжээнүүдэд 18 хүүхэд оролцсон бол 2018 онд 56 хүүхэд болж өссөн ба хамтарсан багийг танилцуулах уулзалт, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын сургалтууд, хүүхэд хамгааллын чиглэлээр уралдаан тэмцээн, өдөрлөг, аян зэрэг арга хэмжээнд оролцох оролцоо нэмэгдсэн болохыг дараах хүснэгтээс харж болно.


**Хүснэгт 4.2.3** Хамтарсан багаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон гэж хариулсан хүүхдүүдийн өгсөн тоон мэдээлэл (2015, 2018 оны судалгааны харьцуулсан үр дүнгээр)

Сонгосон үзүүлэлт	2015 оны тоон мэдээлэл	2018 оны тоон мэдээлэл
Хүүхдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамтын тухай сургалт	10	23
Хүмүүжлийн эерэг аргууд сургалт	2	9
Хамтарсан багт хэрхэн хандах, холбогдох, туслалцаа авах тухай сургалт танилцуулга, уулзалт	-	8
Хамтарсан багийн танилцуулга уулзалт	4	4
Хүүхэд хамгаалалтай холбоотой уралдаан тэмцээн	1	6
Хамтарсан багийн гишүүдээс хийсэн уулзалт, зөвлөгөө, тусламж, дэмжлэг	1	3
Бусад	-	3
<b>Нийт</b>	<b>18</b>	<b>56</b>

Эцсийн үнэлгээнд хамрагдсан хүүхдүүдийн 52% нь эцэг эхчүүдийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барилд эерэг өөрчлөлт гарсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Тэдний зүгээс эцэг эхчүүд хүүхэдтэйгээ харилцахдаа харилцан ярилцах, зөв бурууг ойлгуулах, хүүхдээ сонсох зэргээр хүмүүжлийн эерэг арга хэрэглэдэг гэжээ. График 4.2.1-т харуулснаар төслийн зорилтот орон нутгийн хүүхдүүдийн 55.6%-д нь дээрх эерэг өөрчлөлт гарсан гэж хариулсан нь хяналтын орон нутагтай харьцуулахад өндөр байна.



**График 4.2.1** Сүүлийн 3 жилийн байдлаар эцэг эхчүүдийн хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцах арга барилд хүүхдүүдийн өгсөн үнэлгээ (2018 оны судалгааны дүнгээр)




Судалгаа явагдсан орон нутгаар харвал, Архангай аймгаас судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 59.4%, Улаанбаатар хотын хүүхдүүдийн 46.4% нь эцэг эхийн хүүхэд хүмүүжүүлэх арга барилд эерэг өөрчлөлт гарсан хэмээн үнэлсэн байна.

#### А. Төслийн зорилтот болон хяналтын орон нутгийн хамтарсан багаас эцэг эх, олон нийтэд зориулсан бусад сургалт

2017 оны байдлаар нэг хороо дунджаар 7 үйл ажиллагааг олон нийтэд зохион байгуулж, ойролцоогоор 800-1000 хүнийг хамруулсан байна.

**График 4.2.2** Хамтарсан багаас зохион байгуулсан сургалтын тоо



Хамтарсан баг олон нийтэд чиглэсэн дараах сургалтуудыг зохион байгуулсныг матриц 4.2.1-т харуулав.

**Хүснэгт 4.2.4 Олон нийтэд чиглэн зохион байгуулсан сургалт (2018)**

Зохион байгуулсан сургалт, судалгаа	Баг, хорооны түвшинд																	
	Зорилтот хороо							Хяналтын хороо										
	ЧД, 9 хороо	ЧД, 10 хороо	БЗД, 27 хороо	БЗД, 23 хороо	СХД, 2 хороо	СХД, 10 хороо	Архангай, Хайрхан сум	Архангай, Батцэнгэл сум	Архангай, Эрдэнэбулган, 4 –р баг	ЧД, 7 хороо	ЧД, 12 хороо	БЗД, 7 хороо	БЗД, 16 хороо	СХД, 13 хороо	СХД, 20 хороо	Архангай, Эрдэнэбулган сум, 1 баг	Архангай, Ихтамир сум	Архангай, Өндөр-Улаан сум
Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг таниулах	+	+	+	+	+	+	+	+	+		+	+	+		+			+
Цахим орчин дахь үе тэнгийнхний дарамт шахалтын эсрэг мэдээлэл сургалт	+	+		+			+	+				+						
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй сургалт, мэдээлэл өгөх үйл ажиллагааны хамт	+					+	+											
Гэр бүлд зориулсан сургалтууд	+	+	+	+			+	+				+	+	+				+
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаатай хамтарсан хүүхэд хамгааллын сургалт, Архины хамааралтай иргэдэд зориулсан сургалтууд	+	+		+			+	+							+			
Хүүхдийн тусламжийн 108 утасны талаар сургалт (107* 108* 102*) тухай мэдээлэл	+		+	+				+					+					
Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн эцэг эхчүүдэд хамтарсан багийн үйл ажиллагааг таниулах сургалт	+		+	+				+	+									
Судалгаа				+			+											

Зорилтот орон нутгийн хамтарсан багууд хүүхэд хамгааллын асуудалд холбогдох хуулиудыг сурталчлах арга хэмжээг эцэг эх, олон нийтэд зориулан зохион байгуулсан байна. Эдгээр сургалтуудыг зохион байгуулахдаа сургуулиар дамжуулан сурагчдад, мөн төрийн байгууллагын ажилтнууд, эцэг эхчүүдэд зэргээр тодорхой бүлгүүдээр зохион байгуулсан нь ач холбогдолтой болжээ. Мөн тухайн ялгаатай бүлгүүдийн сонирхлыг татахуйц тэмцээн уралдаануудыг зохион байгуулсан нь олон нийтийн талархлыг хүлээсэн арга хэмжээ болсон хэмээн дүгнэж байна.



**Зураг 4.2.1** Архангай аймгийн Хайрхан сум албан хаагчид, хүүхэд, гэр бүлд хууль таниулах сургалт явуулж буй нь



**Зураг 4.2.2** Хууль таниулах сургалт

Төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багаас тодорхой бүлгүүдэд, тухайлбал гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, архины хамааралтай иргэдийг оролцуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлжээ. “Гэр бүлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн орчинд эцэг эхчүүдийн хүлээх хариуцлагыг дээшлүүлье”, “Архигүй гэр бүл”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Харилцаа, хандлага, зан чанарын тухай”, “Баяр хөөртэй гэр бүл”, “Гэр бүлийн уур амьсгал” сургалт, сурталчилгааны ажлуудыг хамтарсан багаараа зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн байна.

2015 оны төслийн суурь судалгааны үр дүнгээр олон нийтэд чиглэсэн арга хэмжээ цөөн, арга хэмжээ нь гол төлөв орон нутгийн идэвхтэй иргэдийн оролцоотой хэрэгждэг байсан бол 2018 оны эцсийн үнэлгээний үр дүнгээр хамтарсан багийн үйл ажиллагаа өргөжиж, зорилтот хүн амаас гадна хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг албан хаагч, удирдах ажилтнуудын оролцоог хангаж ирсэн байна.

#### **Шигтгээ 4.2.2** Хүмүүжлийн эерэг аргын сургалтын үр нөлөө

Манай хороонд хүүхэд харах үйлчилгээ-5, улсын цэцэрлэг-2, гэр цэцэрлэг-2, бага сургууль-2 гэх мэт боловсролын байгууллагууд байдаг. Бага анги, цэцэрлэгийн багш нар хамтарсан багаас зохион байгуулдаг хүмүүжлийн эерэг аргын сургалтад оролцох санал гаргасан. Эцэг эхээс гадна багш нарыг дээрх сургалтад хамруулбал тэднээр дамжуулж олон эцэг, эхчүүдэд хүргэх боломжтой.

*Баянзүрх дүүргийн 23-р хороо, Засаг дарга*

Цахим орчин ба гадуурхал, үе тэнгийнхний дарамтаас урьдчилан сэргийлэх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтуудыг төслийн зорилтот болон хяналтын хамтарсан багууд зохион байгуулсан байна. Жишээлбэл, БЗД-ийн 7-р хороонд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллага, цахим тоглоомын газрын тоо олон гэх мэт эрсдэлт нөхцөл байдлыг харгалзан төслийн хяналтын хамтарсан багаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулжээ.

Хамтарсан багийн гишүүд хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд тулгуурлан үйл ажиллагаагаа төлөвлөн, хэрэгжүүлж байна. Хамтарсан багуудаас орон нутгийн түвшинд архины хамааралтай иргэд, сургууль завсардсан хүүхэд, хөдөлмөр эрхэлдэг хүүхэд, хараа хяналтгүй хүүхэд, хагас ба бүтэн өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэмт хэрэгт холбогдож болзошгүй эрсдэлт бүлгийн хүүхдийн судалгаа, түүнчлэн 2017 онд 107, 108, 102 утсанд хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ирсэн дуудлагыг мөшгөх судалгааг тус тус хийсэн байна. Хүүхэд хамгаалагдаж чадахгүй байгаа орчныг танин мэдэх зорилготой “Хүүхдэд ээлтэй хот” судалгаанд хүүхдүүдийг хамруулан, амьдарч буй орчныг нь үнэлүүлсэн байна. Цаашид хамтарсан багийн гишүүд ашиглах стандарт асуулга хэрэглэх, түүний үр дүнг боловсруулах программыг ашиглаж сурах зэргээр чадавхжих хэрэгцээ байгааг судалгааны үеэр тэмдэглэсэн юм.

### Шигтгээ 4.2.3

Гэр бүлд зориулсан сургалтад суусан. Хүүхдээ хүмүүжүүлж, хүүхэдтэйгээ харьцаж болоод байна л гэж бодоод байсан, үгүй юм билээ. Их олон зүйлийг сурсан. Хүүхдэдээ цаг гаргаж, түүнийг сонсох хэрэгтэй гэдгийг маш сайн ойлгож, хэрэгжүүлж байгаа.

*Чингэлтэй дүүргийн 9-р хорооны иргэн*

### Шигтгээ 4.2.4

Манай хорооны хувьд 8 цахим тоглоомын газартай. Доод тал нь 48 суудалтай, дээд тал нь 150 суудалтай байна. Мөн РС тоглоомын газар байгаа. Цагдаа нар тэдэнд цагаа баримтлах, бага насны хүүхдүүдийг олон цагаар суулгахгүй байхыг анхааруулдаг ч бодит байдал дээр эсрэгээрээ байдаг.

*Баянзүрх дүүргийн 7-р хорооны нийгмийн ажилтан*

### Шигтгээ 4.2.5

Манай хорооноос зорилтот бүлэг болох архины хамааралтай иргэдэд зориулсан сургалт явуулсан, одоогоор хорооны иргэний танхимд 7 хоног бүрийн Лхагва, Бямба гаригт зорилтот бүлгийн иргэдэд зориулсан сургалт зохион байгуулдаг. 4 хүн архинаас гарсан, одоо 20 иргэн сургалтад хамрагдаж байна.

*Чингэлтэй дүүргийн 9-р хорооны нийгмийн ажилтан*

### Шигтгээ 4.2.6


Судалгаагаар хүүхдүүд өглөө сургуульдаа явахад хаана эрсдэл их, хаана тоглодог, дугуйлан секцэд хамрагдаж чаддаггүй шалтгаан зэрэг асуудлаа өөрсдөө тодорхойлсон. Хамтарсан багийнхан маань хаана тоглох газар байгуулах, эрсдэлийг бууруулахын тулд юу хийхээ тодорхойлсон олон хэрэгцээтэй мэдээлэл цуглуулсан. Бидний тооцоолж байгаагүй газар орчны тухай ч ойлголттой болсон.

*Баянзүрх дүүргийн 23-р хороо, хэсгийн ахлагч*

### 4.3 ХАМТАРСАН БАГААС ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ӨДӨРЛӨГ, АЯН

Өдөрлөг, аяныг хамтарсан багийн үйл ажиллагааг иргэдэд таниулах, иргэдийн оролцоотойгоор гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн эрх, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлэх гэх мэт зорилгоор зохион байгуулж байна. Өдөрлөг, аян зэргийг олон нийтийн сонирхлыг татах үйл ажиллагаануудаар дамжуулан зохион байгуулж байгааг баримт бичгийн судалгааны дүн харуулж байна. Тухайлбал залуучуудад зориулсан Флаш моб өдөрлөг, сургуулийн хүүхдүүдэд зориулсан АХА тэмцээн, Центавр тэмцээнүүдтэй өдөрлөг зэргийг нэрлэж болно. Үнэлгээнд оролцсон хамтарсан багийн гишүүд тухайн жилд олон хүнийг хамарч чадсан, сонирхолтой, олон нийтийн идэвхтэй оролцоог хангасан үйл ажиллагаануудыг нэрлэж байсан ба тэдгээрийг тоон мэдээлэлд тулгуурлан дараах графикаар илэрхийлэв. 2017 онд зохион байгуулсан өдөрлөг, аяны тоо нь төсөл хэрэгжихийн өмнөх 2015 онтой харьцуулахад 3.2 дахин, 2016 онтой харьцуулахад 1.6 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл 2017 онд нэг хороо дунджаар 8-9 үйл ажиллагаа өдөрлөг, аяныг хамтарсан багаар зохион байгуулжээ. Зохион байгуулсан өдөрлөг аяныг төслийн зорилтот болон хяналтын хороогоор харьцуулан харуулъя.

**График 4.3.1** Хамтарсан багаас олон нийтэд зориулан зохион байгуулсан өдөрлөг ба аяны тоон мэдээлэл



**Хүснэгт 4.3.1** Олон нийтэд чиглэн зохион байгуулагдсан өдөрлөг, аян

Зохион байгуулсан өдөрлөг, аян	Баг, хорооны түвшинд																	
	Зорилтот хороо						Хяналтын хороо											
	ЧД, 9 хороо	ЧД, 10 хороо	БЗД, 27 хороо	БЗД, 23 хороо	СХД, 2 хороо	СХД, 10 хороо	Архангай, Хайрхан сум	Архангай, Батцэнгэл сум	Архангай, Эрдэнэбулган 4-р баг	ЧД, 7 хороо	ЧД, 12 хороо	БЗД, 7 хороо	БЗД, 16 хороо	СХД, 13 хороо	СХД, 20 хороо	Архангай, Эрдэнэбулган сум, 1-р баг	Архангай, Ихтамир сум, Төвийн баг	Архангай, Өндөр-Улаан сум, Төвийн баг
Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр 4 сарын 30-тай холбоотой	+	+	+	+	+	+	+	+		+	+	+					+	
“Дэвжээ”, “Центавр”, “АХА” тэмцээн	+		+	+	+		+			+		+		+	+		+	+
Архины хамааралтай иргэдийг урамшуулалт эргүүлд хамруулсан	+												+					

Гэрээсээ дайжсан хүүхдүүдийг оролцуулсан уулзалт	+	+		+	+	+	+	+	+										
Өрхөөр явж, хүүхдийг хэрхэн хамгаалах тухай ойлголтыг багтаасан гарын авлага тараасан	+		+	+			+			+		+							
“Хүүхдэд ээлтэй орон нутаг” хэлэлцүүлэг							+												
Яриа таниулга, уулзалтууд						+				+									
5.15 буюу “Гэр бүлийн өдөр”, “Аавуудын хурал”, Аавуудын өдөрлөг	+		+						+			+							
Эерэг аавуудын клуб, аавтайгаа хамтдаа тэмцээнд				+					+										
Аз жаргалтай ээж, аз жаргалтай гэр бүл		+																	
Сурагчдын зөвлөл, гэр бүлийн зөвлөл	+								+										
“Хүүхдэдээ бахархан дуурайх ээж аав нь байя” уриан дор хүүхэд хамгааллын сарын аян, “Ээж, аав, би” уралдаан тэмцээн, мэдээлэл хүргэх самбар	+		+	+			+												
Сурагчдаас эцэг эхдээ илгээх захидал									+										

4 сарын 30-ны өдөр буюу “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоохын төлөөх дэлхийн өдөр”-ийг ХИС өөрийн хамтрагч байгууллагууд, хүүхэд, олон нийттэй хамтран 2006 оноос хойш тэмдэглэж хэвшжээ. Тухайлбал, энэхүү өдөрлөгийг зохион байгуулж, эцэг эхчүүдэд хүүхдээ зодож шийтгэхгүйгээр хүмүүжүүлэх аргыг сурталчилж, улмаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхэд хамгааллын болон хүүхдийн эрхийн тухай

#### Шигтгээ 4.3.1

Зодож шийтгэхгүй байх өдрийг угтан 3-5 дугаар ангийн хүүхдүүдэд мэдээлэл өгөөд, тэдгээр хүүхдүүдийн эцэг эхчүүдэд захидал хүргэдэг. Эцэг эхчүүд хүлээж аваад захидлын доод хэсгийг уран авч, хүлээж авлаа гэсэн гарын үсэг зураад буцаан явуулдаг. Тэдгээр хүүхдүүдээсээ 2 идэвхтэй бүлгийг сонгон авч, хүмүүст мессэж хүргэх замаар дахин тараадаг.

*Баянзүрх дүүргийн 7-р хорооны  
нийгмийн ажилтан*

хуулиудыг сурталчлах, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулах үйл ажиллагаа явуулсан байна. Төслийн зорилтот орон нутгийн хамтарсан багууд сарын аяныг зохион байгуулж, олон нийт, эцэг эхчүүдэд хандсан олон үйл ажиллагаа явуулжээ.

№	Угил амжиллагаа	Хугацаа	Хариуцагч багын нэр	Дүгнэлт
1	Содорлогон ололт	10:00	Төрийн тулгуур	Ажлын үр дүнд хамтарсан багийн гишүүдэд мэдээлэл өгөх, тэднийг хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцуулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.
2	Сургуулийн хуралын өдөр	10:00	Аман Эрдэнэ	Сургуулийн хуралын өдөр хуралын үеэр хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.
3	Хүүхэд хамтарсан тусгай хурал. Тэр оройгоор хуралын үеэр хүүхдэд хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.	11:00	Сүхбаатар, О.ОХИРОВА	Хуралын үеэр хүүхдэд хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.
4	Сургуулийн хуралын өдөр хуралын үеэр хүүхдэд хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.	11:20	Ц.ЭНХЖУУ, Х.МОНХОО, С.ОЮУН, Д.БАЯН, Х.БЭЛЭГ, Х.МОНХОО	Хуралын үеэр хүүхдэд хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.
5	Төрийн байгууллагад үйл ажиллагаа явуулсан үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.	12:00	С.ХАНГАЙ, С.БАЯН, Х.МОНХОО	Хуралын үеэр хүүхдэд хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж, хамтарсан багийн үйл ажиллагааг таниулахад тусалж.

**Зураг 4.3.1** Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 4-р багийн сарын аяны төлөвлөгөө



**Зураг 4.3.2** Чингэлтэй дүүргийн 9-р хороо

Мөн өргөн хүрээтэй зохион байгуулагддаг, иргэд, олон нийтийн сонирхлыг татдаг үйл ажиллагаанууд бол Дэвжээ, Центавр, АХА тэмцээнүүд юм. Хамтарсан багийн танилцуулга өдөрлөгөөр эцэг эхчүүдэд хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагааг таниулах, тараах материалаар мэдээлэл хүргэх, эцэг эхчүүдэд нөлөөлөх зорилгоор сурагчдын дунд гэр бүлдээ зориулан зохион бичлэг бичих аян өрнүүлэх, зургийн үзэсгэлэн гаргах зэрэг сайн туршлага бий болжээ.



**Зураг 4.3.3** Эцэг эх, олон нийтийг хамруулсан үйл ажиллагаанууд



**Зураг 4.3.4** Баянзүрх дүүргийн 27-р хороо

#### 4.4 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АСУУДЛААР ХАМТАРСАН БАГТ ХАНДАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ТУРШЛАГА

Төслийн зорилтот орон нутгийн хамтарсан багийн бүрэлдэхүүнд ордоггүй, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын дунд (n=40) судалгаа явуулахад бүгд хамтарсан багийн үйл ажиллагааг мэддэг, мэдээлэлтэй болохоо илэрхийлсэн юм. Хүүхэд хамгааллын ажилтнуудын 87.5% нь 2015 оноос хойш хамтарсан багийн тухай мэдээлэл авсан гэж хариулсан нь ХИС-гийн төсөл хэрэгжиж эхэлсэн үетэй давхцаж байна.

**Хүснэгт 4.4.1** Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын хамтарсан багийн талаарх мэдээлэлтэй байдал

Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнууд	Мэдээлэлтэй гэж хариулсан хувь	Тоо
Төрийн байгууллага	100.0	5
Сургуулийн багш, нийгмийн ажилтан	100.0	8
Эмч	100.0	11
Цагдаа	100.0	2
Төрийн бус байгууллага	100.0	1
Бусад (улсын бүртгэгч, зохион байгуулагч)	100.0	13
Нийт	<b>100.0</b>	<b>40</b>

Судалгаанд хамрагдсан дээрх ажилтнуудын 27.5% нь хорооноос зохион байгуулсан хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, 25% нь хүмүүжлийн эерэг арга, хамтарсан багийг чадавхжуулах ажил болон холбогдох хууль тогтоомжийг таниулах сургалт, 2,5% нь зурагт хуудас, мөн 2,5% нь хүүхдийн эрх, хамгааллын сэдэвт уралдаан тэмцээнээс мэдээлэл авсан байна. Ерөнхийдөө хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын хамтарсан багийн талаарх мэдлэг, мэдээллийн төвшин маш сайн байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын хувьд хамтарсан багаас зохион байгуулсан хүмүүжлийн эерэг аргын сургалт, хамтарсан багийг чадавхжуулах сургалт, хууль сурталчлах сургалт болон хороо, багаас хүүхэд хамгааллын чиглэлээр явуулдаг үйл ажиллагаанаас хамтарсан багийн тухай мэдээллийг илүүтэй олж авсан байна.

Судалгаанд хамрагдсан хүүхэд хамгааллын чиглэлээр ажилтнууд тухайн орон нутгийн хамтарсан багаас хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудыг нэрлэсэн бөгөөд тэдгээрийг эрэмбэлэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 50% Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ
- 17,5% Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа
- 7,5% Хүүхэд хамгааллын сургалт
- 7,5% Эцэг эхчүүдэд зориулсан хүмүүжлийн эерэг аргын сургалт



- 7,5% Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
- 5% Хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгаа
- 5% Зорилтот бүлэгт (архины хамааралтай хүмүүс, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг хүмүүс) чиглэсэн хүмүүжлийн эерэг аргын сургалт

Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын өгсөн хариултад тулгуурлан дүгнэхэд хамтарсан баг хүүхэд хамгааллын чиглэлээр олон талт, үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн байна. Өөрөөр хэлбэл хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнууд хамтарсан баг, түүний үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэл маш сайтай байна.

Чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд төсөл хэрэгжсэнээр хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын зүгээс хамтарсан багийн ажлыг цааргалж, мэдээлэл өгөхөөс татгалзах хандлага өөрчлөгдсөн бөгөөд хүүхэд хамгаалалд холбогдох зөрчлийн асуудлаар хамтарсан багт мэдээлэх, хамтарч ажиллах байдал нэмэгдсэн байна. Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнууд хамтарсан багаас зохион байгуулдаг сургагч багшийн сургалт, хүүхэд хамгааллын зөвлөгөөн, уулзалт семинарт оролцож, ажлын шугамаар хүүхэд хамгааллын чиглэлээр мэдлэг туршлагаа хуваалцан хамтарч ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан хүүхэд хамгааллын ажилтнууд хүүхдийн эрх зөрчигдсэн тохиолдолд хэнд хандахаа 100% мэддэг буюу энэ тохиолдолд хамтарсан багт хандаж, хүүхдийн эрхийг хангаж, хамгаалах үүргээ биелүүлнэ гэсэн хариулт өгчээ.

**Хүснэгт 4.4.2** *Хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар хэнд хандахаа мэднэ гэж хариулсан хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын эзлэх хувь*

	Мэднэ гэж хариулсан хувь	Тоо
Төрийн байгууллага	100.0	5
Сургуулийн багш, нийгмийн ажилтан	100.0	8
Эмч	100.0	11
Цагдаа	100.0	2
Төрийн бус байгууллага	100.0	1
Бусад (улсын бүртгэгч, зохион байгуулагч)	100.0	13
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>40</b>

Судалгаанд оролцогчид хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар хэрхэн мэдээлэхийг мэднэ гэж 100% хариулжээ. Доорх хүснэгтэд харуулснаар хүүхэд хамгааллын асуудлаар 108 утсанд мэдээлэл өгнө гэж 30%, 26.3% нь хамтарсан багт хандаж хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлнэ гэжээ.

### Хүснэгт 4.4.3 Хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар хаана хандахаа мэднэ гэж хариулсан хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын эзлэх хувь (n=40)

Хаана	Дүнд эзлэх хувь
108 утас	30.0
Сургуулийн нийгмийн ажилтан	15.0
Эмч	2.5
Хамтарсан баг	26.3
Цагдаа	15.0
107 утас	11.3
<b>Нийт</b>	<b>100.0</b>

Судалгаанд хамрагдсан хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын 45% нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар холбогдох байгууллага, албан хаагчид мэдээлж байсан ажээ. Үлдсэн хувь нь ийм тохиолдол байгаагүй хэмээн хариулсан байна. Мэдээлэл өгч байсан тохиолдлуудыг сонирхвол хүүхдийн эсрэг бие махбодын, бэлгийн хүчирхийлэл, хүүхэд эцэг эхээсээ болоод гэрээсээ дайжсан, олон нийтийн газар бие махбодын хүчирхийлэлд өртсөн зэрэг асуудал байсан байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд төсөл хэрэгжсэнээр хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудын хамтарсан багийн талаарх мэдлэг ойлголт сайжирч мэдээлэлтэй болоод зогсохгүй өөрсдийн ажил, үүргийн хүрээнд хамтарч ажиллаж байгаа нь чухал үр дүн мөн. Чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд хамтарсан багаас зохион байгуулсан хүмүүжлийн эерэг арга, хүүхдийн эрх, хамгаалалд холбогдох хууль тогтоомжийг таниулах уулзалт, хамтарсан багийн үйл ажиллагааны танилцуулга, өдөрлөг арга хэмжээнүүдэд хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудыг хамруулах замаар тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, хандлагыг өөрчилж байна.

Төсөл хэрэгжих хугацаанд төслийн үр шимийг хүртэгчдэд зориулан хэвлүүлэн тараасан материалын тоог дараах графикаар харууллаа.

### График 4.4.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудад төслөөс боловсруулж хэвлэсэн болон тараасан бүтээгдэхүүний тоо



Төслөөс хамтарсан баг болон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, бусад талуудад зориулж нийт 2000 хувь орчим материал хэвлэж, түгээсэн нь үр дүнгээ өгсөн байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт, хамтарсан баг болон хүмүүжлийн эерэг аргын DVD, хүмүүжлийн эерэг арга, хамтарсан багийн гишүүдэд зориулсан багц гарын авлага, хамтарсан багийн өнөөгийн байдал судалгааны тайлан зэрэг материалууд хүүхэд хамгааллын ажилтнуудын өдөр тутмын ажил үйлчилгээнд ашиглагдаж байна.

**Хүснэгт 4.4.4** Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудад төслөөс боловсруулсан материалыг түгээсэн байдал

Хамтран ажиллагч байгууллага, ажилтнууд	Хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа	Хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа - Монгол хэлээр	Хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа - Англи хэлээр	Хамтарсан багийн багц гарын авлага	Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт	Хамтарсан баг болон хүмүүжлийн эерэг арга DVD	Хүмүүжлийн эерэг арга гарын авлага	Нийт
Хамтарсан багийн сургагч багш нар	30			30	30	30		120
Хамтарсан багийн гарын авлагын багц					300			300
ГБХЗХГ/ аймгийн ГБХЗХГ	10	5	5	21	155	62		258
Нийслэлийн ГБХЗХГ	5	5	5	15	182	40		252
Төслийн удирдах зөвлөл	10	5	3	10				28
Төсөлд хамрагдсан 3 дүүргийн ГБХЗХХ	3	3	1			158		165
ЖАЙКА	2	3	1	3		2		11
ХИС-гийн архив	1	2	2		2	2		9
Бусад хурал, цуглаан		5	5					10
ХИС-гийн Хүүхэд хамгааллын арга зүйн төв	5	2	2	5	20			34
Судалгааны баг		5	5					10
Үндэсний ТББ	2	2	2	2	20			28
ХИС-гийн ажилтнууд		2	5					7
Бусад ОУБ			4					4
Боловсруулсан багш нар				8				8
ХНХЯ						40		40
БГД-ийн ГБХЗХХ						46		46
ХУД-ийн ГБХЗХХ						32		32
Хүмүүжлийн эерэг аргын сургалтын чиглүүлэгч нар							25	25

**Хүснэгт 4.4.5** Төсөлд хамрагдсан сум, баг, хороодод боловсруулсан материалыг түгээсэн байдал, байршлаар

Төслийн зорилтот баг, хороо	Хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа- дэлгэрэнгүй	Хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа - Монгол хэлээр	Хамтарсан багийн өнөөгийн байдал судалгаа - Англи хэлээр	Хамтарсан багийн багц гарын авлага	Хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт	Хамтарсан баг болон хүмүүжлийн эерэг арга DVD	Хүмүүжлийн эерэг арга гарын авлага	Нийт
Архангай аймгийн Батцэнгэл сум	16	2		10	12	5	26	71
Архангай аймгийн Хайрхан сум	16	2		10	12	5	26	71
Архангай аймгийн Эрдэнэбулган сум	16	2		11	13	5	26	73
БЗД-ийн 27-р хороо	16	2		22	24	5	26	95
БЗД-ийн 23-р хороо	16	2		21	23	5	26	93
ЧД-ийн 9-р хороо	16	2		23	25	5	26	97
ЧД-ийн 10-р хороо	16	2		27	29	5	26	105
СХД-ийн 2-р хороо	16	2		23	25	5	26	97
СХД-ийн 10-р хороо	16	2		25	27	5	26	101

Төслийн хүрээнд түгээсэн судалгааны тайлан, хамтарсан багийн багц гарын авлага, хамтарсан баг ба хүмүүжлийн эерэг арга DVD, хүмүүжлийн эерэг арга гарын авлага нь хүүхэд хамгааллын бүхий л оролцогч талуудын хувьд ойлголт мэдэг, мэдээлэл олж авах гол эх үүсвэр болжээ.

Төсөл хэрэгжсэн 3 жилийн хугацаанд хүмүүжлийн эерэг аргын сургагч багшаар бэлтгэх сургалтад төрийн байгууллагын төлөөлөл, зорилтот орон нутгийн хамтарсан багийн гишүүн нийт 25 хүн хамрагдсан байна.

**Хүснэгт 4.4.6** Хүмүүжлийн эерэг аргын сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан төрийн болон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтан, хамтарсан багийн гишүүдийн тоон мэдээлэл

Сонгосон үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо
ГБХЗХГ	1
Нийслэл, дүүргийн ГБХЗХХ	3
Хорооны хамтарсан багийн гишүүд	6
Архангай аймгийн хамтарсан багийн гишүүд	8
ХИС	7
<b>Нийт</b>	<b>25</b>

Хамтарсан багийн гишүүд хийгээд хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагуудын ажилтнууд шинэчилсэн сургалтын хөтөлбөр, агуулга бүхий хүмүүжлийн эерэг аргын 9 удаагийн сургалтад хамрагдсан нь үр дүнтэй болжээ. Судалгааны баримтаас үзэхэд нэг сургагч багшийг бэлтгэхэд 2-3 удаагийн сургалтад хамруулж, дараа нь үндэсний хэмжээний сургагч багш болох боломж олгодог байна. Үндэсний хэмжээний сургагч багшийн эрхийг Канадын Манитобагийн Их Сургуулиас өгдөг нь төслийн үр нөлөө, ач холбогдлыг нэмэгдүүлжээ. Экспертийн ярилцлагын дүнгээс үзэхэд бэлтгэгдсэн 25 сургагч багш, төсөлд хамрагдсан 9 нэгжийн хамтарсан багийн гишүүдэд хүрч сургалт зохион байгуулжээ. ХИС-гийн төслийн хүрээнд хүмүүжлийн эерэг аргын сургагч багш бэлтгэж, гарын авлагыг шинэчилсэн нь үр дүнтэй ажил болсныг судалгаанд хамрагдсан эцэг эх, хүүхэд, хамтарсан багийн гишүүд, хүүхдийн чиглэлээр ажилладаг төрийн байгууллагын ажилтнууд илэрхийллээ.

Төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулж бэлтгэхээс гадна хүүхдийн асуудал хариуцсан ГБХЗХГ, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнуудыг мөн хамруулан чадавхжуулсан байна. Түүнээс гадна сургууль, эмнэлэг, цагдаагийн байгууллага, ТББ-уудын зүгээс хамтарсан багт хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар мэдээлэх, сургалтаар олж авсан мэдлэгээ цааш түгээх байдлаар үүрэг хүлээн оролцдог, хамтран ажиллах замаар мэдлэг мэдээлэл, туршлага солилцох, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх зэрэг урьдач нөхцөл бүрэлдэн бий болоход төслийн үзүүлсэн үр нөлөөг тэмдэглэх нь зүйтэй.

#### **Шигтгээ 4.4.1 Төслийн хүрээнд хийгдсэн сургалтын үр нөлөө**

ХИС-гаас явуулсан хүмүүжлийн эерэг аргын сургалтад манай мэргэжилтнүүд нэлээн олон удаа хамрагдаж, цаашаа нэгжид ажилладаг хүүхэд хамгааллын чиглэлийн ажилтан, эцэг эхчүүдэд хүргэх зорилгоор сургалтыг явуулсан. Хүүхэд хамгааллын чиглэлээр Лантуун дохио зэрэг ТББ-тай ажилладаг.

*(Экспертийн ярилцлага, ЧД, ГБХЗХХ-ын мэргэжилтэн)*

Чадавх бэхжүүлэх сургалтыг хамтарсан багийн гишүүд, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтнууд, эцэг эх, хүүхдүүдэд зориулан явуулсан нь үр дүнд хүрч байна. Нэг сайн жишээ хэлэхэд Батцэнгэл сумын засаг дарга өөрөө сургалтад багаа авчирч, нэр нь ороогүй ч сургалтад сууж, энэ миний хийх ёстой ажил юм байна гэдгийг сайн ойлгож авч маш хариуцлагатай, оролцоотой хандсан.

*(Экспертийн ярилцлага, Архангай аймаг, хөтөлбөрийн мэргэжилтэн)*

## **ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ НЬ:**

### **СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

#### **5.1 БОДЛОГЫН ТӨВШИНД**

Төсөл хэрэгжиж эхлэх үетэй харьцуулахад Монгол Улсад хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд ихээхэн ахиц гарсан байна. Тухайлбал, 1) хүүхэд хамгааллын бие даасан хууль батлагдан гарсан, 2) хамтарсан баг болон түүний чиг үүргийн талаар тодорхойлсон, 3) дээрх хуулиудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн журмууд бий болсон зэргийг дурдаж болно.

Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах, дэмжих тогтолцооны хүрээнд мөн чухал алхмууд хийгджээ. Тухайлбал, “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл хэрэгжүүлэх зөвлөл, “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай салбар дундын ажлын хэсэг” болон “Хүүхдийн хөгжил, хамгааллын байнгын ажлын хэсэг” зэрэг бодлогын хэрэгжилтийг хангах бүтцүүд бий болсон байна.

“Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлснээр хамтарсан баг, хамтарсан багаас үйлчилгээ хүргэх бодлогын хөгжилд үлэмж хувь нэмрийг оруулсан байна. Ерөнхийдөө тус төслийн зорилго нь бодлого боловсруулах болон тогтолцоо бүрдүүлэх чиглэлд байсан гэж хэлж болно. Энэ нь хууль болон түүнийг дагалдан гарсан журмуудыг боловсруулах, батлах үйл явцад агуулгын хувьд ч, үйл явцын хувьд ч нөлөөллийн үүргээ сайн гүйцэтгэсэн байна. Түүнчлэн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх бүтэц байгуулагдахад ХИС нь олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл болохын хувьд тодорхой байр суурь эзэлж, үүргээ гүйцэтгэж ирсэн юм.

ХИС-гийн төслийн багаас хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг дэмжих, тухайлбал, хууль сурталчлан таниулах чиглэлд олон нийтэд нөлөөлөх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн хүүхэд хамгааллын холбогдох журмуудыг хэрэгжүүлэх хүрээнд сүүлийн хоёр жилд нээлттэй семинар, сургалт, тэмцээн болон бусад үйл ажиллагааг зохион байгуулж иржээ. Энэ нь хүүхэд хамгааллын салбарт баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд төрийн үүргийг орлох хүчин зүйл болж байна.

Хүүхэд хамгааллын бодлогын хийгээд тогтолцооны хүрээнд ихээхэн дэвшил гарсан ч өнөөдөр зарим асуудлууд байсаар байна. Өнөөгийн байдлаар Монгол улсад нэг талаас, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, нөгөө талаас “Хүүхэд хамгааллын” чиглэлд бие даасан хууль, эрх зүйн орчин бүрэлдсэн нь сайшаалтай болов ч, тэдгээрийн хэрэгжилтийг хангах бүтэц, тогтолцоо хийгээд дүрэм журмуудын уялдаа холбоог хангахад цаашид анхаарах шаардлага үүсч байна.

Хууль хэрэгжих үндсэн нэг нөхцөл болсон хамтарсан багийн санхүүжилтийн хүрээнд том дэвшил гарсан. Тодруулбал, кейс шийдвэрлэх зардлыг төсөвт тусган, орон нутгийн төвшинд хуваарилах болсон. Хэдийгээр хамтарсан багийн үйл ажиллагаанд зориулсан төсөв хөрөнгийн асуудалд ийнхүү дэвшил гарсан боловч түүнийг орон нутгийн төвшинд зориулалтын бусаар зарцуулах явдал гарсан байна.

Төрийн албаны тогтворгүй байдал нь хүүхэд хамгааллын бодлогыг үр нөлөөтэй, тууштай хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Хамтарсан багт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй аймаг, дүүргийн холбогдох хэлтсийн мэргэжилтнүүд, тэр дундаа хамтарсан багийн кейс менежер болсон нийгмийн ажилтны ажлын байрны тогтворгүй байдал анхаарал татахуйц хэмжээнд байгаа нь цаашид хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт, болон үйлчилгээ сайжрахад хамгийн том эрсдэлт хүчин зүйл юм.

Нийгмийн ажилтныг хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах тогтолцоо үгүйлэгдэж байна. Өнөөдрийн эрх зүйн орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхэд гэр бүлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл энэ чиг үүргийг хэрэгжүүлэхээр байгаа ч энэ дунд эзэнгүй орон зай үүссээр байгаа бөгөөд түүний багагүй хэсгийг олон улсын байгууллагууд орлон гүйцэтгэж байна.

Төслийн нэгжээс төлөвлөлт, тайлангийн нэгдсэн загвараар хангаж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн нь төслийн зорилтот хамтарсан багууд үйл ажиллагаагаа төлөвлөх, тайлагнах чадварт суралцах замаар багийн зохион байгуулалтаа сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн байна.

Хамтарсан багийн гишүүдийн хурал, уулзалт тогтмолжих зэргээр төслийн зорилтот хамтарсан багийн зохион байгуулалт жигдэрч, харьцангуй тогтвортой үйл ажиллагаа явуулах болжээ. Үүнд хууль, эрх зүйн орчин, төрийн үйлчилгээний бүтцэд гарсан өөрчлөлт басхүү нөлөө үзүүлсэн байна.

Төслийн зүгээс хамтарсан багийн гишүүдийн үүрэг биелүүлэх чадавхыг дэмжих, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарсны үр дүнд төслийн зорилтот хамтарсан багийн гишүүдийн үүрэг биелүүлэлт, оролцоо, гишүүдийн хоорондын хамтын ажиллагаанд мэдэгдэхүйц дэвшил гаргасан байна. Гэхдээ хамтарсан багийн гишүүдийн оролцоонд гишүүдийн тогтвор суурьшилтай ажиллах баталгаа хангагдаагүй, ажлын байрны тодорхойлолтод хамтарсан багийн үүргийг тусгаагүй зэрэг нь саад учруулж байна.

Төслийн өмнөх суурь судалгаагаар хамтарсан багийн ахлагч нь хэн болох, удирдах, зохион байгуулах үүргийг хэн хариуцах асуудал тавигдаж байсан бол төсөл хэрэгжсэн хамтарсан баг дахь багийн ахлагчийн оролцоо, үүрэг, санаачилга нь өссөнөөр орон нутгийн шийдвэр гаргагчдад нөлөөлөх, төсөв санхүүгийн тодорхой дэмжлэг авч чадахад хүрсэн байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хамтарсан багийн ажиллах журмыг батлан гаргаснаар хамтарсан багийн ажиллах эрх зүйн орчин бүрдэж, улмаар гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгосон нь эерэг нөлөө үзүүлсэн бөгөөд хөтөлбөрөөс хууль, журмуудыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан нь бүхий л оролцогч талуудын чиг үүргийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны хөрс суурийг бий болгож чадсан байна.

Төсөл хэрэгжиж эхлэх үеийн нэг анхаарал татсан нөхцөл байдал бол салбар дундын зохицуулалт байхгүй байсан явдал юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхдийн эрх болон хамгааллын асуудалд оролцогч талуудын чиг үүргийг тодорхойлсон байна. Түүнчлэн хамтарсан багийн үйлчилгээнд чухал ач холбогдолтой бүтэц болох салбар дундын ажлын хэсэг байгуулагдсан юм. Гэсэн хэдий ч салбар дундын зохицуулалт нь хамтарсан багийн түвшинд биеллээ олоход асуудал тулгарсаар байна. Бодлого хийгээд бүтцийн төвшинд чухал алхмууд бий болсон ч хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгах явдал жигд биш байна.

### ***Дээрх дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.***

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон хүүхэд хамгааллын бодлогын хоорондын уялдаа холбоог хангах, түүнчлэн эдгээр бодлогын хэрэгжилтийг хангах төрийн байгууллагын бүтэц, тогтолцооны хоорондын уялдаа холбоо, харилцааг сайжруулах;
- Хамтарсан багийн үйлчилгээний зардлын хуваарилалт, ашиглалт, хамтарсан багийн гишүүдийн урамшууллыг тусгай журмаар зохицуулж өгөх;
- Хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод “Хүүхэд хамгаалал”-ын чиг үүргийг тусгасан үндэсний хэмжээний ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг гаргах;
- Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээнд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх;
- Хүүхэд хамгааллын чиг үүрэг хүлээгчтэй байгуулах “Нууцлалын гэрээ”-ний загварыг боловсруулан батлах;
- Хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг, ажлын ачааллын судалгааг хийж, гишүүдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох;
- Хамтарсан багийн гишүүдийн үр дүнгийн гэрээнд хамтарсан багийн хүүхэд хамгааллын чиг үүргийг тусгаж өгөх;
- Засаг захиргааны анхан шатны нэгжид гэр бүл, хүүхэд хамгааллын ажилтны орон тоог нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн хүн амын хэмжээг харгалзан бий болгох;
- Хамтарсан багийн гишүүдийг мэргэжил, аргагүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий албан тушаалтныг хүүхэд гэр бүл, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагад бий болгох, төрийн бус байгууллагуудыг энэ чиглэлд



бэлтгэн, гэрээлэн гүйцэтгүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

- Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн үеийн үйлчилгээний дэд бүтэц болох түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн нийгэм, сэтгэлзүйн болон эрхзүйн үйлчилгээний төв байгуулах;
- Төрийн байгууллагын болон орон нутгийн удирдах албан тушаалтнуудын үр дүнгийн гэрээнд хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих асуудлыг тусгах, түүнд саад учруулсан тохиолдолд тухайн удирдах ажилтанд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх;
- Хүүхэд хамгааллын сургалтад төрийн байгууллагын болон орон нутгийн удирдах албан тушаалтнуудыг заавал хамруулах асуудлыг журмаар зохицуулах;

## 5.2 ОРОН НУТГИЙН ТӨВШИНД

Орон нутгийн төвшинд хамтарсан багийн эрх хэмжээ хангалтгүй хэвээр байгаа нь энэ түвшинд хүүхэд хамгааллын засаглал сул байгааг харуулж байна. Нутгийн захиргааны болон орон нутаг дахь төрийн бусад байгууллагын удирдлагын төвшинд хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, түүнд өгөх ач холбогдол доогуур байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд хамтарсан багийг байгуулах үйл ажиллагаанд нь хяналт тавих нутгийн өөрийн удирдлагын байгууллага, хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангах засаг даргын чиг үүрэг болон хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих орон нутгийн хүүхдийн төлөө зөвлөлийн чиг үүргүүд жигд бус, хангалтгүй хэрэгжиж байна.

Орон нутгийн төвшинд хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх нэгдсэн удирдамж, стандарт бий болсон нь хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд чухал түлхэц болжээ. Гэвч нутгийн удирдлагын манлайлал, төрийн албаны халаа сэлгээ, төсөв санхүү, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар зэрэг орон нутгийн шинжтэй хүчин зүйлээс хамаарч хамтарсан багийн үйл ажиллагааны төвшин харилцан адилгүй байна.

Хүүхэд хамгааллын эрх зүйн орчин бүрдэж, холбогдох дүрэм журмууд бий болсон нь хамтарсан багийн гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгож, хамтарсан баг дахь гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудлаар хамтарсан багаар ажиллаж, шийдвэр гаргадаг болоход нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэвч судалгаанд хамрагдсан хамтарсан багуудын олонход гишүүдийн чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгаагүй байна.

Төсөл хэрэгжсэнээр хамтарсан багийн гишүүдийг мэргэжил, арга зүйн хувьд ихээхэн дэмжсэн нь харагдаж байна. Сургалтаас гадна орон нутагт төсөл хариуцсан ажилтан ажиллуулж, ажлын байранд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн нь онцгой нөлөө үзүүлжээ. Гэвч төсөл хэрэгжээгүй орон нутагт нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагын үйлчилгээ нэн дутмаг байна. Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь хуулиар тодорхойлсон энэ чиг үүргээ хэрэгжүүлэх чадамж муу байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар сум, дүүрэг, баг, хорооны засаг дарга нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүрэгтэй боловч түүний хэрэгжилт нь орон нутгийн төвшинд хангагдахгүй байна.

Зарим орон нутагт тодорхой хэмжээний төсвийг хамтарсан багийн үйл ажиллагаанд зориулан төлөвлөж, шийдвэрлэсэн байна. Гэвч судалгаа явагдсан бусад талбарт ийм туршлага байхгүй байна. Одоогийн туршлагаар орон нутаг хамтарсан багт төсөв хуваарилах явдал нь а) хамтарсан багийн гишүүдээс нутгийн өөрөө удирдах байгууллагад төлөөлөгч байх, б) хамтарсан багийн удирдлага, хамтарсан багаас нутгийн удирдлагад нөлөөлөх чадвар зэргээр нөхцөлдөж байна.

Төсөл хэрэгжсэнээр хурал тогтмолжиж, тайлагналт, гишүүдийн оролцоо, чиг үүргийн хэрэгжилт сайжирсан байна. Хууль, эрхзүйн орчин, төрийн үйлчилгээний бүтцэд өөрчлөлт гарсан нь аль ч хамтарсан багийн хурлын тогтворжилтод эерэг түлхэц болсон байна. Гэвч хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт орон нутагт жигд биш ба тухайн аймаг, дүүргийн хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын удирдлага, хяналтаас хамаарч харилцан адилгүй хэрэгжиж байна.

Хүүхэд хамгааллын чиг үүрэг хүлээгчдийн дунд нууцлал алдах тохиолдол гарч байсан тухай суурь судалгаагаар хөндөгдөж байсан бол төслийн зорилтот хамтарсан багуудад уг асуудлыг “Нууцлалын гэрээ” (нууц хадгалах гэрээ) байгуулах замаар шийдсэн нь оновчтой болжээ.

Төслийн зорилтот хамтарсан багуудын хооронд туршлага судлах боломжийг олгосон нь хамтарсан баг хоорондын хамтын ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна. Ерөнхийдөө хамтарсан багуудын хооронд туршлага солилцох, нийгмийн сүлжээ үүсгэх хэрэгцээ шаардлага өндөр байгаа нь харагдаж байна.

### ***Дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.***

- Орон нутгийн төвшин дэх хүүхэд хамгааллын засаглалыг сайжруулах, орон нутгийн хүүхдийн төлөө зөвлөл, нутгийн өөрийн удирдлагын байгууллага, нутгийн захиргаа зэрэг институцийн хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлэх хэрэгтэй;
- Орон нутагт байгаа төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтны үр дүнгийн гэрээнд хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд хүүхэд хамгааллын чиг үүргийг тусгах;
- Орон нутгийн төсвийн төлөвлөлтөд хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг тусгаж буй өнөөгийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, энэ чиглэлээр бодлогын удирдамж, зөвлөмж боловсруулж нутгийн өөрийн удирдлагын байгууллагад нөлөөллийн ажил явуулах;
- Орон нутгийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын мэдлэг, ойлголт, хандлагад нөлөөлөх;
- Орон нутгийн хүүхэд гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага нутгийн өөрийн удирдлагын байгууллагатай зөвшилцөн хүүхдийн асуудал хариуцсан ажилтан ажиллуулж болох талаар хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

- Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн үеийн үйлчилгээний дэд бүтэц болох түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн болон эрх зүйн үйлчилгээний төв байгуулах чиглэлээр орон нутаг санаачилгатай ажиллах;
- Орон нутгийн төвшинд хамтарсан баг хооронд туршлага судлах, хамтран ажиллах, зөвлөлдөх нөхцөлийг бүрдүүлэх;
- Орон нутгаас хамтарсан багийн олон нийтэд хандсан үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлдэг байх, тухайлбал сургалт, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд шаардлагатай байр танхим, тээвэрлэлт гэх мэт.

## 5.3 ХАМТАРСАН БАГИЙН ТӨВШИНД

### 5.3.1 Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварын хүрээнд

Хамтарсан багаар ажиллах аргазүйн сургалтыг зөвхөн хамтарсан багийн гишүүд төдийгүй хэсгийн ахлагч, эцэг эх, сургуулийн багш нар, шийдвэр гаргах төвшний удирдлагууд зэрэг бүх төвшинд явуулснаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааны ерөнхий ойлголт, мэдлэгийн төвшин дээшилсэн байна.

Хамтарсан багийн гишүүд кейс бүртгэл нээх, төлөвлөгөөний дагуу ажиллах, хаах зэрэг үйл ажиллагаанд хамтарч ажиллах үндэс суурь нэгэнтээ тавигдсан байна.

Хамтарсан багийн гишүүдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ур чадвар олгох сургалтыг анхан болон гүнзгийрүүлсэн хэлбэрээр явуулсан нь хамтарсан багийн үйл ажиллагаанд зохих үр дүнгээ өгсөн байна.

Хамтарсан багийн гишүүдэд шаардлагатай ур чадвар бий болж, хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарсан тохиолдолд хамтарсан баг чухамхүү ямар хариу үйлдэл хийх, хэнд хандах, нэн тэргүүнд яаралтай тусламж үйлчилгээг хэрхэн хүргэх, кейс нээх, хаах, төлөвлөгөөний дагуу үйлчилгээ үзүүлэх тал дээр төслийн зорилтот болон хяналтын бүлгийн хувьд аль аль нь хамтран ажиллах туршлага хуримтлуулсан байна.

Хамтарсан багийн мэдлэг, ур чадварын төвшин нэмэгдэхэд зөвхөн сургалт төдийгүй орон нутагт төсөл хариуцсан ажилтан ажиллуулж, ажлын байранд мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч ажиллуулсан нь онцгой нөлөө үзүүлжээ.

Цаашид хамтарсан багаар ажиллах, хамтарсан багийн өмнө үүрэг хүлээх, багт гүйцэтгэх өөрийн байр суурь, үүргээ ухамсарлах, багийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх явцдаа ажлын байран дээр дэмжлэг зөвлөгөө авах нь төслийн үр дүнг бусад талбарт хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөөлөх болно.

Цаашид хамтарсан багийн мэдлэг, ур чадварын одоогийн хүрсэн төвшинг хадгалан байнгын

тогтмол сургалтад тулгуурлан хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, улмаар үйл ажиллагааг тогтмолжуулж, сайжруулах хэрэгтэй юм.

### **Дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.**

- Хүүхэд хамгааллын ажилтнуудын хувьд хийнгээ сурах, сурангаа хийх зарчмыг нэвтрүүлэх нь ихээхэн үр дүнтэй байгааг харгалзан мэргэжил, аргагүйн дэмжлэгийг ажлын байран дээр нь үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх;
- Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг гишүүн тус бүрийн ажлын байрны чиг үүрэг, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулах;
- Хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын агуулгад кейс нээх, кейс төлөвлөгөө боловсруулах, багаар ажиллах, шийдвэр гаргах, үйлчилгээ үзүүлэх, кейс менежмент ба үйлчилгээг удирдан зохицуулах, кейс хаах зэрэг сэдвийг тусган, бодит жишээ баримтад тулгуурлан сургалтыг явуулах;
- Хамтарсан багийг чадавхжуулах сургалтаас гишүүдийн мэдлэг, ур чадвар, хандлагын үр нөлөөг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах,

### **5.3.2 Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд**

Төсөл эхлэхийн өмнө хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийг хэсгийн ахлагч, олон нийтийн мэдээлэл, хүүхдийн тусламжийн 108 утас болон цагдаагийн дуудлага дээр суурилж авч байсан бол төсөл хэрэгжсэний дараа мэдээллийг ихэвчлэн хэсгийн ахлагч нар, хүүхдийн тусламжийн 108 утас, цагдаагийн дуудлага, ялангуяа хамтарсан багийн гишүүд өөрсдийн үйл ажиллагаагаар дамжуулан илрүүлэх байдал зонхилох болсон байна.

Төслийн зорилтот хамтарсан баг эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдийн хувьд 2015 онд 54 хүүхэд, 2016 онд 450 хүүхэд, 2017 онд 525 хүүхэд, хяналтын хамтарсан баг 2015 онд 10 хүүхэд, 2016 онд 214 хүүхэд, 2017 онд 485 хүүхэд тус тус илрүүлснээс харахад ХИС-гаас хэрэгжүүлсэн төслийн үр дүнд хамгаалуулах шаардлагатай хүүхдүүдийг илрүүлэх үйл ажиллагаа сайжирсан байна.

Төсөл хэрэгжихийн өмнө хамтарсан багуудын 40% орчим нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягт байгаа эсэхийг мэдэхгүй, огт маягт ашигладаггүй, эсвэл зөвхөн нөхцөл байдлын үнэлгээний маягт, хүүхдийн эрсдэлийн маягт зэрэг 4-5 маягтын хүрээнд ажилладаг байсан бол төслийн хүрээнд боловсруулсан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягтыг боловсруулан, практикт нэвтрүүлснээр зорилтот хамтарсан багийн 95% нь маягтуудыг бөглөх ур чадвар нэмэгдсэн гэж үзжээ.

Суурь судалгааны үр дүнгээс харахад кейстэй ажиллах арга барил дутмаг, кейсийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй, кейс нээх, ажиллах, үнэлэх, хаах зэрэг үйлчилгээний үе шат, дарааллын мэдлэг байхгүй талаар хамтарсан багийн гишүүд илэрхийлжээ. Хамтарсан багт ирсэн мэдээлэл, дуудлага бүрийг нөхцөл байдлын болон эрсдэлийн үнэлгээ хийхгүйгээр шууд кейс гэж үзэх хандлага түгээмэл байсан бол төсөл хэрэгжсэний дараа зорилтот хамтарсан багийн хувьд кейс дээр ажиллах байдал 2 дахин нэмэгдэн, гишүүдийн кейсийн талаарх ойлголт мэдлэг дээшлэн, кейс дээр ажиллах туршлагатай болсон байна.

Хамтарсан багийн үйлчилгээний чанар сайжирсан гэж зорилтот хамтарсан багийн гишүүдийн 60,9% нь хариулсан бол хяналтын хамтарсан багийн гишүүдийн хариулт 2 дахин бага байна. Энэ нь нэг талаас хамтарсан багийн үйлчилгээг хүргэх багийн гишүүдийн ур чадвар нэмэгдсэн, нөгөө талаас удирдлагын зүгээс хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг ойлгох, дэмжих явдал сайжирсантай холбоотой ба ийнхүү сайжирсныг зорилтот хамтарсан багууд төслийн хэрэгжилтийн үр өгөөжтэй холбон тайлбарлаж байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах, нөхөн сэргээхэд чиглэсэн байгууллага, тусламж үйлчилгээнүүдийн талаар зарим хяналтын хамтарсан багийн гишүүдэд мэдээлэл хомс байгаагаас хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ удаашрах, орхигдох явдал байсаар байна.

### **Дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.**

- Хамтарсан багуудад нийгмийн ажлын, сэтгэл зүйн болон эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хаяг, байршил, холбогдох утас, үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүртээмжтэй байлгах;
- Хамтарсан багаас хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хамтарсан багийн гишүүдийг урьдчилан сэргийлэх үйлчилгээний арга зүй, ур чадварт сургах чиглэлээр чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллах;
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, бүртгэх, маягт хөтлөх, үйлчилгээ үзүүлэхэд хамтарсан багийн гишүүд харилцан адилгүй байгаа учраас ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээг зохион байгуулах;
- Кейс менежментийн үйлчилгээг сайжруулах, байгууллага хоорондын үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах, нөхөн сэргээхэд чиглэсэн байгууллагуудын хүрээнд нийгмийн сүлжээний ажил явуулах, сүлжээ бүрдүүлэх;
- Хамтарсан баг ачаалалтай ажилладаг хороон дээр нийгмийн ажлын мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг сайн дурын ажилтнаар ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх боломжийг судлах;
- Хамтарсан багийн гишүүдийг ажил үүрэгтэй холбоотой сэтгэл зүйн гэмтэл, ажлын байрны халшралаас урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх арга зүйд сургах;
- Хамтарсан багийн гишүүд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэхдээ тухай бүрдээ нууцыг хадгалах гэрээ байгуулах;
- Хамтарсан багийн гишүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхыг дээшлүүлэх, нийгмийн ажилтны өөрийн үнэлгээний аргачлалд суралцах;

### **5.3.3 Хамтарсан багаас олон нийтэд хандсан үйл ажиллагааны хүрээнд**

Зорилтот орон нутгийн эцэг эхчүүдийн 63.8%, хүүхдүүдийн 52.9% хамтарсан багийн тухай ойлголт, мэдээлэлтэй болсон, зорилтот бүлгийн эцэг эхчүүдийн 83.6%, хүүхдүүдийн 63.8% нь хамтарсан багт хүүхэд хамгааллын асуудлаар хандах ойлголт мэдлэгтэй байгаа бөгөөд энэ нь төсөл хэрэгжихийн өмнөх үетэй харьцуулахад эрс дээшилсэн үзүүлэлт бөгөөд төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжсэнийг харуулж байна.

Эцэг эхчүүдийн хүүхдээ хүмүүжүүлэх эерэг аргын талаарх ойлголт мэдлэг дээшилж, хүүхдийн хүмүүжлийн асуудалд хүмүүжлийн эерэг аргуудыг хэрэглэх болсон нь харагдаж байна. Ялангуяа төслийн зорилтот бүлгийн эцэг эхчүүдийн 87.8% нь хүмүүжлийн дээрх аргын талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг сургалтаар дамжуулан олж авсан байна.

Зарим зорилтот орон нутагт эцэг эхчүүдийн дунд хамтарсан багаас зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа нь орон нутгийн бусад эцэг эхчүүд, олон нийтийн гишүүдийн хандлага, зан үйлийг өөрчлөх, нөлөөлөх байдлаар түгэн дэлгэрсэн туршлага бий болжээ. Үүнд хамаарах сайн туршлагауд нь цаашид төслийн үр нөлөө, үр дүн удаан хугацаанд хадгалагдах нөхцөлийг бүрдүүлжээ. Эцэг эхчүүдийн хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэдтэйгээ харилцах арга барилд өөрчлөлт гарч, хүмүүжлийн эерэг аргын хэрэглээ нэмэгдсэнийг эцэг эхийн судалгааны үр дүнгээс гадна хүүхдүүдийн дунд явуулсан асуулгын үр дүн харуулж байгаа юм.

Зарим эцэг эхийн зүгээс ажилтай, завгүй зэрэг шалтгаан тоочин сургалтад хамрагдахаас төвөгшөөдөг, хамтарсан багуудад сургалт зохион байгуулах байр танхимын олдоц, зай талбайн хүртээмж, орчин нөхцөл, сургалтын зардал зэрэг материаллаг орчин, төсөв санхүүжилттэй холбоотой бэрхшээл тулгардаг байна. Эдгээр асуудлыг шийдсэн тохиолдолд энэхүү эрэлт хэрэгцээтэй сургалт тогтвортой үргэлжилж, урт хугацаанд үр нөлөөгөө үзүүлнэ. Дээр дурдсанчлан эцэг эх болон бусад оролцогч талуудыг оролцуулан зохион байгуулсан хүмүүжлийн эерэг аргын сургалтыг үргэлжлүүлэн явуулах хэрэгцээ, энэхүү сургалтад хамрагдах хүлээлт өндөр байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой байна.

Хүмүүжлийн эерэг арга хэмээх энэхүү ач холбогдол өндөртэй сургалтыг цааш нь үргэлжлүүлэхдээ ялангуяа баг, хорооны хамтарсан багийн бүтцээр явуулахад төсөв санхүүжилт, сургалтын материаллаг орчныг шийдвэрлэх тал дээр зарим орон нутагт бий болсон сайн туршлагыг онцлон авч үзэж болохоор байна.

Хүүхдүүд хамтарсан багийн талаар мэдээлэл авч буй гол эх сурвалжууд нь нийгмийн ажилтан, сургууль, эцэг эх, багш болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байна. Ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг өссөн байдал 2018 оны судалгааны дүнгээс харагдаж байна.

### ***Дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.***

- Хүмүүжлийн эерэг аргын сургалт хамгийн үр нөлөөтэй үйл ажиллагаа болж байгааг харгалзан энэ чиглэлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, үйлчилгээг улам бүр боловсронгуй болгох талаар анхаарах;
- Хамтарсан багийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд сайн дурын эцэг эхчүүдийг хүмүүжлийн эерэг аргын сургалтад хамруулж олон нийтийн идэвхжүүлэгчээр бэлтгэн, цаашид сургалтыг тэдэнд тулгуурлан өргөжүүлэх;

- Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд нийтийн эзэмшлийн гудамж талбай, байр зэрэг нутаг дэвсгэрийн болон бусад нийгмийн сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг үр бүтээлтэй ашиглах;
- Олон нийтэд чиглэсэн хүмүүжлийн зэрэг аргын сургалтын зар мэдээллийг илүү хүртээмжтэй болгохын тулд өрх гэрээр мэдээлэл хүргэх, сургалтыг үр өгөөжтэй болгохын тулд эцэг эхчүүдийн амралтын өдөр, чөлөөт цагаар явуулах;
- Баг, хорооны төвшинд нутаг дэвсгэрийн хүн ам, зорилтот бүлгээс хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, хэрэгцээг тодорхойлон хамтарсан багийн олон нийтэд хандсан үйл ажиллагаанд тусгах;
- Одоогийн хүрсэн төвшин, амжилтад тулгуурлан хамтарсан багийн сургалтыг цаашид төсөл хэрэгжүүлэх орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжилтэн, хамтарсан багийн гишүүдийн оролцоотойгоор системтэй явуулах.



**Save the Children**

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ [secretary@savethechildren.mn](mailto:secretary@savethechildren.mn)

🌐 [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

© Гэрэл зургуудын эрхийг Хүүхдийг Ивээх Сан эзэмшинэ.